




НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2040)



УЛААНБААТАР ХОТ
2026 он

БАТАЛСАН:
“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ПАРК” ХК-ИЙН ТҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР

**НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ПАРКИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(2025-2040)**

ТАНИЛЦСАН:

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ПАРКИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН НЭГЖИЙН
ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ,
ЗӨВЛӨМЖ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.МЭНДБАЯР

ХЯНАСАН:

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.ЭНХСАЙХАН

ШИНЖЭЭЧИД:

ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР
ДОКТОР, ПРОФЕССОР



Д.МӨНХБАЯР

Д.ОЮУНЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН УДИРДАГЧ БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР, МОНГОЛ УЛСЫН
МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР
АЖ ҮЙЛДВЭРИЙН ИНЖЕНЕР-ЭДИЙН ЗАСАГЧ,
ДОКТОР (Ph.D), ПРОФ, МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ
ЭДИЙН ЗАСАГЧ
БИЗНЕСИЙН ЭДИЙ ЗАСАГЧ, БИЗНЕСИЙН
УДИРДЛАГЫН ДОКТОР (Ph.D)
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГЧ, БИЗНЕСИЙН
УДИРДЛАГЫН МАГИСТР
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МЕНЕЖМЕНТ, БИЗНЕСИЙН
УДИРДЛАГЫН МАГИСТР



М.БУРМАА

С.ТӨГС

Б.БАТТУЛГА

Ц.БАТХУЯГ

Ц.МӨНХСҮХ



ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт, зарим нэр томъёоны тайлбар.....	4
УДИРТГАЛ.....	6
БҮЛЭГ I. “НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ийн ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ЗОРИЛТУУД.....	9
1.1. Алсын хараа, эрхэм зорилго, үндсэн үнэт зүйлс.....	9
1.2. Хөгжлийн стратеги.....	11
1.3. Стратегийн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.....	12
Урт хугацааны стратеги (2030–2040).....	12
Дунд хугацааны стратеги (2025–2030).....	41
БҮЛЭГ II. МЕНЕЖМЕНТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТҮНШЛЭЛИЙН ЗАГВАР.....	57
2.1. “Налайхын ҮТП”-ийн ҮТП-ийн бүтэц, засаглалын хувилбар.....	57
2.2. Налайхын ҮТП-ийн кластерийн зохион байгуулалт, менежментээр хангах бодлого.....	64
2.3. Санхүүжилтийн бүтэц, загварчлал.....	75
2.3.1 Налайхын ҮТП-д шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ.....	75
2.3.2. НҮТП-ийн нэгжүүдээс паркийн хураамжаар орлого бүрдүүлэх, санхүүжилт авах загвар.....	76
2.3.3. НҮТП-ийн Хураамжийн Орлогын Тооцоолол.....	78
2.3.4. Паркийн үйл ажиллагааны зардлын төсөв, ирээдүйн төсөөлөл.....	85
2.3.5. Хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ.....	87
2.4. Хөрөнгө оруулалтын боломжууд, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	89
2.5. НҮТП-ийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	100
БҮЛЭГ III. ҮТП-ийн ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.....	105
БҮЛЭГ IV. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, МОНИТОРИНГ.....	110
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ.....	114



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ, ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
ДБТС	Дэд Бүтцийн Төвлөрсөн Систем
ЕАЭЗХН	Евроазийн эдийн засгийн хамтын нийгэмлэг
НҮТП	Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ҮТП	Үйлдвэрлэл технологийн парк
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХК	Хувьцаат компани
ХТЗ	Хөгжлийн төлөвлөлтийн зөвлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

ADB Climate Fund - *Asian Development Bank Climate Fund(s)* — Азийн хөгжлийн банкны уур амьсгалын сан, уур амьсгалын санхүүжилтийн хэрэгслүүд

АНК - *Auslandshandelskammern (German Chambers of Commerce Abroad)* — Германы Гадаад худалдааны танхимууд

АРЕС - *Asia-Pacific Economic Cooperation* — Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа

ASEAN - *Association of Southeast Asian Nations* — Зүүн Өмнөд Азийн Улсуудын Холбоо

ASTM – *American Society for Testing and Material* — Америкийн Туршилт ба Материалын Нийгэмлэг

ССС - *China Compulsory Certification* — БНХАУ-ын заавал мөрдөх бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын тохирлын гэрчилгээ

СЕ - *Conformité Européenne* — Европын стандартад нийцсэн бүтээгдэхүүнд олгодог тохирлын тэмдэг

ЕАС - *Eurasian Conformity* — Евроазийн эдийн засгийн холбооны (ЕАЭЗХ) стандарт, техникийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний тэмдэг

ERP - *Enterprise Resource Planning*

GCF - *Green Climate Fund* — Уур амьсгалын ногоон сан

GEF - *Global Environment Facility* — Дэлхийн байгаль орчны сан

IASP - *International Association of Science Parks and Areas of Innovation* — Олон улсын Шинжлэх ухаан, инновацын паркуудын холбоо



IoT - Internet of Things — Зүйлсийн интернэт (холбогдсон төхөөрөмжүүдийн ухаалаг сүлжээ)

ISO - International Organization for Standardization — Олон улсын стандартчиллын байгууллага

JCM - *Joint Crediting Mechanism* — Хамтарсан кредитжүүлэлтийн механизм (голдуу Япон улстай хэрэгжүүлдэг хүлэмжийн хийн бууралтыг хамтран тооцох механизм)

MoU Memorandum of Understanding — Харилцан ойлголцлын санамж бичиг

R&D - Research and Development — Судалгаа ба хөгжүүлэлт

Smart Parks Network олон улсын сүлжээ

TRL – Technology Readiness Level

Factor-driven – хүчин зүйлсийн удирдлагатай. Үйлдвэрлэл, өсөлт нь голчлон *байгалийн нөөц, хөдөлмөрийн хямд өртөг, анхан шатны хүчин зүйлс*-ээс хамаардаг эдийн засгийн загвар. Инновац, технологийн бүтээмж өндөр биш, бүтэц шилжилтийн эхэн үе шаттай улсуудад хамаарна.

Innovation-driven – инновац удирдлагатай. Эдийн засгийн хөгжлийн дээд шат бөгөөд өсөлт нь *шинэ технологи, судалгаа-хөгжүүлэлт (R&D), өндөр нэмүү өртөг бүхий инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ*-ээр бий болдог тогтолцоо.

Финтек – санхүүгийн технологи. Санхүүгийн үйлчилгээг *дижитал технологи, хиймэл оюун, блокчейн, өгөгдлийн автоматжуулалт*-аар шинэчилж, илүү хурдан, хямд, хүртээмжтэй болгох шийдлүүдийг хэлнэ. Жишээ: цахим төлбөр, дижитал банк, P2P зээл, крипто, ухаалаг гэрээ гэх мэт.

Zero Waste Park - Тэг хог хаягдалтай парк. Үйлдвэрлэл, хэрэглээний бүх шатанд *хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах, эрчим хүч гарган ашиглах* зарчмаар “тэг хаягдал”-ын зорилготой паркийн менежментийн загвар. Хаягдал хаягдахгүй, нөөцийн үр ашиг хамгийн өндөр түвшинд хүрэх экосистем.

Питч эвент - хөрөнгө оруулагчдад танилцуулах арга хэмжээ. Гарааны бизнес, инновацын багууд богино хугацаанд (жишээ нь 3–5 минут) *бизнес санаа, бүтээгдэхүүн, санхүүгийн загвараа* хөрөнгө оруулагч, менторуудад танилцуулдаг уралдаант арга хэмжээ.

Стартап - гарааны бизнес. Түргэн өсөлтөд чиглэсэн, инновацад суурилсан, тодорхойгүй орчинд бизнесийн шинэ загвар, технологи туршдаг *шинэ компани*. Хурдтай масштаблах, өндөр өсөлт, хөрөнгө оруулалт татах чадвараараа ялгардаг.



УДИРТГАЛ

Монгол Улс урт, дунд хугацаанд эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүсчилсэн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилтыг төрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн суурь баримт бичгүүддээ шат дараатайгаар тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал, “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд аж үйлдвэрийн болон үйлдвэрлэл, технологийн паркуудыг бүсчилсэн байдлаар хөгжүүлэх, импортыг орлох болон экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих нь улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах гол хөшүүрэг болохыг тодорхойлсон. Энэхүү бодлогын хүрээнд Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн шинэ тэнхлэгийг бүрдүүлэх, хотын төвлөрлийг сааруулах зорилготойгоор Налайх дүүрэгт Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, хөгжүүлэх чиглэл баримтлагдаж байна.

Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк нь нийслэлийн зүүн бүсэд байршилтай, барилгын материалын үйлдвэрлэлд тулгуурласан, цаашид үйлдвэрлэл-логистик-худалдааны нэгдсэн кластер болон хөгжих стратегийн ач холбогдол бүхий төсөл юм. Улаанбаатар хотын барилга, дэд бүтцийн салбарын эрчимтэй өсөлт, барилгын материалын импортын хараат байдлыг бууруулах бодлогын шаардлага, дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтууд нь уг паркийг үе шаттайгаар хөгжүүлэх бодит хэрэгцээ, зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Үүнтэй уялдан Налайх дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, тогтвортой ажлын байр бий болгох, дагуул хотын хөгжлийг хурдасгах суурь нөхцөл нь НҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг цогцоор нь шинэчлэн боловсруулах үндэслэл болж байна.

Энэхүү “Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк (2025–2040)-ийн Хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулахдаа Монгол Улсын “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, “Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль”, мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 тоот тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-д нийцүүлэн боловсруулсан болно. Төлөвлөгөө нь алсын хараа, стратегийн зорилго, хэрэгжилтийн үе шат, санхүүжилт, засаглал, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог цогцоор нь хамарсан стратегийн баримт бичиг байхаар төлөвлөгдсөн.

Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах явцад Налайхын ҮТП-тэй холбоотой өмнө хийгдсэн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүд (120 га, 130 га), байгаль орчны суурь судалгаа, улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын баримт бичгүүд, мөн Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, суурь судалгаанууд-ыг үндэслэл болгож ашиглав. Түүнчлэн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй болон төлөвлөгдөж буй стратегийн ач холбогдол бүхий төслүүдтэй уялдах асуудлыг тусгайлан авч үзсэн.

Энэ хүрээнд Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийг Налайх дүүрэгт байгуулагдаж буй “Налуу-Ухаа” эдийн засгийн тусгай бүстэй харилцан уялдсан байдлаар хөгжүүлэх стратегийн шийдлийг тусгасан болно. “Налуу-Ухаа” эдийн засгийн тусгай бүс нь олон улсын тээвэр, логистик, худалдаа, үйлчилгээний цогц зангилаа болон хөгжих зорилготой бөгөөд Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк нь тус бүсийн үйлдвэрлэлийн бодит агуулга, бүтээгдэхүүний урсгалыг бүрдүүлэх үндсэн цөм болж төлөвлөгдөж байна. Ингэснээр үйлдвэрлэл-тээвэр-гааль-худалдааны өртгийн гинжин хэлхээ нэг дор



бүрэлдэж, нийслэл болон улсын хэмжээнд стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрлэл, логистикийн шинэ тэнхлэг бий болох нөхцөл бүрдэнэ.

Мөн Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк болон “Налуу-Ухаа” эдийн засгийн тусгай бүс нь нийслэлийн бодлого, удирдлагын нэг мандатын хүрээнд, төр-хувийн хэвшлийн түншлэлд (PPP) суурилсан санхүүжилт, бүтээн байгуулалтын загвараар хэрэгжих боломжтой байгаа нь дэд бүтэц, хөрөнгө оруулалт, хөгжлийн үе шатыг уялдуулах бодит суурь нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, давхардлыг бууруулах, нэгдсэн засаглал, зохион байгуулалтын шийдлийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хөгжлийн төлөвлөгөөний суурь үндэслэлийг боловсруулахдаа суурь судалгаа, бизнесийн гадаад, дотоод орчны иж бүрэн шинжилгээ, стратегийн байр суурийн үнэлгээ, өрсөлдөх чадвар болон эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн арга зүйд тулгуурлан гүйцэтгэж, эдгээр судалгааны дүн шинжилгээг стратегийн чиглэл, зорилтуудыг тодорхойлох үндсэн суурь баримт бичиг болгосон болно. Ийнхүү төлөвлөгөө нь бодит нөхцөл, өгөгдөл, шинжилгээнд тулгуурласан, хэрэгжих боломжтой стратегийн шийдлүүдийг агуулж байна.

Энэхүү Хөгжлийн төлөвлөгөөний гол зорилго нь Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийг кластер-суурьтай, экспортод чиглэсэн, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих, “Налуу-Ухаа” эдийн засгийн тусгай бүстэй харилцан уялдсан үйлдвэрлэл-логистикийн стратегийн төв болгон хөгжүүлэхэд оршино. Төлөвлөгөө нь төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид болон орон нутгийн оролцогч талуудын хамтын ажиллагааг нэгтгэж, бүс нутгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулах стратегийн ач холбогдол бүхий баримт бичиг болно.

Хөгжлийн төлөвлөгөө нь нийт дөрвөн бүлгээс бүрдэх бөгөөд бүлэг тус бүр нь Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг стратеги-хэрэгжилт-үр нөлөө-хяналт, үнэлгээний уялдаатай логикоор цогцоор төлөвлөх зорилготойгоор боловсруулагдсан.

Нэгдүгээр бүлэгт Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийн алсын хараа, эрхэм зорилго, тэдгээрт нийцсэн урт болон дунд хугацааны стратегийн зорилго, зорилтууд, мөн эдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга замын төлөвлөлтийг тодорхойлсон. Стратегийн чиглэлүүдийг суурь судалгаа, бизнесийн орчны шинжилгээ, стратегийн байр суурийн үнэлгээнд тулгуурлан тодорхойлж, үе шаттай хэрэгжүүлэх логик, уялдааг тусгасан нь энэхүү бүлгийн үндсэн агуулга юм.

Хоёрдугаар бүлэгт Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой засаглал, зохион байгуулалт, санхүүжилт, түншлэл, хэрэгжилтийн механизмыг тодорхойлон, стратегийн зорилтуудыг бодит ажил болгох хэрэгжүүлэх төлөвлөгөө, практик ач холбогдол бүхий зөвлөмжүүдийг боловсруулан санал болгосон. Тус бүлэг нь төлөвлөгөөний хэрэгжилтийн институцийн болон санхүүгийн суурийг бүрдүүлэхэд чиглэсэн болно.

Гуравдугаар бүлэгт Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тодорхойлж, бүс нутаг, нийслэл, улсын хэмжээнд бий болох эдийн засгийн өсөлт, ажлын байр, үйлдвэрлэлийн нэмүү өртөг, импорт орлох болон экспортын чадавх, түүнчлэн нийгмийн хөгжил, орон нутгийн амьжиргаанд үзүүлэх эерэг нөлөөг цогцоор нь тусгасан.

Дөрөвдүгээр бүлэгт Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянах, үнэлэх, сайжруулах тогтолцоог тодорхойлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, хариуцлага, мэдээллийн урсгал, тайлагналын механизмыг тусгасан.



Энэхүү бүлэгт стратегийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хэмжигдэхүйц үзүүлэлтүүд (KPI)-ээр үнэлэх, хэрэгжилтийн явцад үүсэх эрсдэл, гүйцэтгэлийн зөрүүг илрүүлж, засварлах, шинэчлэх шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтуудыг тодорхойлсон. Ийнхүү дөрөвдүгээр бүлэг нь Хөгжлийн төлөвлөгөө бодитой хэрэгжиж, зорьсон үр дүндээ хүрэхийг баталгаажуулах удирдлагын хяналтын үндсэн суурь болж байна.

Түүнчлэн энэхүү Хөгжлийн төлөвлөгөө нь Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийн урт болон дунд хугацааны хөгжлийн суурь стратегийн баримт бичиг болохын хувьд цаашид хэрэгжүүлэх богино хугацааны төлөвлөлтүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх үндсэн чиг баримжаа болох ач холбогдолтой. Иймд Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан алсын хараа, стратегийн зорилго, зорилтууд, хэрэгжилтийн үе шат, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд тулгуурлан жил тутмын болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг уялдаа холбоотойгоор боловсруулах, хэрэгжилтийг хангах нь нэн чухал юм.

Энэ хүрээнд Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийн санхүү, эдийн засгийн төлөвлөлт, маркетинг, борлуулалтын бодлого, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хүний нөөцийн бодлого, чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүд зэрэг богино хугацаанд хэрэгжих төлөвлөлтүүдийг энэхүү Хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулж, стратегийн зорилтуудтай нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэснээр стратеги болон өдөр тутмын удирдлага, гүйцэтгэлийн хоорондын уялдаа хангагдаж, төлөвлөгөө бодит үр дүнд хүрэх нөхцөл бүрдэнэ.

Налайхын ҮТП-ийн 2025-2030 он хүртэлх дунд хугацааны болон 2040 он хүртэлх урт хугацааны энэхүү хөгжлийн төлөвлөгөө нь зөвхөн Налайх дүүргийн биш, нийслэл болон улсын эдийн засгийн тэлэлтэд бодит хувь нэмэр оруулах хөгжлийн гарц болно гэдэгт итгэлтэй байна.



БҮЛЭГ I. “НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК”-ИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ЗОРИЛТУУД

1.1. Алсын хараа, эрхэм зорилго, үндсэн үнэт зүйлс

Алсын хараа



Монголын барилгын материал, эко технологийн үйлдвэрлэлийг дэлхийн жишигт хүргэж, инновац ба тогтвортой хөгжилд манлайлах үйлдвэр технологийн төв болно.

Эрхэм зорилго



Байгаль орчинд ээлтэй, бизнесийн таатай орчин бүрдүүлж, үндэсний хөгжилд чиглэсэн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, барилгын материалын үйлдвэрлэлийн кластер байгуулж Инновац, хамтын ажиллагаа, хүний нөөцийн чадавхыг ханган, бодит эрэлтэд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоод зах зээлд тогтвортой ханган нийлүүлэхийн зэрэгцээ экспортыг нэмэгдүүлэн ажиллана.

Үнэт зүйлс



- 1. Тогтвортой байдал:** Ногоон технологи, дахин боловсруулалтыг эрхэмлэх.
- 2. Инновац:** Технологийн шинэчлэл, судалгаа-хөгжлийг түргэсгэх.
- 3. Хариуцлага:** Байгаль орчин, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах.
- 4. Хамтын ажиллагаа:** Олон улсын түншлэл, аж үйлдвэрлэлийн цогцолбор хөгжлийг бэхжүүлэх.
- 5. Ил тод байдал:** Менежментийн үйл ажиллагааг нээлттэй, шударга явуулах.

Зорилго & Амбиц



Манай зорилго

Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, технологийн дэвшил, инновацын шийдлийг дэмжих замаар Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, орон нутгийн иргэдийн амьдрал, ажиллах орчныг сайжруулах эерэг экосистемийг бүрдүүлэх.

Манай амбиц

Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Парк нь Монгол Улсын үйлдвэрлэлийн экосистемийг олон улсын түвшинд шинэ шатанд гаргах, мэдлэгт суурилсан эдийн засгийн өсөлтийн хөшүүрэг болно.

Бид:

- ✓ *Азийн тэргүүлэх үйлдвэрлэл, технологийн парк-ийн загварыг нутагшуулж, бүс нутгийн хэмжээний инновац, кластер хөгжлийн төв болно;*



- ✓ *Импортыг орлох, экспортын баримжаатай, өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнд суурилсан эдийн засгийн шинэ хөшүүрэг-ийг бий болгоно;*
- ✓ *Дэд бүтэц, технологи, хүний нөөц, инновацын цогц чадавхыг хөгжүүлсэн загвар паркийн жишиг тогтооно;*
- ✓ *Тогтвортой хөгжил, ногоон шийдлийг компанийн соёл, бодлогын төвд байршуулна;*
- ✓ *Үйлдвэрлэл, судалгаа, бизнесийн хамтын ажиллагааг хөшүүрэг болгон бүтээлч хамтын ажиллагааны орчин бүрдүүлнэ.*

Налайхын Үйлдвэрлэл Технологийн Парк (НҮТП)-ийн стратегийн эрхэм зорилго, алсын хараанд нийцсэн, ажилтан, инновац, нийгмийн хариуцлага, үндэсний хөгжил зэрэг үнэт зүйлсийг илэрхийлэх брэндийн тунхаглал (Brand Manifesto)-ыг дараах байдлаар боловсрууллаа.

Налайхын Үйлдвэрлэл Технологийн Парк – Брэндийн тунхаглал

Бид хэн бэ?

Бид бол Монголын бүтээлч үйлдвэрлэлийн шинэ эрин үеийг тодорхойлох цогцолбор. Инновац, эко технологи, хамтын хөгжил, мэдлэгт суурилсан өсөлтийг түүчээлэгч.

Бид юунд итгэдэг вэ?

- ✓ **Ажилтан** бол манай үнэт капитал. Бид тэдний дотоод эрч хүч, бүтээлч сэтгэлгээгээр ирээдүйг бүтээнэ.
- ✓ **Үйлдвэрлэл** зөвхөн материал бүтээдэггүй — харин амьдралын чанар, эдийн засгийн тогтвортой байдал, бахархал бий болгоно.
- ✓ **Инновац** бол зөвхөн шинэ санаа бус — үр дүнд хүрэх ухаалаг түншлэл, хамтын зорилго юм.
- ✓ **Нийгмийн хариуцлага** бол бидний үйл ажиллагааны зүрх. Бид зөвхөн барилгын материал биш, харин зөв хөгжлийг бүтээнэ.

Бид юу бүтээдэг вэ?

- ✓ Байгаль орчинд ээлтэй, шинэлэг шийдэлтэй үйлдвэрлэл
- ✓ Үр ашигтай, тогтвортой хөрөнгө оруулалт
- ✓ Орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжих бодлого
- ✓ Судалгаа–үйлдвэрлэл–инновацын уялдаа бүхий экосистем
- ✓ Хүний нөөцийн ур чадварт суурилсан өсөлтийн орчин

Бид юунд тэмүүлж байна вэ?

Монгол Улсыг **барилгын материал, инновацын үйлдвэрлэлийн бүс нутгийн төв** болгоход хувь нэмрээ оруулж, **нийгмийн хөгжил, ажиллах хүчний чадвар, үндэсний брэнд**-ийг олон улсын тавцанд таниулах.

Бидний Уриа (Slogan):

1. “Стандарттай үйлдвэрлэл, ногоон хөгжил”
2. “Мэдлэгээс бүтээлд, бүтээлээс хөгжилд.”



1.2. Хөгжлийн стратеги





1.3. Стратегийн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Урт хугацааны стратеги (2030–2040)

2030–2040 онд НҮТП нь дэвшилтэт технологи, инновац, байгаль хамгаалалд суурилсан эдийн засагт шилжих “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн хөгжинө. Урт хугацаанд таван стратегийн гол зорилтыг хэрэгжүүлнэ. Стратегийн зорилго тус бүрийн хүрээд таван зорилт тодорхойлон хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөл, бодлого хөтөлбөрийн санаачилгыг дараах хүснэгтүүдээр харуулж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, кластер хөгжүүлэлтийн хөтөлбөрт үйлдвэрлэлийн паркийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, өндөр технологи нутагшуулах гол хэрэгсэл болгож заасан байдаг.

Стратегийн зорилго 1: Олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх

Паркийн өрсөлдөх чадварыг дэд бүтэц, хөрөнгө оруулалтын суурь, кластерын сүлжээ, инновацын систем, мэргэжлийн боловсон хүчин гэсэн таван үндсэн чиглэлд стратегийн зохион байгуулалттайгаар хөгжүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

1.1. ҮТП-ийн талбайг өргөтгөх, дэд бүтцийг үргэлжлүүлэн сайжруулах

- Үндсэн суурь нөхцөл: газар ашиглалт, дэд бүтцийн өргөтгөл (цахилгаан, ус, авто болон төмөр зам, харилцаа холбоо)
- Ашиглалтын зардал багатай, олон улсын стандарт хангасан хөгжлийн хоёр дахь үе шатны суурийг тавина

1.2. Үйлдвэрлэлийн нөөцийг эзэмших, үндэсний томоохон бизнесүүдийг татах

- Монголын тэргүүлэх үйлдвэрлэгчдийг “хамтран хөрөнгө оруулагч” байдлаар татах нь ҮТП-ийн нэр хүнд, цар хүрээг өсгөнө
- Үндэсний бахархал төдийгүй гадаад хөрөнгө оруулалтад баталгаа болох эх үүсвэр болно.

1.3. Эдийн засгийн олон талт холбоос үүсгэх

- Кластерын гинжин нийлүүлэлтэд жижиг, дунд бизнесүүдийг татан оролцуулах нь зөвхөн үйлдвэрлэгч бус экосистемийн хөгжүүлэгч байр суурийг баталгаажуулна.

1.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний инновац хөгжүүлэх

- “Инновацын төв”, “судалгааны төв” зэрэг хамтын R&D орчныг бүрдүүлэх замаар технологийн түвшнийг экспортын чадамжтай түвшинд ойртуулна.

1.5. Ажиллах хүч, мэргэжлийн тогтолцоог бэхжүүлэх

- Аж үйлдвэр–дээд боловсролын хамтын ажиллагаа нь нийлүүлэлтэд суурилсан сургалтын хөтөлбөртэй байна.

Хүснэгт 1.1. НҮТН-ийн урт хугацааны стратегийн зорилго 1-ийн хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилго 1: Олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх				
2	Зорилт 1.1: Үйлдвэрлэл, технологийн паркийн талбайг өргөтгөх – дэд бүтцийг үргэлжлүүлэн сайжруулах	Паркийн газрыг инженерийн дэд бүтцээр бүрэн хангах ажлыг төрийн санхүүжилтээр хэрэгжүүлэх талаар санал боловсруулна	Боловсруулсан саналын тоо	≥1	2031–2035
3		Эрчим хүчний хангамжийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх дэд станцын төсөл хэрэгжүүлэх	- Эрчим хүчний нөөцийн хүчин чадал (МВт) - Шинээр холбогдсон үйлдвэрүүдийн тоо	+50 МВт, ≥ 20 үйлдвэр	2031–2035
4		Үер усны эрсдэлээс сэргийлэх ус зайлуулах систем шинээр барих	- Ус зайлуулах шугамын нийт урт (м) - Үерийн улмаас эвдэрсэн талбайн тоо бууралт (%)	5 км урт, эвдрэл ≥ 70% буурна	2031–2035
5		Төмөр замын терминал бүхий логистикийн дэд бүтэц төлөвлөж хэрэгжүүлэх	- Холбогдсон төмөр замын урт (км) - Терминал ашиглалттай холбоотой экспортын өсөлт (%)	10 км урт, экспорт +25%	2036–2040
6		Инженер геологийн судалгааг бүрэн хийж, хөрсний тохиромжтой төлөвлөлтийн бүс тогтоох	- Судалгаанд хамарсан нийт талбай (га) - Эрсдэлгүй бүсэд шинээр төлөвлөгдсөн төсөл, объектын тоо	50 га, ≥ 10 төсөл	2031–2035
7		Паркийн хоёр дахь үе шатны хотхон байгуулах – ажилчдын орон сууц, дэд бүтэцтэй хамт	- Баригдсан орон сууцны нэгжийн тоо - Хамрагдсан ажилчдын тоо - Ажиллах хүчний байнгын байршлын хувь (%)	300 орон сууц, ≥ 1,000 ажилтан, 60-65% байнгын суурьшил	2036–2040
8		Олон улсын стандартын дагуу паркийн талбайг 2 дахин нэмэгдүүлэх хөтөлбөр	- Шинээр нэмэгдсэн талбайн хэмжээ (га) - Стандартад нийцсэн барилга, байгууламжийн тоо - ISO зэрэгжилттэй бүсийн эзлэх хувь (%)	+100 га, ≥ 20 байгууламж, ISO бүс ≥ 60%	2036–2040
9		Зорилт 1.2: Үйлдвэрлэлийн нөөцийг эзэмших, дотоодын голлох	“Үндэсний хөрөнгө оруулалтын түншлэл” хөтөлбөр хэрэгжүүлж, стратегийн ААН-үүдэд санал тавих	- Хамтран ажиллах гэрээ байгуулсан үндэсний томоохон ААН-ийн тоо - Хамтарсан хөрөнгө оруулалтын дүн (тэрбум₮)	≥ 10 ААН, ≥ 100 тэрбум₮

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
10	томоохон бизнес эрхлэгч үйлдвэрүүдийг татах – үндэсний зах зээлд	Үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн ордуудыг концесс/зохицуулалтаар эзэмших ажлыг эхлүүлэх	- Эзэмшсэн нөөцийн тоо, ашиглалтын хугацаа (жилээр) - Үйлдвэрийн түүхий эдийн хангалтын хувь (%)	≥ 3 орд, ≥ 15 жил, ≥ 70% хангалт	2031–2035
11	тоглогч аж ахуйн нэгжтэй хамтарч хөрөнгө оруулах	Томоохон үйлдвэрлэгчдэд зориулсан "өндөр багтаамжтай үйлдвэрлэлийн талбай" тусгай бүсчлэл хийх	- Өндөр хүчин чадлын үйлдвэр байршуулсан талбайн хэмжээ (га) - Бүртгэгдсэн томоохон ААН-үүдийн тоо	≥ 50 га, ≥ 15 ААН	2036–2040
12		“Үндэсний үйлдвэрлэл-Налайхад” хөрөнгө оруулалтын чуулган жил бүр зохион байгуулах	- Оролцсон хөрөнгө оруулагч, ААН-үүдийн тоо - Хурлын үеэр баталгаажсан хөрөнгө оруулалтын хэмжээ (тэрбум₮)	Эхний шат: ≥ 50 ААН, ≥ 30 тэрбум₮/жил; Дараагийн шат: ≥ 100 ААН, ≥ 60 тэрбум₮/жил	2031–2035 / 2036–2040
13		Үйлдвэрлэлд чиглэсэн Нийслэлийн концесс, түрээсийн бодлогыг шинэчлэх	- Шинэчлэгдсэн түрээсийн гэрээний тоо - Хувийн хэвшлээс шинээр орсон хөрөнгө оруулалт (тэрбум₮)	≥ 30 гэрээ, ≥ 150 тэрбум₮	2036–2040
14	Зорилт 1.3: Эдийн засгийн олон талт холбоос үүсгэх – кластерын гинжин нийлүүлэлтэд оролцох аж ахуйн нэгжүүдийг нэмэгдүүлэх.	“Нийлүүлэлтийн гинжин сүлжээ”-ний нэгдсэн платформ (SCM Hub) хөгжүүлэх	- Платформд бүртгэгдсэн ААН-ийн тоо - Хийгдсэн дотоод гүйлгээний дүн - Симбиозын тохиолдлын тоо	≥ 100 ≥ 50 тэрбум₮ ≥ 20	2031–2035
15		Түүхий эд болон хаягдал дахин ашиглах симбиозын сүлжээ байгуулж бүсчлэл тогтоох	- Симбиозод хамрагдсан үйлдвэрүүдийн тоо - Хаягдал дахин ашиглалтыг нэмэгдүүлсэн хувь (%)	≥ 30 ≥ 25%	2031–2035
16		“Кластерын зах” байгуулах – үйлдвэрлэл, тээвэр, нийлүүлэлтийн ААН-уудын төвлөрсөн орчин	- Кластерын захад үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо - Хамтран бүтээсэн бүтээгдэхүүн/үйлчилгээний тоо	≥ 50 ≥ 20	2036–2040
17		Үйлдвэрлэл, логистик, тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх	- Мэдээллийн санд бүртгэлтэй үйлчилгээ үзүүлэгчийн тоо - Холбогдсон дотоод захиалгын дундаж хугацаа	≥ 100 ≥ 30% буурсан	2031–2035

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
18	Зорилт 1.4: Үйлдвэрлэл, үйлчилгээний инновац хөгжүүлэх – хамтын инновацын төв, судалгааны парк байгуулж кластерын технологийн чадавхыг нэмэгдүүлэх	“Гэрээт нийлүүлэгч” хөтөлбөр хэрэгжүүлж, үндэсний түншүүдийг дэмжих санхүүгийн нөхцөл бүрдүүлэх	- Гэрээт нийлүүлэгчээр бүртгэгдсэн ААН-ийн тоо - Хамгаалагдсан нийлүүлэлтийн гэрээний хэмжээ (тэрбум₮)	≥ 80 ≥ 200 тэрбум₮	2036–2040
19		Нийлүүлэлтийн гинжний төгсгөлд ажиллах жижиг бизнесүүдийг дэмжих хөтөлбөр	- Дэмжигдсэн жижиг бизнесийн тоо - Бүтээгдэхүүн хүргэлтийн хугацааны бууралт - Борлуулалтын өсөлт (%)	≥ 200 ≥ 20% ≥ 30%	2036–2040
20		Паркийн бүрэлдэхүүнд бусад салбарын үйлдвэр нэвтрүүлэх (жишээ нь: химийн болон шил үйлдвэрлэх цогцолбор)	- Шинээр орсон салбарын тоо - Тус салбарт үүссэн ажлын байрны тоо - Паркийн нийт экспортын өсөлт (%)	≥ 2 ≥ 500 ≥ 15%	2036–2040
21		Инновацын хамтын R&D төв байгуулах (төр-хувийн түншлэлтэй)	- Шинэ R&D төсөл, бүтээгдэхүүний тоо - Тус төвөөс гаралтай патент, шинэ технологийн тоо	≥ 10 ≥ 5	2031–2035
22		“Үйлдвэрлэл + Судалгаа” стартап инкубатор байгуулж, технологи дээр суурилсан гарааны бизнес дэмжих	- Хөгжүүлсэн стартапын тоо - Бизнес загвар, патент гаргасан шинэ санааны тоо	≥ 30 ≥ 15	2031–2035
23	Инновац төвтэй үйлдвэрүүдийн технологийн үнэлгээ, дамжуулалт хийх платформ бий болгох	- Хийгдсэн технологийн дамжуулалтын тоо - Шинэчлэгдсэн технологитой үйлдвэрүүдийн тоо	≥ 20 ≥ 15	2036–2040	
24		Салбар хоорондын инновацын уралдаан, хакатон, бизнесийн санааны уралдаан жил бүр зохион байгуулах	- Оролцсон баг, хувь хүний тоо - Инкубаци, хөрөнгө оруулалтад шилжсэн санааны тоо	Эхний шат: жил бүр ≥ 20 баг; ≥ 50% нь хөрөнгө оруулалт татсан Дараагийн шат: жил бүр ≥ 40 баг; Нийт ≥ 30 санаа бүтээгдэхүүн болсон	2031–2035 (эхлэх) → 2036–2040 (өргөжүүлэх)
25		“Нээлттэй инновацын сан” байгуулж, парк дахь үйлдвэрүүдийн дунд	- Сангаас дэмжигдсэн төсөл,	≥ 30 төсөл ≥ 15 ААН ≥ 50 тэрбум₮	2036–2040

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
		инновацын хөрөнгө гаргах тогтолцоо бий болгох	- Хамтран санхүүжүүлсэн ААН-ийн тоо - Инновацын төсөлд оруулсан нийт хөрөнгө (тэрбум₮)		
26		Паркт шинжилгээ, туршилтын төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	- Хийгдсэн лабораторийн шинжилгээний тоо - Сертификат, стандарт хангасан бүтээгдэхүүний хувь (%)	≥ 5 ≥ 80%	2036–2040
27		Инновацын экосистем хөтөлбөр хэрэгжүүлж, бизнес, шинжлэх ухааны байгууллагуудыг холбосон “Үйлдвэрлэл–Судалгаа” институт байгуулах	- Гишүүн байгууллагын тоо - Хамтарсан инновацын төсөл, судалгаа эхлүүлсэн тоо - Олон улсын түншлэлүүдийн тоо	≥ 30 ≥ 20 ≥ 5	2031–2035
28		Их, дээд сургуультай хамтарсан “Үйлдвэрлэлийн дадлагын хөтөлбөр” хэрэгжүүлэх	- Хамрагдсан оюутны тоо - Паркт шууд ажилд орсон төгсөгчийн хувь (%)	≥ 500 ≥ 60%	2031–2035
29	Зорилт 1.5: Ажиллах хүч, мэргэжлийн тогтолцоог бэхжүүлэх– их, дээд сургуультай хамтран үйлдвэрлэлийн чиглэлийн шинэ хөтөлбөр боловсруулах.	Паркийн хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн чиглэлийн хосолмол сургалтын хөтөлбөр (TVET) нэвтрүүлэх	- Шинэчлэгдсэн мэргэжлийн хөтөлбөрийн тоо - Сургалтад хамрагдсан мэргэжилтэй ажилчдын тоо	≥ 10 ≥ 1,000	2031–2035
30		“Аж үйлдвэрийн Академи” байгуулах – гадаад сургалт, менторшип, баталгаажуулалт бүхий систем	- Академид хамрагдсан мэргэжилтний тоо - Гадаад сертификат олгосон сургалтын тоо	≥ 2,000 ≥ 1,000	2036–2040
31		Үйлдвэрүүдэд ажиллаж буй ажилчдад зориулсан тасралтгүй чадавхжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	- Жилд хамрагдсан ажилтны тоо - Бүтээмж өсөлттэй холбоотой үйлдвэрийн тоо	Эхний шат: жил бүр ≥ 500 ажилтан хамрагдсан, ≥ 20 үйлдвэр хамрагдсан - Дараагийн шат: жил бүр ≥ 1,000 ажилтан, ≥ 40 үйлдвэр хамрагдсан	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөжүүлэх)

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
32		“Ажиллах хүч – үйлдвэрлэл” дата платформ нэвтрүүлэх (чиглэлийн ур чадварын нөөцийн зураглал)	- Платформд бүртгэгдсэн мэргэжил, ажил хайгчийн тоо - Ажилд зуучлагдсан иргэдийн хувь (%)	≥ 10,000 ≥ 80%	2036–2040
33		ШУТИС-д паркийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай зохицсон дадлагын газар байгуулах	- Дадлагын газарт хамрагдсан оюутны тоо - Төгсөөд үйлдвэрт шууд ажилд орсон хувь (%) - Дадлага үр дүнгийн үнэлгээ	≥ 300 ≥ 70% ≥ 80% эерэг	2031–2035
34		Паркийн сургалт, судалгаа, инновацын технологийн цогцолбор барих хөтөлбөр хэрэгжүүлэх	- Баригдсан цогцолборын хүчин чадал (м ²) - Жилд зохион байгуулсан сургалт, хакатоны тоо - Нэвтрүүлсэн технологийн тоо	≥ 20,000 м ² Жил бүр ≥ 50 ≥ 10	2036–2040



Уг стратегийн нэгдүгээр зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд дараах зүйлсэд анхаарах нь зүйтэй. Үүнд:

- ✓ **Газрын ашиглалтын асуудал:** хоёр дахь үе шатны өргөтгөл хийхэд эрх зүйн тодорхой байдал, орон нутгийн дэмжлэг чухал юм.
- ✓ **Эдийн засгийн тогтворгүй байдал:** хөрөнгө оруулалтын эрсдэл, ханшийн савлагаа зэргийн хүрээнд байнга судалгаа, шинжилгээ хийж байх шаардлагатай.
- ✓ **Хүний нөөцийн хомсдол:** чадварлаг ажиллах хүч, сургагч багш, R&D багийг бүрдүүлэх, хадгалахад анхааран ажиллах хэрэгтэй.
- ✓ **Инновацын экосистемийн дутагдал:** патент, технологи дамжуулалт, санхүүжилтийн механизмыг бүрдүүлэхэд санал санаачилга гаргаж ажиллах нь зүйтэй.
- ✓ **Институцийн тогтвортой байдал:** төрийн бодлого, дэмжлэгийн үргэлжлэл хангагдах ёстой.

Энэхүү зорилго бол НҮТП-ийн “дэд бүтэц төвтэй хөгжил”-өөс “инновац, өрсөлдөх чадвар төвтэй хөгжил” рүү шинэ шатанд шилжих эхлэл юм. Хөрөнгө оруулалтын дэд бүтцийн бэлтгэл, нөөцийн оновчтой менежмент, олон талт оролцоонд тулгуурласан кластерын загвар хэрэгжсэн тохиолдолд, НҮТП нь **төвлөрсөн үйлдвэрлэлийн инновацын зангилаа** болох бүрэн боломжтой.

Зөвлөмж

- ✓ Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг институцлэх – Зөвлөл, консорциум, бодлогын оролцогч байгууллага байгуулах;
- ✓ Гадаад стратегийн түншүүдтэй MoU байгуулж эхлэх – БНСУ, ХБНГУ, БНХАУ зэрэг улс орнуудтай урьдчилсан хэлэлцээ эхлүүлэх;
- ✓ Кластерын загварт тулгуурласан зах зээлийн эрэлт, нөөцийн үнэлгээ хийх – Эдийн засгийн үр өгөөжийг бодитоор харуулах;
- ✓ Үйлдвэрлэл–сургалт–R&D холбосон гуравласан түншлэлийн систем бий болгох;
- ✓ Хөгжлийн замын зураглалын үе шат тус бүрийн төслийн удирдлагын нэгж байгуулж, гүйцэтгэлийг хянах;

Стратегийн зорилго 2: Технологи, инновацын салбарт тэргүүлэх

НҮТП-ийг Монгол Улсад технологийн шинэчлэл, дэвшилтэт үйлдвэрлэлийн төв, инновацын институцийн загвар болж хөгжүүлэх урт хугацааны стратегийн чиглэл.

2.1 Шинэ технологийг судалгаа хөгжүүлэлтийн түвшинд нутагшуулах

- ✓ Судалгаа–туршилт–үйлдвэрлэл гэсэн гурван үе шаттай инновацын системийг эхлүүлнэ.
- ✓ Шинэ материал, робот систем, шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

2.2 Дижитал болон автоматжуулсан үйлдвэрлэлд шилжих

- ✓ Аж үйлдвэр 4.0-ийн үндсэн бүрэлдэхүүн: IoT, AI, автоматжуулалт, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын тогтолцоонд шилжинэ.
- ✓ Инновацын лаборатори, “Smart Factory” туршилтын шугам бий болно.



- ✓ Smart Data Dashboard-г хөгжүүлж, паркийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ. Эрчим хүч, ус, хаягдал, үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр зэрэг гол KPI-г бодит цагийн горимоор хянах боломж бүрдэнэ.

2.3 Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн өндөр түвшнийг бий болгох

- ✓ Оюуны өмч, технологийн лиценз, патентын мэдүүлэг хийх чадвар нэмэгдэнэ.
- ✓ Хамгийн багадаа технологийн бэлэн байдлын **TRL6–TRL9** түвшний (Technology Readiness Level) бүтээгдэхүүн бий болно.

2.4 Олон улсын технологийн стандартуудыг нэвтрүүлэх

- ✓ ISO, IEC, ASTM зэрэг стандартуудтай нийцүүлэн чанарын дэд бүтэц бий болгож, экспортын саад тотгорыг бууруулах үндэс тавигдана.
- ✓ IASP, ANK, ASEAN Smart Parks Network олон улсын сүлжээнд гишүүнчлэлээр элсэнэ.

2.5 Инновацын хамтын ажиллагааны сүлжээг өргөжүүлэх

- ✓ Их сургууль–бизнес–R&D төвийн стратегийн түншлэл, гадаад лабораториудтай сүлжээ үүсгэн ажиллана.
- ✓ Innovation Platform, Sandbox систем нэвтрүүлэх боломжтой.

Стратегийн хоёрдугаар зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

- ✓ **Инновацын санхүүжилт тогтолцоогүй:** дотоодын хөрөнгө оруулагчид эрсдэлээс болгоомжилдог.
- ✓ **Технологийн лицензийн эрх зүйн орчин сул:** оюуны өмчийн баталгаажуулалт, хамгаалалт хангалтгүй.
- ✓ **Хүний нөөцийн хомсдол:** технологийн гүнзгий мэдлэгтэй инженер, шинжээч, дата шинжээчийн тоо хязгаарлагдмал.
- ✓ **Институцийн уялдаа муу:** их дээд сургуулиуд, судалгааны байгууллагууд, хувийн хэвшил хоорондын механик холбоо дутмаг.
- ✓ **Инновацын үр өгөөж урт хугацаанд гарах онцлог:** хурдан өгөөж хүлээгч зах зээлд хүлээлт зөв удирдах шаардлагатай.

Хүснэгт 1. 2. НҮТН-ийн урт хугацааны стратегийн зорилго 2-ын хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр нөлөө

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилго 2: Технологи, инновацын салбарт тэргүүлэх				
2	Зорилт 2.1: Шинэ технологийг судалгаа хөгжүүлэлтийн түвшинд нутагшуулах – робот автоматжуулалт, боловсруулалт, шинэ материал боловсруулах.	“Шинэ технологийн туршилтын лаборатори” байгуулах	- Үүссэн туршилтын загвар, технологийн тоо - Хамрагдсан стартап, инженерийн тоо	≥ 10 ≥ 200	2031–2035
3		Гадаад улсад суралцах, туршлага судлах тэтгэлэгт R&D хөтөлбөр хэрэгжүүлэх	- Тэтгэлэгт хамрагдсан судлаачдын тоо - Хөгжүүлсэн туршилтын технологийн тоо	Эхний шат: тэтгэлэгт хамрагдсан ≥ 100 судлаач Дараагийн шат: нийт ≥ 300 судлаач, нутагшуулсан технологи ≥ 20	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөжүүлэх)
4		“Нээлттэй шинэ материалын дата платформ” бий болгож дотоод нөөцийг нэвтрүүлэх	- Дата платформд оруулсан материалын төрөл - Үйлдвэрт ашиглагдсан материалын хувь	≥ 50 ≥ 40%	2036–2040
5		Робот, ухаалаг төхөөрөмжийн угсралтын төв байгуулах	- Угсрагдсан төхөөрөмжийн тоо - Ашиглалтад орсон роботын тоо	≥ 200 ≥ 50	2036–2040
6		“Шинэ материал – шинэ бүтээгдэхүүн” уралдаан жил бүр зохион байгуулах	- Хүрсэн инновацын санаа - Туршилтад орсон материалын тоо	Эхний шат: жил бүр ≥ 30 шинэ санаа Дараагийн шат: жил бүр ≥ 60 санаа, туршилтад орсон материал ≥ 40	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөжүүлэх)
7		Барилгын өндөр өртөг бүхий материалыг орлуулах шинэ бүтээгдэхүүн, түүний бүрэлдэхүүн хэсгийг хөгжүүлэх төсөл	- Хөгжүүлсэн шинэ материалын тоо - Импорт орлох бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувь (%)	≥ 20 ≥ 25%	2036–2040
8		Харьцангуй өндөр технологитой дотоодын үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр (жишээ нь: ухаалаг барилгын иж бүрдэл)	- Шинэчлэгдсэн үйлдвэрлэлийн шийдлийн тоо - Ухаалаг бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй ААН-ийн тоо	≥ 15 ≥ 20	2036–2040

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
9	Зорилт 2.2: Дижитал болон автоматжуулсан үйлдвэрлэлд шилжих	“Үйлдвэрлэл 4.0” туршилтын үйлдвэр байгуулж, модулчлагдсан автомат систем нэвтрүүлэх	- Туршилтаар хөгжүүлсэн системийн тоо - Нэвтрүүлэлтийн хугацаа, ашиглалтад орсон үйлдвэрийн тоо	Эхний шат: ≥ 5 туршилтын автомат систем Дараагийн шат: ≥ 20 үйлдвэрт нэвтрүүлсэн	2031-2035 (туршилт), 2036-2040 (бүрэн нэвтрүүлэлт)
10		IoT, SCADA, ERP систем нэвтрүүлэх Smart Data Dashboard хөгжүүлэн үйл ажиллагаанд нэвтрүүлэх	- Эрчим хүч, ус, хаягдал, үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр зэрэг үзүүлэлтийг бодит цагийн горимоор хянах - ERP систем бүрэн ашиглалтад орсон байгууллагын хувь	≥ 50 ≥ 70%	2036-2040
11		“Үйлдвэрийн өгөгдөл ба хиймэл оюун ухаан” сургалт, зөвлөх үйлчилгээ зохион байгуулах	- Сургалтад хамрагдсан хүний тоо - Өгөгдлийн шийдэл нэвтрүүлсэн тоо	≥ 1,000 ≥ 30	2031-2035
12		Үйлдвэрлэлийн ухаалаг мэдрэгчийн дата-туршилтын лаборатори байгуулж, патентжуулах	- Хөгжүүлсэн мэдрэгчийн тоо - Патентын тоо	≥ 20 ≥ 10	2036-2040
13		“Үйлдвэрлэл + Дижитал” шилжилтийн хэрэгжилтийн индекс боловсруулж тайлагнах	- Жилийн тайлан, дижитал шилжилтийн индекс - Шинэчлэгдсэн процессын хувь (%)	Эхний шат: жил бүр индексийн тайлан гаргасан, процессын шинэчлэлт ≥ 20% Дараагийн шат: процессын шинэчлэлт ≥ 50%, олон улсын тайланг хүлээн зөвшөөрсөн	2031-2035 (эхлэх), 2036-2040 (тогтмолжуулах)
14		Зорилт 2.3: Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн өндөр түвшнийг бий болгох, оюуны	Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн төв байгуулах	- Хөгжүүлсэн бүтээгдэхүүний тоо - Борлуулагдсан шинэ бүтээгдэхүүний хувь (%)	≥ 30 ≥ 20%
15		Патент, гэрчилгээ авахад туслах “Оюуны өмчийн тусгай сан” ажиллуулах	- Баталгаажсан оюуны өмчийн тоо - Сангаас дэмжлэг авсан ААН, хувь хүмүүсийн тоо	≥ 100 ≥ 200	2036-2040

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
16	өмчүүдийг баталгаажуулах	Үндэсний брэнд хөгжүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээний баг ажиллуулах	- Шинэ брэнд бүртгүүлсэн тоо - Экспортод гарсан бүтээгдэхүүний тоо	Эхний шат: бүртгэгдсэн шинэ брэнд ≥ 20 , экспортод гарсан бүтээгдэхүүн ≥ 10 – Дараагийн шат: бүртгэгдсэн шинэ брэнд ≥ 50 , экспортод гарсан бүтээгдэхүүн ≥ 30	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
17		“R&D–Design–Marketing” уялдааг сайжруулах платформ хөгжүүлэх	- Хэрэглэгчийн зүгээс баталгаажсан загварын тоо - Хөгжүүлэлтээс борлуулалт хүртэлх хугацаа (cap)	≥ 40 ≤ 12 cap	2036–2040
18		Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн шилдэг санааг хөрөнгө оруулалтад шилжүүлэх санхүүжилтийн механизм	- Хөрөнгө татсан инновацын санаа - Санхүүжүүлсэн төслөөс зах зээлд гарсан бүтээгдэхүүний тоо	Эхний шат: хөрөнгө татсан инновацын санаа ≥ 20 , зах зээлд гарсан бүтээгдэхүүн ≥ 10 Дараагийн шат: хөрөнгө татсан санаа ≥ 50 , зах зээлд гарсан бүтээгдэхүүн ≥ 30	2031–2035 (эхлэх), 2036–2040 (тогтмолжуулах)
19	Зорилт 2.4: Олон улсын технологийн стандартуудыг нэвтрүүлэх	ISO, ASTM, CE зэрэг олон улсын стандартад нийцсэн сургалт, зөвлөмжийн төв ажиллуулах	- Стандартын сургалтад хамрагдсан ААН-ийн тоо - Стандарт нэвтрүүлсэн бүтээгдэхүүний тоо	≥ 100 ≥ 50	2031–2035
20		Стандартын дагуу аудит хийдэг “Үнэлгээний баг”-ийг парк дотор ажиллуулах	- Аудит хийсэн үйлдвэрүүдийн тоо - Чанарын гэрчилгээтэй үйлдвэрийн хувь (%)	≥ 80 $\geq 60\%$	2036–2040
21		Салбарын стандарт нэвтрүүлэхэд зориулсан буцалтгүй дэмжлэгийн хөтөлбөр хэрэгжүүлэх	- Дэмжигдсэн ААН-ийн тоо - Сертификаттай болж гадагш гарсан бүтээгдэхүүний тоо	≥ 50 ≥ 30	2031–2035

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
22		“Олон улсын стандарт + Кластерын чадавх” хамтарсан арга хэмжээ зохион байгуулах	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо - Оролцсон кластерын тоо	≥ 20 ≥ 15	2036–2040
23		IASP, АНК, ASEAN Smart Parks Network олон улсын сүлжээнд гишүүнчлэлээр элсэнэ.	Хамрагдсан үйл ажиллагааны тоо Экспортын шинэ сувгийн тоо Гишүүнчлэлийн өгөөж	Эхний шат: гишүүнчлэлд элссэн ≥ 3 сүлжээ, хамрагдсан арга хэмжээ ≥ 10 Дараагийн шат: гишүүнчлэлд элссэн ≥ 7 сүлжээ, экспортын шинэ сувгийн тоо ≥ 20	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
24	Зорилт 2.5: Инновацын хамтын ажиллагааны сүлжээг өргөжүүлэх	Гадаад улсын паркуудтай “R&D хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулж хэрэгжүүлэх	- Байгуулсан хамтын ажиллагааны МоU, гэрээний тоо - Хамтарсан төсөл, судалгааны тоо	Эхний шат: байгуулсан МоU, гэрээ ≥ 10 Дараагийн шат: хамтарсан төсөл, судалгааны тоо ≥ 30	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
25		Олон улсын лабораторитой хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж, туршилт хийх боломж бий болгох	- Туршсан бүтээгдэхүүний тоо - Гадаад лабораторитой байгуулсан гэрээний тоо	≥ 20 ≥ 15	2036–2040
26		Инновацын форум, хамтын өдөрлөг, үзэсгэлэн тогтмол зохион байгуулах (гаднын хөрөнгө оруулагчтай)	- Хамрагдсан улс орны тоо - Хөрөнгө татсан төсөл, компанийн тоо	Эхний шат: хамрагдсан улс ≥ 10, хөрөнгө татсан төсөл ≥ 20 Дараагийн шат: хамрагдсан улс ≥ 20, хөрөнгө татсан компани ≥ 50	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөтгөх)
27		Бүс нутгийн (АРЕС, ASEAN, EU) инновацын платформд гишүүнээр нэгдэх, нээлттэй дата солилцоо	- Гишүүнчлэлтэй байгууллагын тоо - API/технологийн солилцооны тоо	≥ 5 ≥ 30	2036–2040
28		“Гадаад хамтын инновацын сан” байгуулж, түншүүдтэй хамтарсан төсөл санхүүжүүлэх механизм	- Санхүүжилт олгосон төсөл, улсын тоо - Гадаад хөрөнгө оруулалтын хувь нэмэр (тэрбум₮)	≥ 40 ≥ 100 тэрбум₮	2036–2040



Энэхүү стратегийн хоёрдугаар зорилго бол инновацад суурилсан хөшүүргийн хөгжил буюу "factor-driven" хөгжлөөс "innovation-driven" хөгжилд шилжих стратегийн нүүдэл юм. Амжилттай хэрэгжвэл НҮТП нь Монгол Улсад анхны технологи экспортлогч кластер болох боломжтой. Инновацын экосистемийг бодитоор хөгжүүлж чадвал хөрөнгө оруулалтын өгөөж нь эдийн засагт *нааштай дам нөлөөтэйгөөр* илэрнэ.

Зөвлөмж

- ✓ **Инновацын тусгай сан, кластер дэмжих хөтөлбөрийг хамт хэрэгжүүлэх.** Жишээ нь: "Smart Nalaikh" дэд төсөл, бизнес инкубатор, венчур хөрөнгө оруулалтын сан байгуулах талаар судалгаа хийж, холбогдох байгууллагад танилцуулах
- ✓ **Гадаад хамтын ажиллагааг стратегийн төвшинд өргөжүүлэх** – БНСУ, Финлянд, ХБНГУ, Япон, Сингапур зэрэг улсуудаас технологийн шилжүүлэлт, туршлага авах
- ✓ **Аж үйлдвэр–их сургууль–төрийн 3 талт түншлэлийн хөтөлбөр боловсруулах** – ҮТП-ийн дэргэд хамтарсан технологи дамжуулах төв байгуулах
- ✓ **Оюуны өмчийг зах зээлд гаргах систем хөгжүүлэх** – бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дараа үйлдвэрлэлд оруулах эрх зүйн, бизнесийн загвар боловсруулах
- ✓ **Салбарын туршилтын стандартыг бататгах** – Чанарын баталгаажуулалт, бүтээгдэхүүний нийцлийн гэрчилгээ, дотоодын лаборатори хөгжүүлэх

Стратегийн зорилт 3: Олон улсын болон дотоодын зах зээлийг бэхжүүлэх

ҮТП-ийн үйлдвэрлэлийн гаралтыг эдийн засгийн үр ашиг, нэмүү өртөг, экспортоор баталгаажуулсан үндэсний болон бүс нутгийн өрсөлдөхүйц үйлдвэрлэлийн төв болгон хөгжүүлэх зорилго.

3.1. ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ХАНГАХ

- ✓ Улаанбаатар хот болон зүүн бүсийн орон сууц, дэд бүтцийн төслүүдэд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ✓ Төсөл, худалдан авалтын урт хугацааны стратегийн түншлэл байгуулах боломж

3.2. ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ

- ✓ Хойд Евро азийн эдийн засгийн хамтын нийгэмлэг, Зүүн өмнөд Ази чиглэлийн зах зээлд зориулсан экспортын бүтээгдэхүүний стандартад нийцсэн үйлдвэрлэл хөгжүүлэх
- ✓ Тусгай зориулалтын тээвэр, логистикийн систем төлөвлөх зайлшгүй шаардлагатай

3.3. ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭ, СОРИЛТЫН СИСТЕМ БИЙ БОЛГОХ

- ✓ ISO, EN, ASTM зэрэг стандартын гэрчилгээ авах лаборатори, гэрчилгээжүүлэх байгууллагын дэд бүтэц бүрдүүлнэ. Энэ нь бүтээгдэхүүний экспортын хязгаарлалтыг бууруулах боломж

3.4. ГАДААД МАРКЕТИНГ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ

- ✓ ҮТП-ийн "нэрийн хуудас" болох олон улсын үзэсгэлэн, худалдааны төлөөлөгчийн газруудыг стратегийн бүсэд байгуулах
- ✓ Хөрөнгө оруулалтын форум, экспортын холбоо үүсгэх замаар хамтарсан сурталчилгаа, брэнд бий болгох



3.5. Борлуулалтын суваг, дэд бүтцээ сайжруулах

Онлайн платформ, нийлүүлэлтийн дижитал сүлжээ, хилийн чөлөөт бүсийн нэгдсэн төвтэй уялдуулсан бүтээгдэхүүний логистик, маркетингийн экосистем төлөвлөх

Стратегийн гуравдугаар зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

- ✓ Экспортын тээвэр, гааль, логистикийн бэрхшээл – Монголын экспортын дэд бүтэц, хил дамнасан тээвэрлэлт хуучирсан
- ✓ Бүтээгдэхүүний олон улсын стандартад нийцэх түвшин сул – сорилт, баталгаажуулалтын дотоод чадавх дутмаг
- ✓ Брэндийн танигдалт сул – Монгол брэндүүд гадаад зах зээлд таниулагдаагүй
- ✓ Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:– экспортод тулгуурласан өгөгдөлд суурилсан шийдвэр дутмаг
- ✓ Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:– экспортын эрсдэл, зээл, баталгааны механизм бүрэн хөгжөөгүй

Хүснэгт 1.3. НҮТП-ийн урт хугацааны стратегийн зорилго 3-ын хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр нөлөө

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилт 3: Олон улсын болон дотоодын зах зээлийг бэхжүүлэх				
2	Зорилт 3.1: Экспортын боломжийг нэмэгдүүлэх	Экспортын бүтээгдэхүүний ангилал, стандарт, савлагааны шаардлагыг шинэчлэх	- Экспортын зориулалттай бүтээгдэхүүний тоо - Шинэ зах зээлд нэвтэрсэн бүтээгдэхүүний тоо	≥ 50 ≥ 20	2031-2035
3		“Экспортод бэлэн үйлдвэрлэл” гэрчилгээжүүлэх тогтолцоо нэвтрүүлэх	- Гэрчилгээ авсан ААН-ийн тоо - Экспортын гэрээний тоо	≥ 100 ≥ 50	2031-2035
4		Экспортын логистикийн дэмжлэгийн сан байгуулах	- Тус сангийн дэмжлэгт хамрагдсан экспортын багц - Тээврийн зардал буурсан хувь (%)	≥ 200 ≥ 20%	2036-2040
5		Олон улсад зориулсан бүтээгдэхүүн хөгжүүлэх R&D хөтөлбөр	- Бүсчилсэн зах зээлд нэвтэрсэн бүтээгдэхүүний тоо - Борлуулалтын өсөлт (%)	Эхний шат: шинэ бүтээгдэхүүн ≥ 30, экспортын өсөлт ≥ 10% Дараагийн шат: шинэ бүтээгдэхүүн ≥ 70, экспортын өсөлт ≥ 25%	2031-2035 (эхлээд), 2036-2040 (өргөжүүлэх)
6		Экспортын түншлэл, бирж, дилерийн сүлжээнд холбох сувгууд хөгжүүлэх	- Дилерийн тоо - Нийт экспортын үнийн өсөлт (%)	≥ 50 ≥ 30%	2036-2040
7		Тусгай зориулалтын тээвэр, гаралт бүхий борлуулалтын төв байгуулах	- Борлуулалтын төвийн хүчин чадал (тн/сар) - Тус төвөөр гарсан экспортын бүтээгдэхүүний хэмжээ (тн)	≥ 10 мян. тн/сар ≥ 500 мян. Тн	2036-2040
8		Монголын барилгын материал экспортлогч компаниудын нэгдэл байгуулж, хамтарсан экспортын корпорац үүсгэх	- Кластерт нэгдсэн компанийн тоо - Хамтарсан экспортын гэрээний тоо болон экспортын дүн (тэрбум₮)	Эхний шат: кластер нэгдсэн компани ≥ 20, хамтарсан гэрээ ≥ 10 Дараагийн шат: кластер компани ≥ 50, хамтарсан гэрээний дүн ≥ 200 тэрбум₮	2031-2035 (эхлээд), 2036-2040 (өргөжүүлэх)
9		Зорилт 3.2: Олон улсад өрсөлдөх чадвар бүхий брэнд	Үндэсний болон олон улсын үзэсгэлэнд оролцох “НҮТП Брэнд” дэмжих хөтөлбөр	- Оролцсон үзэсгэлэнгийн тоо - Брэнд хүлээн зөвшөөрсөн гэрчилгээний тоо	Эхний шат: оролцсон үзэсгэлэн ≥ 20, брэндийн гэрчилгээ авсан ≥ 15

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
	бий болгох – үндэсний чанарыг баталгаажуулах, маркетингийн кампанит ажил өрнүүлэх.			Дараагийн шат: оролцсон үзэсгэлэн ≥ 50 , гэрчилгээ авсан ≥ 40	
10		“НҮТП Брэнд + Үндэсний Чанар” нэгтгэсэн баталгаажуулалтын хөтөлбөр	- Чанарын гэрчилгээтэй бүтээгдэхүүний хувь (%) - Брэндийн индексийн өсөлт	$\geq 70\%$ $\geq 40\%$	2036–2040
11		Цахим сурталчилгаа, олон улсын маркетингийн стратеги боловсруулах	- Веб болон цахим хандалтын тоо - Экспортын онлайн борлуулалт	≥ 500 мянга ≥ 50 тэрбум₮	2031–2035
12		“Үндэсний брэнд хөгжүүлэлтийн төв” байгуулах	- Хөгжүүлсэн шинэ брэндийн тоо - Олон улсад бүртгүүлсэн нэр, логоны тоо	≥ 30 ≥ 20	2036–2040
13		Брэндийн түүх, эх сурвалж, үнэ цэнийг таниулах контент, баримтат видео цуврал хийх	- Үзэгчийн тоо - Контенттой холбоотой нийгмийн хандлагын индекс (reach, engagement rate)	Эхний шат: хийсэн баримтат контент ≥ 10 , үзэгчийн тоо ≥ 1 сая Дараагийн шат: хийсэн контент ≥ 30 , нийгмийн хандалтын индекс $\geq 70\%$	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
14		Зорилт 3.3: Гадаад хөрөнгө оруулалтыг татах – гадаадын үйлдвэрлэл, технологийн компаниудыг хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх.	Гадаад хөрөнгө оруулагчдад зориулсан “НҮТП-ийн хөрөнгө оруулалтын гарын авлага” гаргах	- Хөрөнгө оруулагчидтай байгуулсан урьдчилсан хэлэлцээрийн тоо - Хандалтын тоо	≥ 30 $\geq 10,000$
15	“НҮТП Investor Week” олон улсын хөрөнгө оруулалтын форум зохион байгуулах		- Форумд оролцсон улсын болон хөрөнгө оруулагчдын тоо - Хэлэлцээрийн тоо, дүн (тэрбум₮)	Эхний шат: оролцсон улс ≥ 15 , хөрөнгө оруулагч ≥ 100 , хэлэлцээр ≥ 20 Дараагийн шат: оролцсон улс ≥ 30 , хөрөнгө оруулагч ≥ 300 , хэлэлцээр ≥ 60 , дүн ≥ 500 тэрбум₮	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
16	Стратегийн салбарын (R&D, ногоон технологи гэх мэт) гадаад ААН-д татварын хөнгөлөлт олгох санал болгох		- Хөнгөлөлт авсан ААН-ийн тоо - Хэрэгжүүлсэн төсөл, хөрөнгө оруулалтын хэмжээ	≥ 50 ААН ≥ 30 төсөл ≥ 1 их наяд₮	2036–2040

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
17		“Гадаад түншлэл- Үйлдвэрлэлийн кластер” загвар төслүүд хэрэгжүүлэх	- Гадаад хамтын үйлдвэрүүдийн тоо - Хамтарсан төслөөс үүссэн ажлын байрны тоо	≥ 20 ≥ 5,000	2036–2040
18		Паркийн хөрөнгө оруулалтын бизнесийг олон улсын бирж, финтек платформд танилцуулах	- Танилцуулагдсан кейсийн тоо - Холбогдсон хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн тоо	Эхний шат: танилцуулсан кейс ≥ 20, хөрөнгө оруулалтын хэлэлцээр ≥ 10 Дараагийн шат: кейс ≥ 60, хөрөнгө оруулалтын хэлэлцээр ≥ 40	2031–2035 (эхлэх), 2036–2040 (тогтмолжуулах)
19	Зорилт 3.4: Импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх замаар дотоодын зах зээлийг хангах	Барилгын салбарт хэрэглэгддэг импортын бүтээгдэхүүний жагсаалт, орлох шийдлийн судалгаа хийх	- Судалгаанд хамрагдсан бүтээгдэхүүний тоо - Хамрагдсан орон нутгийн зах зээлийн эзлэх хувь	≥ 50 ≥ 30%	2031–2035
20		“Импорт орлох бүтээгдэхүүн” үйлдвэрлэлийг төрөөс үнэлэх баталгаажуулах тогтолцоо нэвтрүүлэх санал боловсруулах	- Гэрчилгээтэй бүтээгдэхүүний тоо - Импортын бүтээгдэхүүний орлуулалтын хувь (%)	≥ 100 ≥ 40%	2036–2040
21		Орон нутгийн төслүүдэд үндэсний бүтээгдэхүүн ашиглах зөвлөмж, квотын тогтолцоо нэвтрүүлэх	- Үндэсний бүтээгдэхүүн ашигласан төслүүдийн хувь - Нийт хангамж дахь үндэсний эзлэх хувь	≥ 60% ≥ 50%	2036–2040
22		“Made in Mongolia – Барилгын материал” сурталчилгааны аян хэрэгжүүлэх	- Хүрсэн иргэдийн тоо - Сэтгэгдэл, худалдан авалт нэмэгдсэн өсөлт (%)	Эхний шат: хүрсэн иргэд ≥ 200 мянга, хэрэглэгчийн санал сэтгэгдлийн өсөлт ≥ 20% Дараагийн шат: хүрсэн иргэд ≥ 500 мянга, хэрэглэгчийн санал, борлуулалтын өсөлт ≥ 50%	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөжүүлэх)
23		Импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ААН-д дэмжлэг үзүүлэх тусгай сан байгуулах	- Сангийн дэмжлэг авсан үйлдвэрүүдийн тоо - ААН-ийн дотоод нийлүүлэлтийн эзлэх хувь	Эхний шат: дэмжлэг авсан үйлдвэр ≥ 30, дотоод нийлүүлэлтийн эзлэх хувь ≥ 25% Дараагийн шат: дэмжлэг авсан үйлдвэр ≥ 80, дотоод нийлүүлэлтийн эзлэх хувь ≥ 50%	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөжүүлэх)

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
24	Зорилт 3.5: Зах зээлийн мэдээлэл, судалгааг чадавхжуулах – бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гинжин холбоог оновчтой болгох.	“Зах зээлийн тагнуул” дотоод дата систем хөгжүүлж, үнэ ханш, хангамжийн сүлжээ хянах	- Системд бүртгэлтэй мэдээллийн төрөл - Ашигласан хэрэглэгчийн тоо	≥ 50 ≥ 1,000	2031–2035
25		Салбарын зах зээлийн судалгааг улирал тутам хийж, тайлан хэлбэрээр түгээх	- Судалгааны тойм гаргасан тоо - Татаж авсан байгууллагын тоо	Эхний шат: жилд гаргасан судалгааны тайлан ≥ 4, татаж авсан байгууллага ≥ 50 Дараагийн шат: жилд тайлан ≥ 8, татаж авсан байгууллага ≥ 150	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
26		Түүхий эд, хангамжийн оновчлолын симуляци хийх программ хангамжийн шийдэл нэвтрүүлэх	- Симуляцид хамрагдсан ААН-ийн тоо - Үр ашиг нэмэгдсэн үйлдвэрлэлийн тоо (%)	≥ 100 ≥ 25%	2036–2040
27		Хэрэглэгчийн харилцааны суваг нэвтрүүлэх	- Борлуулалт сайжирсан бүтээгдэхүүний тоо - Хэрэглэгчийн хандалт нэмэгдсэн өсөлт (%)	Эхний шат: сайжруулсан бүтээгдэхүүний тоо ≥ 20, хэрэглэгчийн хандалт өсөлт ≥ 30% Дараагийн шат: бүтээгдэхүүний тоо ≥ 50, хэрэглэгчийн хандалт өсөлт ≥ 70%	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөтгөх)
28		Судалгаа, шинжилгээний нэгдсэн төв байгуулж, салбарын шинжилгээг тогтмол хийдэг болох	- Судалгааны байгууллагуудын хамтын тайлангийн тоо - Салбарын дүгнэлтийг ашигласан тоо	≥ 30 ≥ 100	2036–2040



Эдгээр нь УТП-ийн бизнесийн тогтвортой байдал, ашигт байдлыг тодорхойлох стратегийн зорилго юм. Энэ зорилгын амжилт дотоодын борлуулалт, экспортыг хослуулсан хос тулгуурт зах зээлийн систем дээр үндэслэгдэнэ. Олон улсын түншлэл, борлуулалтын платформ, чанарын баталгаажуулалт, брэндийн бодлого нь хамтад нь хэрэгжихгүй бол зөвхөн үйлдвэрлэл төвтэй хөгжлийн загвар нурах эрсдэлтэй.

Зөвлөмж

Экспортын бэлэн байдлын хөтөлбөр хэрэгжүүлж, экспортод чиглэсэн компаниудыг шат дараатай бэлдэх: Стандартад нийцэх, гэрчилгээ авах, сав баглаа, брэнд, логистик зэрэг бүх асуудалд чиглэсэн цогц арга хэмжээ

Монголын экспортын дэмжих үндэсний байгууллагатай хамтран ажиллах: Хамтын брэнд хөгжүүлэлт, үзэсгэлэн, сурталчилгаанд нэгтгэсэн оролцоо бий болгох

Хил дамнасан логистикийн шийдэл төлөвлөх: Улаанбаатар–Замын-Үүд, Налайх–Хөшигтийн хөндий–Туушин төв шугамын дагуу тээврийн урсгалыг төлөвлөх

Олон улсын чанарын гэрчилгээ олгох эрх бүхий лаборатори, нэгж байгуулж, ISO 17025 болон ISO 17065 стандартын дагуу итгэмжлүүлэх: Сорил, гэрчилгээ Монголд хийгдэж, хүлээн зөвшөөрөгдөх суурь үүсгэнэ

Дижитал худалдааны төв байгуулах: E-commerce, B2B болон логистикийн платформуудтай API холболт хийх

Стратегийн зорилт 4: Институцийн чадавх, бодлого, зохицуулалтыг сайжруулах

Үйлдвэрлэл, инновац, хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой, үр ашигтайгаар удирдах засаглалын бүтэц, дижитал дэд бүтэц, хүний нөөцийн бодлого, хамтын ажиллагааны механизм, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилго.

4.1. Хуулийн эрх зүйн орчин, бодлогын уялдааг хангах

- ✓ УТП-ийн үйл ажиллагаанд холбогдох газрын ашиглалт, татвар, дэмжлэг, чанар, эрчим хүчний зохицуулалт зэрэг бодлого, хууль эрх зүйн шинэчлэл зайлшгүй шаардлагатай
- ✓ Төрийн агентлаг, орон нутгийн засаг захиргаатай хамтын бодлогын уялдаа бий болгох шаардлагатай

4.2. Удирдлага, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх

- ✓ Чадамжид суурилсан хүний нөөцийн бодлого хэрэгжүүлснээр УТП-ийн гүйцэтгэлийн чанар, институцийн тогтвортой байдал хангагдана
- ✓ Карьер, манлайлал, гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшууллын бодлогыг нэвтрүүлэх

4.3. Мэдээллийн технологийн дэд бүтцээ сайжруулах

- ✓ ERP, BI системүүд нэвтрүүлснээр өрсөлдөх чадварын үндэс болох өгөгдөлд суурилсан удирдлага бий болно



- ✓ Хүний нөөц, санхүү, ханган нийлүүлэлт, шийдвэр гаргалт ил тод, мэдээллийн сан бүрдсэн байх болно

4.4. ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙН ЗАГВАРЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ

- ✓ Кластерын оролцогч талууд болох төр-их сургууль-үйлдвэр загварын институцийн хамтын ажиллагаа нь инновацын суурь нөхцөл
- ✓ Гадаад, дотоодын технологийн парк, судалгааны байгууллагуудтай платформ, консорциум байгуулах

4.5. САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖМЕНТИЙГ УЯЛДУУЛАХ

- ✓ Мэдээлэл түгээх, олон нийттэй харилцах бодлогыг системчлэх нь оролцогч талуудын итгэлцлийг бэхжүүлнэ
- ✓ “Нээлттэй Парк” концепц: Шилэн тайлагнал, нээлттэй өгөгдөл, инфографик, олон нийтийн дэмжлэг

Стратегийн дөрөвдүгээр зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

- ✓ Хууль эрх зүйн орчны дутагдал – УТП-ийн тусгай статустай холбоотой хууль, журмын уялдаа хангалтгүй
- ✓ Удирдлагын тогтворгүй байдал – институцийн менежмент байнга өөрчлөгдвөл итгэлцэл, хөрөнгө оруулалтын урсгалд сөргөөр нөлөөлнө
- ✓ Мэдээллийн систем нэвтрүүлэх чадамж – ERP, BI зэрэг систем нэвтрүүлэхэд өндөр мэргэшил шаарддаг
- ✓ Түншлэл үр дүнд хүрэхгүй байх эрсдэл – байгууллагуудын эрх ашиг зөрчилдөж, түншлэлийн загвар нурж болзошгүй
- ✓ Нээлттэй мэдээллийн менежмент – олон нийтийн мэдээлэлтэй харилцах бодлого зохион байгуулалтгүй бол сөрөг сэтгэгдэл үүсэх эрсдэлтэй

Хүснэгт 1. 4. НҮТП-ийн урт хугацааны стратегийн зорилго 4-ийн хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр нөлөө

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилт 4: Институцийн чадавх, бодлого, зохицуулалтыг сайжруулах				
2	Зорилт 4.1: Хуулийн эрх зүйн орчин, бодлогын уялдааг хангахад хувь нэмэр оруулах	“Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн орчин”-д шинжилгээ хийх, санал боловсруулах	- Боловсруулсан саналын тоо - Тусгагдсан хууль, журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тоо	≥ 20 ≥ 10	2031–2035
3		“ҮТП-д чиглэсэн бодлогын шинэтгэлийн зөвлөлийг” байгуулахад оролцох	- Зөвлөлийн хуралдааны тоо - Шийдвэрт нөлөөлсөн бодлогын баримтын тоо	Эхний шат: зөвлөлийн хуралдааны тоо ≥ 10, бодлогын баримтад орсон санал ≥ 15 Дараагийн шат: хуралдааны тоо ≥ 30, орсон санал ≥ 40	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөтгөх)
4		Паркийн дэд бүтцэд зориулсан хөрөнгө оруулалтын хуулийн шинэ санал боловсруулах	- Хууль, тогтоолын төсөл боловсруулсан тоо - Батлагдсан бодлогын саналын хэрэгжилт (%)	≥ 5 ≥ 60%	2036–2040
5		Үндэсний стандарт, техникийн зохицуулалтын уялдаа сайжруулах стратеги боловсруулах	- Стандартын уялдааг сайжруулсан тоо - Хугацаа богиноссон төрийн үйлчилгээний тоо (%)	≥ 50 ≥ 80%	2036–2040
6		Хөгжлийн бодлогын баримт бичигт паркийн үүргийг системтэй тусгах судалгаа хийх	- Бодлогын баримт бичигт туссан ҮТП-үүдийн тоо - Уялдсан төслүүдийн санхүүжилтийн өсөлт (%)	≥ 5 ≥ 50%	2031–2035
7		Зорилт 4.2: Удирдлага, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх	Паркийн удирдлагын манлайллын чадамжийг үнэлэх, хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	- Хөгжүүлсэн манлайллын сургалтын тоо - Удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээний өсөлт (%)	≥ 10 ≥ 20%
8	Зорилт 4.2: Удирдлага, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх	“Хүний нөөцийн стратеги 2040” баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх	- Стратеги баримт бичгийн хэрэгжилтийн түвшин - Ажиллах хүчний тогтвортой байдлын индекс (%)	≥ 70% ≥ 80%	2031–2035
9		Шилдэг ажилтан–албан тушаалын замнал, карьер	- Карьер дэвшсэн ажилтны тоо	≥ 200 ≥ 85%	2036–2040

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
		хөгжүүлэлтийн тогтолцоо нэвтрүүлэх	- Байгууллагын сэтгэл ханамжийн үнэлгээ (%)		
10		Чадварын үнэлгээний систем, гүйцэтгэлийн KPI-г автоматжуулах	- Автомат үнэлгээнд хамрагдсан ажилтны тоо - KPI гүйцэтгэлийн уялдаа сайжирсан хувь (%)	≥ 3,000 ≥ 30%	2036–2040
11		Салбар доторх манлайлагчдыг сургаж, “паркийн мэргэжилтэн”-ий сүлжээ бий болгох	- Мэргэшсэн ажилтны тоо - Олон нийттэй хийсэн харилцааны дундаж хүрэлт (reach)	≥ 1,000 ≥ 200,000	2031–2035
12	Зорилт 4.3: Мэдээллийн технологийн дэд бүтцээ сайжруулах	“Дижитал паркийн менежмент” систем хөгжүүлэх	- Автоматжуулсан процессын тоо - Системийг өдөр тутам ашиглаж буй хэрэглэгчийн тоо	≥ 20 ≥ 100	2031–2035 (туршилт), 2036–2040 (бүрэн хэрэгжүүлэх)
13		Интеграцлагдсан ERP + CRM системийг ААН-үүдэд санал болгон нэвтрүүлэх	- Нэвтрүүлсэн ААН-ийн тоо - Ашиглалтаас үүдэлтэй өгөөжийн өсөлт (%)	≥ 200 ≥ 25%	2036–2040
14		ҮТП-ийн дата төв, серверийн өргөтгөл, мэдээллийн нөөцлөлтийн систем байгуулах	- Серверийн хүчин чадал (ТВ) - Нөөцлөгдөж буй датагийн хэмжээ	≥ 200 ТВ ≥ 1 PB	2031–2035
15		“Цахим хяналт-шинжилгээ” дотоод мэдээллийн самбар бий болгох	- Нээлттэй самбарын тоо (dashboard) - Ашиглаж буй тайлангийн тоо	≥ 10 ≥ 200	2036–2040
16		Ажлын байр бүрд ухаалаг тоног төхөөрөмж, нэгдсэн сүлжээгээр холбогдох шийдэл хэрэгжүүлэх	- Холбогдсон төхөөрөмжийн тоо - Цахим бичиг баримтын эргэлтийн хурд (%)	≥ 10,000 ≥ 70%	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
17	Зорилт 4.4: Хамтын ажиллагаа, түншлэлийн	“НҮТП–ААН–Их сургууль” 3 талт түншлэлийн стратеги хэрэгжүүлэх	- Хамтарсан төсөл эхлүүлсэн байгууллагын тоо - Гэрээний хүрээнд хийсэн судалгаа, сургалтын тоо	≥ 20 ≥ 30	2031–2035

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
18	загварыг өргөжүүлэх	“ҮТП хамтын ажиллагааны платформ” бий болгож, түншлэлийн өгөгдөл, хэлцлийн суваг нээх	- Платформд бүртгэгдсэн түншийн тоо - Платформоор дамжсан хэлцэл, хамтын төсөл	≥ 200 ≥ 100	2036–2040
19		ААН, төр, гадаад байгууллагын санхүүжилттэй хамтарсан төслийн менежментийн загвар нэвтрүүлэх	- Нэвтрүүлсэн PPP хэлбэрийн төсөл - Хөрөнгө оруулалтын хэмжээ (тэрбум₮)	≥ 20 ≥ 500 тэрбум₮	2036–2040
20		Олон улсын хамтын ажиллагааны зөвлөл байгуулах	- Гишүүн байгууллагын тоо - Тус зөвлөлөөс эхлүүлсэн түншлэлийн тоо	Эхний шат: гишүүн байгууллага ≥ 10, эхлүүлсэн түншлэл ≥ 15 Дараагийн шат: гишүүн байгууллага ≥ 30, эхлүүлсэн түншлэл ≥ 50	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөжүүлэх)
21		“Паркийн нээлттэй түншлэл” жил бүрийн чуулга уулзалт зохион байгуулах	- Оролцогчдын тоо - Чуулганаар батлагдсан түншлэлийн санамж бичгийн тоо	Эхний шат: оролцогч ≥ 200, батлагдсан түншлэлийн санал ≥ 30 Дараагийн шат: оролцогч ≥ 500, батлагдсан санал ≥ 80	2031–2035 → (эхлэх), 2036–2040 (тогтмолжуулах)
22		“Үйлчилгээний стандартчилсан протокол” боловсруулж, паркийн бүх үйлчилгээнд нэвтрүүлэх	- Протоколд нийцсэн үйлчилгээний тоо - Сэтгэл ханамжийн индекс (%)	≥ 30 ≥ 85%	2036–2040
23	Зорилт 4.5: Салбарын дэд бүтэц, үйлчилгээний менежментийг уялдуулах	Олон нийтэд нээлттэй тайлагнах боломж бүрдүүлэх	- Самбарт оруулсан шинэ мэдээллийн тоо - Хандалт, оролцооны тоо	≥ 200 ≥ 100	2031–2035
24		Хэвлэл мэдээллийн стратеги боловсруулах, олон нийтэд чиглэсэн контент цуврал гаргах	- Контентын хандалт, сэтгэгдэл - Сурвалжилсан хэвлэл мэдээллийн байгууллагын тоо	≥ 1 сая ≥ 80%	2031–2035



№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
25		Үйлчилгээний санал гомдлын нэгдсэн систем, дата бүртгэлийг нэвтрүүлэх	- Ирүүлсэн гомдлын шийдвэрлэсэн хувь (%) - Хянагдсан үйлчилгээнүүдийн тоо	≥ 90% ≥ 200	2036–2040
26		“Нэгдсэн үйлчилгээний төв” байгуулах (one-stop service hub)	- Үйлчилгээний төрөл - Дундаж үйлчилгээг авах хугацааны бууралт (%)	≥ 50 ≥ 30% буурсан	2036–2040



Энэхүү зорилго нь НҮТП-ийн институцийн суурь тогтолцоог орчин үеийн, үр ашигтай, итгэлцэлд суурилсан загвар болгон бэхжүүлэхэд чиглэнэ. Хэдий бүтээгдэхүүн үйлдвэрлэл чухал ч, түүнийг удирдах “институцийн бодлого” буюу дотоод зохион байгуулалтгүйгээр тогтвортой амжилт гарахгүй. Институцийн шинэчлэл нь зөвхөн дотоод журам, бүтэц биш, харьцангуй хараат бус, өгөгдөлд суурилсан, хариуцлагатай соёл төлөвшүүлэх стратегийн үйлдэл юм.

Зөвлөмж

- ✓ Засгийн газар, УБ хотын захиргааны дэмжлэгтэйгээр паркийн тусгай татварын, дэмжлэгийн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх. Шаардлагатай тохиолдолд “ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай” хуулийн өөрчлөлтөд санал оруулах
- ✓ Төслийн удирдлагын нэгж болон мэдээлэл дамжуулах нэгж байгуулах. Стратеги, төлөвлөлт, хүний нөөц, мэдээллийн системийг төвлөрүүлсэн шинэтгэлийн баг
- ✓ Түншлэлийн удирдлагын бодлого боловсруулах. Их сургууль, R&D, бизнес, орон нутаг зэрэг бүхий л оролцогч талуудтай хамтран ажиллах хүрээ, хариуцлагын матриц тодорхойлох
- ✓ ISO 9001 (Чанарын удирдлагын тогтолцоо), ISO 30414 (Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал) стандартыг үе шаттай нэвтрүүлэх
- ✓ Шилэн менежментийн дата платформ хөгжүүлж, нээлттэй мэдээллийн загвар хэрэгжүүлэх. Зах зээл, хөрөнгө оруулагч, олон нийттэй харилцахад суурь итгэлцэл бий болно

Стратегийн зорилт 5: Байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжих

Үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжил нь байгаль орчин, уур амьсгалын тогтвортой байдалд нийцтэй, нийгмийн эрэлт хэрэгцээнд суурилсан, ажиллах хүчний амьдрах орчныг сайжруулах бодлогоор дамжин урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангана.

5.1. ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАН ЯЛГАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ

- ✓ Барилгын үйлдвэрлэлийн хаягдал, дулаан, ус зэрэг бохирдол үүсгэх хүчин зүйлсийг бууруулах, хог хаягдлыг дахин боловсруулах (circular economy) систем нэвтрүүлэх
- ✓ Цэвэрлэх байгууламж, хаягдлын ангиллын стандартыг ҮТП-д тогтоох

5.2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГ, СЭРГЭЭГДЭХ ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙГ АШИГЛАХ

- ✓ Нарны, салхины болон дахин ашиглах боломжтой эх үүсвэрийг төвлөрсөн хангамжтай хослуулах
- ✓ Үйлдвэрүүдийн эрчим хүчний хэрэглээг хянах “ухаалаг хэмнэлт” системүүдийг нэвтрүүлэх

5.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДАГЫН СИСТЕМИЙГ БЭХЖҮҮЛЭХ

- ✓ ISO 14001 зэрэг олон улсын стандартуудыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн экологийн ул мөрийг бууруулах
- ✓ Байгаль орчны нөлөөллийн урьдчилсан болон явцын мониторингийг хийдэг дотоод хяналтын нэгжтэй болох



5.4. НОГООН БАЙГУУЛАМЖ, АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

- ✓ УТП нь зөвхөн үйлдвэрлэлийн цогцолбор биш, харин амьдрах, амрах, сурч хөгжих орчныг хамарсан хэлбэрээр хөгжих ёстой
- ✓ Цэцэрлэгт хүрээлэн, зүлэг, мод бут сөөг, спортын талбай зэрэг орчны элементүүдийг нэвтрүүлэх

5.5. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- ✓ “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Орон сууцны хөтөлбөр”, “Нийтийн тээврийн хүртээмж”, “Төрийн үйлчилгээний хүртээмж” зэрэг үйлчилгээний хангамжийг багтаасан нийгмийн хариуцлагын загвар хэрэгжүүлэх
- ✓ Төрийн үйлчилгээ, нэг цэгийн төв, эмнэлэг, цэцэрлэг, нийгмийн дэд бүтэц УТП-ийн хөгжлийн нэг хэсэг байх шаардлагатай

Стратегийн тавдугаар зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

- ✓ Хог, бохирдлын стандарт, хяналтын орчин сул – нэгдсэн стандарт, дүрэм журмын уялдаа бүрдээгүй
- ✓ Сэргээгдэх эрчим хүчний өртөг өндөр, анхны хөрөнгө оруулалт их – хувийн хэвшлийн идэвх сул байж болзошгүй
- ✓ ISO болон бусад олон улсын стандартын баталгаажуулалт, мониторинг хэрэгжилтгүй байх эрсдэл
- ✓ Ногоон байгууламжийг арчлах, хамгаалах урт хугацааны менежмент дутмаг – үр ашиггүй хөрөнгө оруулалт болох эрсдэлтэй
- ✓ Нийгмийн үйлчилгээний бүтэц нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй бол орон нутгийн иргэдийн дэмжлэг суларна

Энэхүү зорилго нь УТП-ийн экологийн болон нийгмийн тогтвортой байдлыг баталгаажуулах үндэс суурь юм. Хэрэв зөв хэрэгжүүлбэл НҮТП нь “байгальд ээлтэй үйлдвэрлэлийн төв” гэсэн улсын брэнд статус авах боломжтой. Энэ зорилго нь гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудын ESG үнэлгээнд эергээр нөлөөлнө.

Зөвлөмж

“Ногоон парк” хөгжлийн дэд стратеги боловсруулж, SDG (Тогтвортой хөгжлийн зорилтууд)-тай уялдуулах: НҮТП нь үндэсний түвшинд анхны “Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн УТП” болж чадна.

Ногоон санхүүжилт, уур амьсгалын олон улсын сангуудтай уялдсан төсөл хэрэгжүүлэх: GCF, GEF, JCM, ADB Climate Fund зэрэг эх үүсвэрээс хөрөнгө татах боломжийг эрэлхийлнэ.

Үйлдвэр бүрийг “environmental compliance matrix”-аар үнэлж, урамшууллын механизм нэвтрүүлэх: Байгальд ээлтэй үйлдвэрүүд татварын хөнгөлөлт, дэмжлэг эдэлнэ.

Орон нутгийн оролцоог хангах “Нээлттэй парк” өдөрлөг, мэдээллийн хөтөлбөр хэрэгжүүлэх: Итгэлцлийг бий болгож, нийгмийн эсэргүүцлээс урьдчилан сэргийлнэ.

Эко инновацийн төв, хог дахин боловсруулах цех, байгаль орчны лаборатори зэрэг “EcoHub” байгуулах: Цогц шийдлээр байгаль орчны асуудлыг системтэй шийднэ.

Хүснэгт 1. 5. НҮТН-ийн урт хугацааны стратегийн зорилго 5-ын хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр нөлөө

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилт 5: Байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжих				
2	Зорилт 5.1: Тогтвортой хэрэглээ, хог хаягдлын менежмент	Хог хаягдлыг ангилан ялгах төвлөрсөн систем, зориулалтын сав суурилуулах	- Ангилан ялгасан хогны эзлэх хувь (%) - Нийт дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ (тн)	≥ 50% ≥ 100 мян. Тн	2031-2035
3		Дахин боловсруулалт, хоёрдогч түүхий эдийн боловсруулах жижиг үйлдвэрлэл байгуулах	- Боловсруулсан материалын тоо төрөл - Үүссэн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувь (%)	≥ 30 ≥ 20%	2036-2040
4		“Zero Waste Park” уриа дор хог хаягдлын цогц менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх	- Хог хаягдлын бууралт (% жилд) - ААН-үүдийн хог хаягдлын менежмент сайжирсан хувь (%)	≥ 10% ≥ 50%	2036-2040
5		ААН-үүдэд зориулсан хаягдлын бүртгэл, тайлагналын цахим платформ хөгжүүлэх	- Тайлагнасан ААН-ийн тоо - Тохирсон стандартын дагуух менежменттэй ААН-ийн хувь (%)	≥ 300 ≥ 60%	2031-2035
6		Хог хаягдлын боловсруулалт, сэргээгдэх нөөцийн сургалт, урамшууллын систем нэвтрүүлэх	- Хамрагдсан хүний тоо - Сэргээгдэх түүхий эдийн ашиглалтыг нэмэгдүүлсэн хувь (%)	Эхний шат: сургалтад хамрагдсан ≥ 1,000 хүн, дахин ашиглалтыг нэмэгдүүлсэн хувь ≥ 20% Дараагийн шат: хамрагдсан ≥ 3,000 хүн, дахин ашиглалтыг нэмэгдүүлсэн хувь ≥ 50%	2031-2035 (эхлээд), 2036-2040 (өргөжүүлэх)
7		Зорилт 5.2: Эрчим хүчний ногоон хөтөлбөр	Нар, салхи, биомасс зэрэг эх үүсвэрт суурилсан жижиг СЭХ станц байгуулах	- СЭХ-ийн суурилагдсан хүчин чадал (МВт) - СЭХ ашигласан нийт эрчим хүчний хувь (%)	≥ 200 МВт ≥ 30%
8	Үйлдвэрүүдэд зориулсан “ногоон гэрчилгээ” олгох тогтолцоо бүрдүүлэх		- Ногоон гэрчилгээтэй ААН-ийн тоо - СЭХ хэрэглэж буй үйлдвэрлэлийн хувь (%)	Эхний шат: гэрчилгээтэй ААН ≥ 100 Дараагийн шат: гэрчилгээтэй ААН ≥ 300, СЭХ ашигласан хувь ≥ 50%	2031-2035 (эхлээд), 2036-2040 (өргөжүүлэх)
9	Эрчим хүчний үр ашигт хэрэглээг дэмжих урамшууллын бодлого хэрэгжүүлэх		- Эрчим хүчний хэмнэлтийн хэмжээ (MWh) - Урамшуулалд хамрагдсан ААН-ийн тоо	≥ 50,000 MWh ≥ 200	2031-2035

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
10		Барилга, үйлдвэрийн дулаан алдагдлын хяналтын аудит, зөвлөмжийн систем хөгжүүлэх	- Хяналт хийсэн барилга байгууламжийн тоо - Аудитаар шийдэгдсэн зардал буурсан хувь (%)	≥ 500 ≥ 25%	2036–2040
11		Цахилгаан хэрэглээнд IoT, ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх	- Ухаалаг системд холбогдсон төхөөрөмжийн тоо - Тоон хяналтын хэрэглээний өсөлт (%)	Эхний шат: холбогдсон төхөөрөмж ≥ 20,000, хэрэглээний хяналтын өсөлт ≥ 30% Дараагийн шат: холбогдсон төхөөрөмж ≥ 60,000, хяналтын өсөлт ≥ 70%	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөжүүлэх)
12	Зорилт 5.3: Байгаль орчинд ээлтэй техник, технологи нэвтрүүлэх	“Ногоон техник, технологийн лавлах төв” байгуулж стандарт, зөвлөмжийг боловсруулах	- Бүртгэгдсэн ногоон технологийн тоо - Хэрэглээнд орсон лавлагаа шийдлийн хувь (%)	≥ 50 ≥ 40%	2031–2035
13		Үйлдвэрлэлийн процессын эко шинэчлэлийн үнэлгээ, дизайн зөвлөх үйлчилгээ үзүүлэх	- Үнэлгээ хийсэн процессын тоо - Дизайн сайжруулсан үйлдвэрлэлийн хувь (%)	≥ 200 ≥ 30%	2036–2040
14		Ногоон түүхий эдийн судалгаа, нутагшуулалтын төсөл хэрэгжүүлэх	- Судалсан түүхий эдийн төрөл - Шинээр үйлдвэрлэлд орсон ногоон материалын хувь (%)	Эхний шат: судалсан түүхий эдийн төрөл ≥ 20, үйлдвэрлэлд орсон материал ≥ 15% Дараагийн шат: төрөл ≥ 50, үйлдвэрлэлд орсон материал ≥ 40%	2031–2035 (эхлээд), 2036–2040 (өргөжүүлэх)
15		Ногоон шийдэлд шилжсэн ААН-д татварын урамшуулал олгох бодлого хэрэгжүүлэх	- Урамшуулал авсан ААН-ийн тоо - Ногоон процесс нэвтрүүлсэн үйлдвэрлэлийн өсөлт (%)	≥ 200 ≥ 35%	2036–2040
16		Эко бүтээгдэхүүний брэнд болон экспортын дэмжлэгийн тусгай шугам байгуулах	- Экспортод гарсан эко бүтээгдэхүүний тоо - Нэмэгдсэн экспортын орлого (тэрбум₮)	≥ 100 ≥ 300 тэрбум₮	2036–2040
17		Зорилт 5.4: Хүрээлэн буй орчин,	Паркийн талбайг бүсчлэн ногоон байгууламжаар хангах	- Ногоон байгууламжийн талбайн хэмжээ (га) - Нэг ажилтанд ноогдох ногоон бүс (м ²)	Эхний шат: ногоон байгууламж ≥ 50 га, нэг

№	Зорилтууд	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт (KPI)	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
	экосистемд ээлтэй орчин бүрдүүлэх			ажилтанд ногдох талбай $\geq 10 \text{ м}^2$ Дараагийн шат: нийт ≥ 150 га, нэг ажилтанд $\geq 25 \text{ м}^2$	2036–2040 (өргөжүүлэх)
18		Хаягдал ус цэвэршүүлэх байгууламжийг өргөтгөж, дахин ашиглалтад оруулах	- Цэвэрлэсэн хаягдал усны хэмжээ (м^3) - Дахин ашигласан усны хувь (%)	≥ 2 сая м^3 $\geq 40\%$	2036–2040
19		Эко барилгын шийдлийг стандартад нийцүүлэн төсөлд тусгах	- Стандарттай барилга байгууламжийн тоо - Эрчим хүч, усны хэмнэлттэй барилгын хувь (%)	≥ 30 $\geq 20\%$	2031–2035
20		Дуу чимээ, агаарын бохирдлын хяналтын ухаалаг мэдрэгч систем суурилуулах	- Суурилуулсан мэдрэгчийн тоо - Илэрсэн бохирдлын бууралтын хувь (%)	≥ 200 $\geq 25\%$	2036–2040
21		Амьтан, ургамлын олон янз байдал хадгалах "экологийн бүс" байгуулж хамгаалах	- Эко бүсийн талбайн хэмжээ (га) - Хамгаалсан зүйлсийн тоо, нөхөн сэргээсэн төрөл	≥ 100 га ≥ 50	2036–2040
22	Зорилт 5.5: Уур амьсгалын өөрчлөлтийн бодлогыг дэмжих	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох менежментийн төлөвлөгөө боловсруулах	- Бодлого батлагдсан огноо - Хэрэгжилтэд хамрагдсан байгууллагын тоо	≥ 1 ≥ 50	2031–2035
23		Үер, ган, зуд зэрэгт тэсвэртэй дэд бүтцийн загвар төлөвлөх	- Дасан зохицсон барилга/төсөл - Хохирол бууруулсан тохиолдлын хувь (%)	≥ 20 $\geq 30\%$	2036–2040
24		Уур амьсгалын индикатор бүхий цахим хяналтын платформ хөгжүүлэх	- Индикаторын тоо - Ашиглалттай тайлан, графикийн тоо	Эхний шат: индикатор ≥ 20 , ашигласан тайлан ≥ 50 Дараагийн шат: индикатор ≥ 50 , ашигласан тайлан ≥ 200	2031–2035 (эхлэх), 2036–2040 (өргөтгөх)
25		Олон улсын "Climate finance" хөтөлбөрт хамрагдах, уур амьсгалын төсөлд хөрөнгө татах	- Хамрагдсан олон улсын хөтөлбөрийн тоо - Хөрөнгө татсан хэмжээ (тэрбум₮)	≥ 15 ≥ 500 тэрбум₮	2036–2040
26		"Уур амьсгалд тэсвэртэй үйлдвэрлэл"-ийн стандарт нэвтрүүлж, гэрчилгээжүүлэх тогтолцоо бий болгох	- Стандарт баталсан огноо - Гэрчилгээ авсан ААН-ийн тоо	≥ 5 ≥ 100	2031–2035

Дунд хугацааны стратеги (2025–2030)

2025–2030 онд НҮТП нь дараах стратегийн зорилгуудыг хэрэгжүүлнэ. Эдгээр зорилго, зорилт нь үндэсний болон бүс нутгийн хөгжлийн бодлого, инновац, кластер хөгжүүлэлт, дотоод зах зээл ба экспортын бодлоготой уялдан бүрдсэн байна. Стратегийн зорилгууд болон зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, үйл ажиллагааг дараах хүснэгтүүдээр харууллаа.

Хүснэгт 1. 6. НҮТП-ийн дунд хугацааны стратегийн зорилго 1-ийн хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр дүн

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилго 1: Үйлдвэрлэл, технологийн кластерын бүтцийг бэхжүүлэх					
2	Зорилт 1.1: Паркийн инженерийн болон нийгмийн дэд бүтцийг бүрэн ашиглалтад оруулах	Инженерийн дэд бүтцийн өргөтгөл хийх (ус, дулаан, цахилгаан, бохир)	Үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаар холбогдох боломж бүрдэнэ	Дэд бүтцэд холбогдсон үйлдвэрүүдийн хувь	100%	2025–2026
3		Нийгмийн дэд бүтцийн байгууламж барих (орон сууц, үйлчилгээний төв)	Ажиллах хүч тогтвортой байршиж, үйлчилгээний хүртээмж сайжирна	Шинэ байгууламжийн тоо	3	2025–2027
4		Инженерийн шугам сүлжээний техник хяналтын систем суурилуулах	Үйлчилгээний найдвартай байдал сайжирна	Техник хяналтын системтэй шугамын хувь	100%	2026
5		Нэгдсэн ДБТС (Дэд Бүтцийн Төвлөрсөн Систем) байгуулах	Төлөвлөлт, хяналт, удирдлагын уялдаа сайжирна	Нэгдсэн системтэй нэгжийн тоо	1	2025-2026
6		Олон улсын стандартын дагуу инженерийн сүлжээний зураглал хийх	Бүтээн байгуулалтын уялдаа хангагдана	Зураглалаар бүрэн хамрагдсан талбайн хувь	100%	2025
7	Зорилт 1.2: Барилгын материалын холбогдох үйлдвэрлэлүүдийн цогцолбор, бүсийг байгуулах	Барилгын материалын үйлдвэрлэлийн цогцолбор төлөвлөх, зургийн даалгавар боловсруулах	Кластер хөгжлийн суурь тавигдана	Батлагдсан зураг, ТЭЗҮ	1 иж бүрэн	2025
8		Орчин үеийн технологитой тоосго, хөнгөн блокны үйлдвэр байгуулах	Импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ	Үйлдвэрийн тоо	1-2	2026-2028
9		Шил, дулаан тусгаарлагч материалын туршилтын шугам нээх	Инновац бүтээгдэхүүн хөгжүүлэлт эхэлнэ	Туршилтын нэгж	1	2026
10		Кластерын үндсэн гишүүдийг сонгон шалгаруулж нэвтрүүлэх	Үйлдвэрүүдийн уялдаа сайжирна	Нэвтэрсэн үйлдвэрүүдийн тоо	15	2025-2026

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
11		Кластерын логистик, түүхий эдийн нийлүүлэлтийн төв байгуулах	Зардал буурч, үйлдвэрлэлийн үр ашиг нэмэгдэнэ	Нийлүүлэлтийн төвийн тоо	1	2028-2030
12	Зорилт 1.3: Үйлдвэрлэлийн орчныг стандартчилж, чанарын баталгаажуулалтыг хангах	Чанар, стандартын лаборатори байгуулах	Бүтээгдэхүүний баталгаажуулалт, итгэлцэл нэмэгдэнэ	Баталгаажсан бүтээгдэхүүний тоо	50+	2026-2027
13		Үйлдвэрлэлийн техникийн хяналтын тогтолцоо бүрдүүлэх	Үйлдвэрлэлийн алдаа буурч, чанар сайжирна	Тохирлын гэрчилгээтэй ААН-ийн тоо	30+	2026
14		Судалгаа шинжилгээний төв ажиллуулах	Шинэ бүтээгдэхүүн, инновац хөгжүүлэлт идэвхэжнэ	Хийгдсэн судалгааны тоо	10	2025-2027
15		Үйлдвэрүүдийн стандартад нийцсэн удирдамж боловсруулах	Үйлдвэрлэл стандартжиж, тэгш нөхцөл бүрдэнэ	Батлагдсан удирдамжийн тоо	5	2026
16		Үйлдвэрүүдийн чанарын дотоод хяналтын сургалт явуулах	Ажилтнуудын ур чадвар нэмэгдэж, алдаа буурна	Сургалтад хамрагдсан хүний тоо	Бүх ажилчид	2025-2026
17	Зорилт 1.4: Дагаж хөгжих ЖДҮ, технологийн инновац, гарааны бизнесийг дэмжих таатай орчныг бүрдүүлэх	Бизнес инкубатор төв байгуулах	Гарааны бизнесүүдийн орчны дэмжлэг сайжирна	Инкубаторт хамрагдсан стартапын тоо	20	2026-2027
18		ЖДҮ-д зориулсан түрээсийн талбай гаргах	Зардлын дарамт буурч, тогтвортой үйл ажиллагаа бүрдэнэ	Хамрагдсан ЖДҮ-ийн тоо	30	2025-2027
19		Санхүүгийн болон бизнес зөвлөгөөний баг ажиллуулах	Эдийн засгийн чадамжтай ААН-үүд нэмэгдэнэ	Зөвлөгөө авсан ААН-ийн тоо	100	2026-2027
20		Стартап уралдаан, питч эвент жил бүр зохион байгуулах	Шинэ санаа, хөрөнгө оруулалт холбогдоно	Хамрагдсан багийн тоо	25+	2025-2030
21		Инновац хөгжүүлэлтийн хамтарсан лаборатори байгуулах	Дагаж хөгжих бизнесүүдийн технологийн чадамж сайжирна	Лабораторид туршсан бүтээгдэхүүний тоо	30	2026-2028
22	Зорилт 1.5: Мэргэжлийн боловсон	Үйлдвэрлэлийн чиглэлийн сургалтын төв байгуулж, шинэ хөтөлбөр нэвтрүүлэх	Бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн тоо нэмэгдэнэ	Сургалтад хамрагдсан хүний тоо	300+	2025-2027

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
23	хүчний чадавхыг сайжруулах	Сургалт-үйлдвэрлэлийн хосолмол хөтөлбөр хэрэгжүүлэх	Ажилд орох ур чадвартай боловсон хүчний хангалт сайжирна	Хөтөлбөрт хамрагдсан төгсөгчдийн хувь	80%	2026-2030
24		Мэргэжилтэн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх	Олон улсын туршлага, шилдэг практик нутагшина	Оролцсон мэргэжилтний тоо	50	2026-2028
25		Үйлдвэрүүд дээр практик дадлагын хөтөлбөр хэрэгжүүлэх	Оюутан, суралцагчдын практик чадвар дээшилнэ	Дадлагын тоо/жилд	50+	2025-2030
26		Ажлын байрны байнгын үнэлгээ, мэргэжлийн ур чадварын оношилгоо нэвтрүүлэх	Чадавхад суурилсан хүний нөөцийн менежмент төлөвшинө	Үнэлгээ хийгдсэн ажилтны хувь	90%	2027-2030

Хүснэгт 1. 7. НУТП-ийн дунд хугацааны стратегийн зорилго 2-ийн хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр дүн

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилго 2: Технологи, инновацыг чадавхыг хөгжүүлэх					
2	Зорилт 2.1: Судалгаа, шинжилгээ, инновацын төв байгуулах	Барилгын материалын шинжилгээний төвийн зураг төсөл боловсруулах, байгуулах	Судалгаа, туршилт, бүтээгдэхүүний баталгаажуулалт хийх суурь бүтэц бүрдэнэ	Төвийн ашиглалтад орсон огноо	2026	2025-2026
3		Барилгын материалын туршилт, баталгаажуулалтын лаборатори чанарын баталгаажуулалт авах	Туршилтын үр дүн олон улсын хүлээн зөвшөөрөлттэй болно	Итгэмжлэгдсэн лабораторийн статус	ISO/IEC 17025 стандарт хангасан	2027
4		Барилгын материалын шинэ технологийн туршилтын багц бүтээгдэхүүн хөгжүүлэх	Импорт орлох дотоодын инновац бүтээгдэхүүн бий болно	Хөгжүүлсэн шинэ бүтээгдэхүүний тоо	5	2026-2028
5		Судалгааны багуудыг бүрдүүлэх, салбар лабораториудаар сүлжээ үүсгэх	Мэргэжлийн судалгаа-шинжилгээний хамтын ажиллагаа өргөжнө	Тус лабораторитой хамтран ажиллах байгууллагын тоо	10+	2025-2027

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
6		Шинжилгээний үр дүнд суурилсан технологийн зөвлөмжийн сан гаргах	Бүтээгдэхүүн сайжруулалт, стандартчилалд судалгаа шууд нөлөөлөх боломж бүрдэнэ	Зөвлөмж гаргасан судалгааны тайлангийн тоо	20+	2026-2030
7	Зорилт 2.2: Технологи, инновацыг дэмжих	Инкубаторын хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх	Илүү олон стартап, инновац бизнес хөгжих боломжтой болно	Хамрагдсан гарааны бизнесийн тоо	20	2026-2028
8		Технологи дамжуулах төв байгуулах	Шинжлэх ухаан-бизнесийн уялдаа сайжирна, дотоодын технологи зах зээлд хүрнэ	Хөрвүүлэгдсэн технологийн тоо (R&D → Business)	10	2026-2028
9		Инновацын багуудын хамтарсан төслийн санхүүжилтийн схем боловсруулах	Шинэлэг санаа бодит үйлдвэрлэлд хүрэх хөрөнгө оруулалтын боломж нэмэгдэнэ	Хамтран хэрэгжүүлсэн инновацын төслийн тоо	15	2025-2030
10		Инновацын патент, лицензийн үйлчилгээний систем ажиллуулах	Шинэ технологи, бүтээгдэхүүний эрх зүйн хамгаалалт сайжирна	Патентжуулсан санааны тоо	10	2026-2029
11		Инновацын уралдаан, хурдасгуур (accelerator) хөтөлбөр зохион байгуулах	Залуу инженер, технологичдод хөрөнгө оруулалт татах боломж бүрдэнэ	Уралдаанд оролцсон баг / хамт олон	50+	2026-2030
12	Зорилт 2.3 – Орчин үеийн үйлдвэрлэлийн технологи нэвтрүүлэх	Үйлдвэрлэлийн робот, автомат удирдлагын системийн туршилтын төсөл хэрэгжүүлэх	Дижитал шилжилтийн кейс бий болж, бусад үйлдвэрт загвар болно	Туршилтад оролцсон үйлдвэрүүдийн тоо	1	2026-2027
13		IoT болон хяналтын ухаалаг төхөөрөмжийг үйлдвэрлэлийн шугамд суурилуулах	Өгөгдөлд суурилсан хяналт, шийдвэр гаргалт сайжирна	IoT суурилуулсан нэгжийн тоо	30	2026-2030
14		AI/ML шийдлийг ашигласан чанарын хяналтын программ хангамж нэвтрүүлэх	Алдаа буурч, стандартын гажуудал автоматаар илэрдэг болно	Автомат хяналттай шугамын эзлэх хувь	50%	2027-2030

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
15		Үйлдвэрийн ухаалаг шийдэлтэй (smart factory) бүтээн байгуулалт эхлүүлэх	Дэвшилтэт технологид суурилсан “парк доторх парк” концепц хэрэгжинэ	Ухаалаг үйлдвэрлэлийн шинэ нэгжийн тоо	3	2026-2029
16		Үйлдвэрлэлд хийгдсэн технологийн өөрчлөлтөөс үүссэн бүтээмжийн өсөлтийг хянах систем нэвтрүүлэх	Технологийн хөрөнгө оруулалтын өгөөжийг үнэлэх боломжтой болно	Нэгжид ногдох бүтээмжийн өсөлт (%)	+20%	2027-2030
17	Зорилт 2.4 – Хамтарсан инновацын төслүүд хэрэгжүүлэх	Их, дээд сургуулиудтай хамтран инновацын хамтарсан судалгаа, хөгжүүлэлтийн төсөл хэрэгжүүлэх	Судалгаанд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болно	Хамтарсан хэрэгжсэн төслийн тоо	10	2025-2030
18		ААН–сургалтын байгууллагын консорциум байгуулж жил бүр төсөл сонгон шалгаруулах	Хувийн хэвшил–академик хамтын ажиллагаа институцийн түвшинд уялдаатай болно	Консорциумд оролцсон талуудын тоо	15+	2026–2030
19		“Industry-Academia Lab” буюу хамтарсан лаборатори ажиллуулах	Инновацын туршилт, Шинэ бүтээгдэхүүн боловсруулах орчин бий болно	Шинэ бүтээгдэхүүн боловсруулсан тоо	20	2025–2028
20		Технологийн сорил, баталгаажуулалтын нээлттэй платформ хөгжүүлэх	ААН-үүд шинэ технологио зах зээлд гаргахын өмнө сорьж, баталгаажуулах боломжтой болно	Сорилд хамрагдсан шинэ технологийн тоо	30	2026-2030
21		Инновацын хамтарсан хөрөнгө оруулалтын сан үүсгэх боломжийг судлах	Эрсдэлтэй боловч ирээдүйтэй санаа, төсөлд эх үүсвэр бий болно	Хөрөнгө оруулсан инновацын стартап/төсөл	10+	2027–2030
22	Зорилт 2.5: Дотоодын технологийн чадварыг нэмэгдүүлэх	Инженер, техникийн ажилтнуудад зориулсан нарийн мэргэшлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	Үйлдвэрлэлд шаардагдах өндөр ур чадвартай боловсон хүчин бэлтгэгдэнэ	Сургалтад хамрагдсан техникийн ажилтны тоо	300+	2026-2030
23		Олон улсын технологийн сургалт, солилцооны хөтөлбөрт оролцох инженерүүдийг дэмжих	Дотоодын боловсон хүчин олон улсын шилдэг туршлага нутагшуулах чадавхтай болно	Гадаадад сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	50	2025–2030

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
24		Үйлдвэрийн практик ур чадварын сургалтын төв байгуулах	Хөдөлмөрийн зах зээлд шууд бэлтгэгдэх мэргэжилтэн, дадлагын орчин бүрдэнэ	Төвд дадлага хийсэн суралцагчдын тоо	300+	2026-2029
25		Технологийн мэргэжлийн үнэлгээ, чадамжийн гэрчилгээжүүлэлт нэвтрүүлэх	Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг баталгаажуулах стандарт тогтоно	Сертификат олгосон ажилтны тоо	200	2027-2030
26		Сургагч багшийн хөтөлбөр хэрэгжүүлэх	Дотооддоо сургалт явуулах, тогтвортой чадамж хөгжүүлэх боломж бүрдэнэ	Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	30	2025-2028

Хүснэгт 1. 8. НҮТН-ийн дунд хугацааны стратегийн зорилго 3-ын хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр дүн

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилго 3: Зах зээл, экспортын сувгийг өргөтгөх					
2	Зорилт 3.1: Дотоод зах зээлийн эрэлт хангах	Нийслэл болон зүүн бүсийн дэд бүтцийн төслүүдийн материалын хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх	Эрэлтэд суурилсан үйлдвэрлэлийн төлөвлөлт бий болно	Судалгаанд хамрагдсан төсөл, зах зээлийн тоо	30+ төсөл	2025-2027
3		Төсөлд нийлүүлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугамуудыг өргөтгөх	Дотоодын хэрэгцээг хангасан тогтвортой нийлүүлэлт бүрдэнэ	Өргөтгөсөн үйлдвэрлэлийн хүчин чадал	+30%	2026-2028
4		Барилгын томоохон төсөл, хот байгуулалтын байгууллагуудтай урт хугацааны гэрээ байгуулах	Тогтмол борлуулалт, тогтвортой орлого, түншлэл бүрдэнэ	Байгуулсан урт хугацааны гэрээний тоо	10+ гэрээ	2025-2027
5		Дотоодын зах зээлд зориулсан бүтээгдэхүүний ангилал, стандартыг оновчлох	Борлуулалт нэмэгдэж, бүтээгдэхүүн хэрэглэгчийн хэрэгцээнд нийцнэ	Стандартад нийцсэн шинэ бүтээгдэхүүний тоо	5	2026-2029
6		Нийслэл болон орон нутгийн барилгын кластер байгууллагуудтай стратегийн түншлэл тогтоох	Зөвхөн нийлүүлэгч бус, хөгжлийн хамтрагч болох шинэ хэлбэр төлөвшинэ	Түншлэлийн санамж бичиг, гэрээний тоо	15	2025-2027

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
7	Зорилт 3.2: Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Экспортын бүтээгдэхүүнд тохирох түүхий эд, технологийн судалгаа хийх	Зах зээлд тохирсон өндөр чанартай бүтээгдэхүүний хөгжүүлэлт эхэлнэ	Хийгдсэн техник-эдийн засгийн үндэслэл, технологийн судалгааны тоо	5	2025-2026
8		ЕАЭЗХН, Ази, Зүүн өмнөд Азийн орнуудад чиглэсэн экспортын стратеги боловсруулах	Тодорхой зах зээлийг онилсон борлуулалтын төлөвлөгөөтэй болно	Экспортын зах зээлд чиглэсэн стратеги, төлөвлөгөөний тоо	3 бүс/орон	2026-2027
9		Экспортын зориулалттай барилгын бүтээц, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугам байгуулж, турших	Экспортод гарах боломжтой бүтээгдэхүүн бодитоор үйлдвэрлэгдэнэ	Туршилтын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний тоо	10	2026-2028
10		Гадаад зах зээлд зориулсан сав баглаа боодол, шошго, таних тэмдэгтэй брэнд хөгжүүлэх	Бүтээгдэхүүний танигдах чадвар, хэрэглэгчийн итгэл нэмэгдэнэ	Хөгжүүлсэн экспортын брэндийн тоо	3	2027-2029
11		Экспортын дэмжих үйлчилгээнүүдийн цогц багц бий болгох (гааль, логистик, зөвлөгөө)	Экспортлогч ААН-үүдийн зардал буурч, гарц нэмэгдэнэ	Экспортын үйлчилгээнд хамрагдсан ААН-ийн тоо	20	2026-2030
12		Зорилт 3.3: Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх сорилт, гэрчилгээний систем бий болгох	Олон улсын стандарт (ISO, EN, ASTM гэх мэт)-ын шаардлагыг хангах лабораторийн хүчин чадал бий болгох	Экспортын бүтээгдэхүүнүүдийг олон улсын сорилд хамруулах нөхцөл бүрдэнэ	Хамрагдсан олон улсын стандартын тоо	10+
13	Гадаад сорилын төвүүдтэй хамтын ажиллагаа, харилцан зөвшөөрөх хэлэлцээр байгуулах		Монголд хийсэн шинжилгээг гадаадад хүлээн зөвшөөрөх боломжтой болно	Хамтран ажиллах гэрээ байгуулсан сорилын төвүүдийн тоо	5	2026-2028
14	Экспортын зориулалттай бүтээгдэхүүний гэрчилгээжүүлэлтийн багц үйлчилгээ нэвтрүүлэх		ААН-үүдэд экспортын чадамж олгох үйлчилгээний платформ бүрдэнэ	Сертификат авсан бүтээгдэхүүний тоо	25	2026-2029
15	Гэрчилгээний төвийг итгэмжлүүлж, ISO/IEC 17065 стандартын дагуу ажиллуулах		Хөндлөнгийн, баталгаажсан гэрчилгээ олгох эрх бүхий төвтэй болно	Итгэмжлэлийн гэрчилгээний статус	Албан ёсны	2027-2029

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
					итгэмжлэгдсэн	
16		Бүтээгдэхүүнд CE, EAC, CCC зэрэг бүс нутгийн экспортын тэмдэглэгээ авах аргачлал боловсруулж, зааварчилгаа өгөх	Экспортын техникийн саад тотгор багасна	Хамрагдсан ААН-ийн тоо / сургалтын материалын тоо	50 ААН	2026-2030
17	Зорилт 3.4: Гадаад хамтын ажиллагаа, маркетингийг өргөжүүлэх	НҮТП-ийн нэрийн өмнөөс олон улсын барилгын материалын үзэсгэлэнд жил бүр оролцох	Бүтээгдэхүүний танигдах чадвар нэмэгдэж, гадаад харилцаа өргөжнө	Оролцсон үзэсгэлэнгийн тоо	Жилд 1 удаа	2025-2030
18		Гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд зориулсан "Investor Day" форум зохион байгуулах	Шууд хөрөнгө оруулалт татах, түншлэл үүсэх нөхцөл бүрдэнэ	Форумд оролцогч хөрөнгө оруулагчийн тоо	50+ оролцогч / жил	2025-2030
19		Олон улсын маркетингийн агентлаг, худалдааны төлөөлөгчийн газартай стратегийн гэрээ байгуулах	Зах зээлийн талаарх мэдээлэл, худалдан авагчийн сүлжээ үүснэ	Байгуулсан стратегийн түншлэлийн гэрээний тоо	5	2026-2028
20		НҮТП-ийн гадаад сурталчилгааны вэбсайт, мультимедиа контент, олон хэл дээрх каталог хөгжүүлэх	Гадаад худалдан авагч, түншүүдэд хүртээмжтэй мэдээллийн орчин бүрдэнэ	Хандалтын тоо, татан авсан материалын тоо	10,000+ хандалт	2025-2026
21		Монголын дипломат төлөөлөгчийн газар, худалдааны танхимуудтай хамтарсан сурталчилгаа зохион байгуулах	Үндэсний түвшний сурталчилгаагаар дэмжигдсэн экспорт, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ	Хамтран зохион байгуулсан арга хэмжээний тоо	12 арга хэмжээ	2025-2030
22		НҮТП-ийн брэнд, лого, бүтээгдэхүүний таних тэмдэг, нийтлэг дизайн боловсруулах	Хэрэглэгчийн итгэлцэл нэмэгдэж, зах зээлийн өрсөлдөх чадвар дээшилнэ	Хөгжүүлсэн брэнд, дизайн концепцийн тоо	1 иж бүрэн багц	2025
23	Зорилт 3.5: Борлуулалтын суваг, дэд бүтцээ сайжруулах	Борлуулалтын төв (distribution hub) байгуулах, бүсчилсэн логистикийн шийдэл хэрэгжүүлэх	Бүтээгдэхүүний хүргэлт хурдсаж, зардал буурна	Төвийн үйл ажиллагаанд хамрагдсан ААН-ийн тоо	50+	2026-2028

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
24		Барилгын материалын онлайн худалдааны платформ хөгжүүлэх	Хүртээмж нэмэгдэж, B2B болон B2C сувгаар шууд борлуулалт өргөжнө	Цахим платформын идэвхтэй хэрэглэгчийн тоо	10000+	2026-2030
25		Борлуулалтын багийг мэргэшүүлж, сургалт, урамшууллын систем нэвтрүүлэх	Борлуулалтын багийн бүтээмж, ур чадвар сайжирна	Борлуулалтын өсөлтийн хувь / Сургалтад хамрагдсан ажилтны тоо	+25% өсөлт / 50 ажилтан	2025-2028
26		Барилгын материалын бөөний, жижиглэн борлуулалтын сүлжээтэй урт хугацааны түншлэл байгуулах	Үндэсний хэмжээнд тогтвортой зах зээлийн сувагтай болно	Түншлэлийн хэлэлцээрийн тоо	20+ байгууллага	2025-2030

Хүснэгт 1.9. НҮТП-ийн дунд хугацааны стратегийн зорилго 4-ийн хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр дүн

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилго 4: НҮТП-ийн чадавхыг бэхжүүлэх					
2	Зорилт 4.1: Менежмент, үйл ажиллагааны ил тод байдлыг дэмжих	Засаглалын бүтцийн үнэлгээ хийж, шинэчлэлтийн стратеги боловсруулах	Удирдлагын бүтэц, шийдвэр гаргалт оновчтой, хариуцлагатай болно	Шинэчлэгдсэн дүрэм, журам, бүтэц батлагдсан эсэх	1 иж бүрэн шинэчлэл	2025-2026
3		Удирдлага болон үйл ажиллагааны ил тод байдлыг хангах цахим тайлагналын систем хөгжүүлэх	Ашиг сонирхлын зөрчил, мэдээллийн тэгш хүртээмж сайжирна	Тайлан, мэдээллийн цахим хандалтын тоо	10,000+ хандалт	2025-2027
4		Нийтийн мэдээллийн ил тод байдал, бизнесийн ёс зүйн сургалт, хөтөлбөр хэрэгжүүлэх	Соёл, хандлага төлөвшиж, хариуцлага сайжирна	Сургалтад хамрагдсан ажилтан, ААН-ийн тоо	100+	2025-2028
5		Аж ахуйн нэгжүүдийн гэрээ, тендерийн ил тод байдлын нэгдсэн портал нэвтрүүлэх	Шилэн ажиллагаа төлөвшинө, бизнесийн итгэлцэл нэмэгдэнэ	Ил тод байршуулсан тендерийн тоо	100% гэрээ цахимжсан	2026

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
6		Засаглалын хяналт-шинжилгээний хараат бус зөвлөлийг байгуулах	Хөндлөнгийн хяналт, бодлогын зөвлөмжийн үр ашиг дээшилнэ	Хурлын тоо, гаргасан зөвлөмж, хүлээсэн хариуцлагын тоо	4 хурал/жил, 20+ зөвлөмж	2025-2030
7	Зорилт 4.2: Хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх	Чадамжид суурилсан хүний нөөцийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх	Ажилтан бүрийн ур чадвар, гүйцэтгэлд тулгуурласан HR менежмент төлөвшинө	Стратеги баримт бичиг, дагалдах хэрэгжилтийн төлөвлөгөө	1 иж бүрэн баримт бичиг	2025-2026
8		Удирдах ажилтнуудын манлайлал, хариуцлагын хөтөлбөр хэрэгжүүлэх	Удирдлагын гүйцэтгэл, шийдвэрийн чанар сайжирна	Сургалтад хамрагдсан удирдах албан тушаалтны хувь	100%	2025-2027
9		Урамшуулал, карьер хөгжлийн шатлалт тогтолцоо бүрдүүлэх	Ажилтан тогтвортой байдал, бүтээмж өснө	Сэтгэл ханамжийн судалгааны эерэг хариултын хувь	≥80%	2026-2030
10		Дижитал хүний нөөцийн систем нэвтрүүлж, ажлын гүйцэтгэл, бүтээмжийн хяналтыг сайжруулах	Ил тод, бодит өгөгдөлд тулгуурласан үнэлгээ хийгдэнэ	Системийн хамрагдалт, тайлагналын давтамж	100% баг хамрагдсан	2026-2029
11		Хүний нөөцийн бодлогын тогтвортой байдлыг хангах журмууд шинэчлэх, ISO 30414 стандарттай уялдуулах	Байгууллагын хүний нөөцийн соёл, тогтолцоо олон улсын түвшинд нийцнэ	Хамарсан журмын тоо, ISO нийцлийн үнэлгээ	10 журам шинэчилнэ	2027-2030
12	Зорилт 4.3. Цахим засаглал, дижитал менежментийг хөгжүүлэх	ERP (Enterprise Resource Planning) систем нэвтрүүлэх	Санхүү, нөөц, хүний нөөцийн нэгдсэн удирдлага сайжирна	ERP системийг бүрэн ашиглаж буй албадын хувь	100%	2025-2026
13		Паркийн удирдлагын шийдвэр гаргалтад дата аналитикийг ашиглах BI систем нэвтрүүлэх	Хурдан, шинжилгээнд суурилсан шийдвэр гаргалт төлөвшинө	BI тайлангийн давтамж, хэрэглээний индекс	Сард 4+ тайлан	2026-2028
14		Үйлдвэр бүрийн өгөгдөлд суурилсан дижитал хяналтын төв байгуулах	Үйл ажиллагааны уялдаа, шуурхай хяналт бодит цагт хийгдэнэ	Хяналтын төвөөс хянаж буй нэгжийн тоо	100% нэгж	2026-2029

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
15	Зорилт 4.4: Санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх	Цахим оффис, баримт бичгийн удирдлагын систем нэвтрүүлэх	Баримт бичиг, шийдвэрийн ил тод байдал, давхардал буурна	Баримт бичгийн удирдлагын системд байршуулсан баримт бичгийн тоо	10,000+ баримт	2025-2027
16		Паркийн дижитал хөгжлийн стратегийг боловсруулах, олон улсын ISO 27001 стандартад нийцүүлэх	Цахим менежмент аюулгүй, тогтвортой, стратегитай болно	ISO нийцлийн түвшин, стратегийн баталсан хувилбар	1 стратеги, ISO баталгаажуулалт	2027-2030
17		НҮТП-ийн дэд бүтцийн нэгтгэсэн хөрөнгө оруулалтын зураглал (Investment Map) боловсруулах. Crowd-investment болон PPP санхүүжилт татах суурь мэдээллийг ил тод болгох	Хөрөнгө оруулалтын ил тод байдал, сонирхлын түвшин нэмэгдэнэ	Бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын боломжийн тоо Data-room-д байршуулсан мэдээллийн багц	≥ 20 хөрөнгө оруулалтын боломж (үйлдвэр, агуулах, үйлчилгээ) 100% цахим платформд нээлттэй	2025-2029
18	Зорилт 4.4: Санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоог бэхжүүлэх	Blended Finance Framework (төслийн шат бүрд нэн хөнгөлөлттэй, буцалтгүй, хувийн хөрөнгө оруулалтыг хослуулах загвар) боловсруулах,	Инновацийн болон R&D суурьтай төсөлд санхүүгийн хүртээмж сайжирна	Санхүүжилтийн схемийн тоо Оролцсон эх үүсвэрийн төрөл	2 blended finance загвар (грант+зээл, зээл+equity) 3 төрлийн эх үүсвэр (төр, хувийн, ОУБ)	2025-2030
19		“Innovation Finance Facility” болон “Risk Guarantee Fund” байгуулах тухай судалгаа, концепц боловсруулах. ААН, гарааны бизнесийн санхүүжилтийн	Стартап болон экспортод чиглэсэн компаниудын санхүүжилт авах нөхцөл сайжирна	Боловсруулсан концепц/загварын тоо	1	2026-2028

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
		эрсдэлийг бууруулах боломжийг судлах				
20		“Investment Readiness Accelerator” хөтөлбөр эхлүүлэх. ҮТП-д үйл ажиллагаа явуулах ААН-үүдэд төслийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын санал бэлтгэх зөвлөгөө олгох	Санхүүгийн соёл, хөрөнгө оруулалтад бэлтгэгдсэн компаниудын тоо нэмэгдэнэ	Сургалтад хамрагдсан ААН-ийн тоо Санхүүжилт татсан стартапын тоо	≥ 15 ААН хөтөлбөрт хамрагдсан ≥ 5 стартап	2026–2030
21		Эрсдэлийн даатгалын загвар боловсруулах Хямрал, түүхий эдийн үнэ, байгалийн хүчин зүйлийн нөлөөг бууруулах	Хөрөнгө оруулагчдын итгэл, банкны зээлийн баталгаа сайжирна	Эрсдэлийн хамгаалалттай төслийн тоо Хамрагдсан байгууллагын тоо	≥ 3 төсөл ≥ 10	2026–2030
22		НҮТП-ийн мэдээллийн нэгдсэн платформ шинэчлэх	Хүртээмжтэй, хялбар ойлгогдох, ил тод харилцаа бүрдэнэ	Вэбсайтын хэрэглэгчийн тоо, шинэ контентын давтамж	10,000+ хэрэглэгч	2025–2026
23	Зорилт 4.5: Технологи мэдээллийн систем нэвтрүүлэх	Үйлдвэрлэлийн сүлжээ, ханган нийлүүлэлтийн уялдааг газрын зураг дээр дүрслэн, хөгжлийн боломжийг тодорхойлох	Эдийн засгийн уялдаа, логистик зангилаа, нийлүүлэлтийн сүлжээний нэгдмэл зураглал бүрдэнэ	Хөгжлийн боломж бүхий аж ахуйн нэгжийн кластерын тоо (үйлдвэр, агуулах, нэгдсэн логистик төв, лаборатори, R&D гэх мэт)	5 кластер	2026–2028
24		Дотоод, гадаад зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чиг хандлагыг урьдчилан таамаглах системийг ашиглах	Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн шийдвэр дэмжих дата суурь бий болно	Урьдчилан таамаглах загварын үнэн зөв байдал (%), Аналитик тайлангийн давтамж	85%	2026–2038
25				Сард 1 удаа		

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
26		Smart Data Dashboard нэвтрүүлэх Эрчим хүч, ус, хаягдал, үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр зэрэг гол KPI-г бодит цагийн горимоор хянах	Бодит цагийн хяналт, шийдвэр гаргалтын үр ашиг сайжирна	Хянагдаж буй KPI-ын тоо, шинэчлэлтийн давтамж (real-time/өдөрт/7 хоногт)	12 KPI ¹	2026- 2028
27				Шинэчлэлтийн давтамж	Real-time хяналттай, 24/7 дата урсгалтай, 1 минут тутамд refresh	
28				Паркийн сошиал, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн контент хөгжүүлэлт, мэдээ түгээлтийг өргөтгөх	Иргэдийн мэдээлэлд суурилсан оролцоо, саналын чанар сайжирна	

¹ Эрчим хүчний хэрэглээ, Усны хэрэглээ, Хог хаягдлын хэмжээ, Үйлдвэрлэлийн хэмжээ, Ажлын байрны тоо, Ажиллах хүчний бүтэц, Дундаж цалин, Газрын ашиглалт, Түрээсийн орлого, Түүхий эдийн эргэлт, R&D төсөл, Байгаль орчны үзүүлэлт (CO₂, дуу чимээ гэх мэт)

Хүснэгт 1. 10. НҮТН-ийн дунд хугацааны стратегийн зорилго 5-ын хүрэн дэх зорилт, үйл ажиллагаа, үр дүн

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
1	Стратегийн зорилго 5: Ногоон хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх					
2	Зорилт 5.1 – Хог хаягдал ангилан ялгах, дахин боловсруулах	Ангилан ялгах хаягдлын нэгдсэн журам баталж хэрэгжүүлэх	Үйлдвэр бүр хаягдлаа ангилан ялгаж, дахин боловсруулах нөхцөл бүрдэнэ	Ангилсан хог хаягдлын эзлэх хувь	≥80%	2025-2028
3		Дахин боловсруулах цех байгуулах /тусгай зориулалт бүхий/	Хаягдлыг ашиглах, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн бий болно	Боловсруулсан хаягдлын хэмжээ (тонн)	1000 тн/жил	2026–2028
4		Цэвэрлэх байгууламжийн зураг төсөл, хэрэгжилтийн төсөл боловсруулж, хэрэгжүүлэх	Усны бохирдол буурч, дахин ашиглалт боломжтой болно	Цэвэрлэгдэж буй хаягдал усны хэмжээ	90%	2026–2029
5		Аж ахуйн нэгжүүдэд зориулсан байгальд ээлтэй хог хаягдлын боловсруулалтын сургалт явуулах	Үйлдвэрүүдийн хандлага, хэрэгжилт бодитоор сайжирна	Сургалтад хамрагдсан ААН-ийн тоо	50+	2025-2027
6		Паркийн хэмжээнд “ногоон бүтээгдэхүүн”-ийн шалгуур үзүүлэлт тогтоож, урамшууллын механизм хэрэгжүүлэх	Байгальд ээлтэй үйлдвэрлэл рүү өөрчлөлт хандлага хурдасна	Ногоон урамшуулалд хамрагдсан үйлдвэрүүдийн тоо	20	2027–2030
7		Зорилт 5.2 – Эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний төслүүд хэрэгжүүлэх	Нарны цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах	Үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах суурь тавигдана	Боловсруулсан ТЭЗҮ, зураг төсөл	1 иж бүрэн
8	Паркийн дотоод хэрэглээний 30%-ийг нарны эх үүсвэрээр хангах туршилтын төсөл хэрэгжүүлэх		Эрчим хүчний өртөг буурч, байгальд ээлтэй шийдэл төлөвшинэ	Сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан хэрэглээний эзлэх хувь	30%	2026-2028
9	Салхины эрчим хүч ашиглах боломжийг судалж, туршилтын төслийг эхлүүлэх		Эрчим хүчний төрөлжилт, нөөцийн тогтвортой байдал хангагдана	Суурилуулсан салхин турбин / хүч чадал (kW)	500 kW	2027–2030
10	Үйлдвэрүүдэд эрчим хүч хэмнэлтийн аудит хийх, зөвлөмж өгөх хөтөлбөр хэрэгжүүлэх		Эрчим хүчний хэмнэлт бодитоор хэмжигдэнэ	Аудит хийсэн үйлдвэрүүдийн тоо	50+	2025–2027

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
11		Ногоон эрчим хүч хэрэглэгчдэд татварын болон тарифын урамшуулал олгох бодлогын санал боловсруулах	ААН-үүд ногоон шилжилт хийхэд идэвхтэй оролцоно	Хөнгөлөлт авсан ААН-ийн тоо	20	2027-2030
12	Зорилт 5.3: Байгаль орчны удирдлагын системийг бэхжүүлэх	ISO 14001 стандартад нийцсэн Байгаль орчны удирдлагын тогтолцооны гарын авлага, журам боловсруулж хэрэгжүүлэх	Үйлдвэрлэлд тогтвортой хөгжлийн зарчим бодитоор хэрэгжинэ	Стандартад нийцсэн ААН-ийн тоо	30	2025-2027
13		Үйлдвэр бүрийн байгаль орчны эрсдэлийн үнэлгээг хийх хөтөлбөр хэрэгжүүлэх	Сөрөг нөлөөллийг урьдчилан илрүүлж, бууруулах системтэй болно	Хамрагдсан үйлдвэрүүдийн тоо	50+	2026-2027
14		Агаар, ус, хөрсний хяналтын онлайн мониторингийн систем суурилуулах	Байгаль орчны төлөв байдал бодит цагт хянагдана	Мониторинг хийгдэж буй үзүүлэлтийн тоо	10	2026-2028
15		Байгальд ээлтэй техник, технологи ашиглаж буй ААН-д урамшууллын бодлого хэрэгжүүлэх	Эерэг хандлага, сайн туршлага тогтмолжино	Урамшуулал авсан байгууллагын тоо	20	2027-2030
16		Байгаль орчны мэдээллийн тайлан, хяналтын ил тод байдлын платформ хөгжүүлэх	Иргэд, оролцогч талууд мэдээллийг чөлөөтэй хянах боломжтой болно	Ил тайлагнасан үзүүлэлтийн тоо, платформын хандалт	10+ тайлан / жил	2026-2030
17	Зорилт 5.4: Ногоон байгууламж, амьдрах орчныг сайжруулах	Паркийн ерөнхий төлөвлөгөөнд ногоон байгууламж, амралтын орчны бүсчлэл тодорхойлох	Эрүүл, тав тухтай, байгальд ээлтэй ажлын болон амьдрах орчин бүрдэнэ	Бүсчилсэн нийт ногоон байгууламжийн хэмжээ	5 га	2025-2026
18		Цэцэрлэгт хүрээлэн, ногоон зурвас, мод үржүүлгийн бүс байгуулж моджуулалт хийх	Агаарын чанар сайжирч, экологийн тэнцвэр хангагдана	Тарьсан модны тоо	10,000 ширхэг	2026-2028
19		Албан бус амралт, спортын зориулалттай талбай, сүүдрэвч, сууц байгуулах	Ажилчдын сэтгэл ханамж, бүтээмж дээшилнэ	Амралтын байгууламжийн тоо	10	2025-2027
20		Гэрэлтүүлэг, камер, хог ангилан хаях ухаалаг хогийн сав бүхий ногоон орчны систем суурилуулах	Аюулгүй, цэвэр, ухаалаг хүрээлэн буй орчин бүрдэнэ	Суулгасан төхөөрөмжийн тоо	200 ширхэг	2026-2029

№	Зорилт	Үйл ажиллагаа	Үр дүн (Outcome)	Шалгуур үзүүлэлт (KPI)	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа
21		Ногоон орчны менежментийн дотоод дүрэм, арчилгааны төлөвлөгөө боловсруулж мөрдүүлэх	Байнгын арчилгаа, тогтвортой менежмент хэрэгжих нөхцөл бүрдэнэ	Сар бүр хийсэн арчилгааны тоо, гүйцэтгэлийн хувь	100%	2025-2030
22	Зорилт 5.5: Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх	Төрийн үйлчилгээний “Нэг цэгийн төв” байгуулахыг санал болгох (иргэний бүртгэл, татвар, НДШ гэх мэт)	Ажиллагчдад төрийн үйлчилгээ хүртээмжтэй, шуурхай болно	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь	≥90%	2027-2028
23		Нийтийн тээврийн шинэ чиглэл нээх, нийслэлийн тээврийн системтэй уялдуулах	Ажилчдын зорчих нөхцөл сайжирна, замын ачаалал буурна	Хамрагдсан зорчигчийн тоо / өдөр	1000	2025-2027
24		Ажилчдын орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх, түрээсийн болон өмчлөх хэлбэрийг дэмжих	Паркийн оршин суугчийн тоо нэмэгдэж, нийгмийн тогтвортой байдал хангагдана	Ашиглалтад орсон байрны тоо	200 өрх	2026–2030
25		Паркийн ажиллагсад, оршин суугчдад зориулсан эрүүл мэнд, спортын үйлчилгээ бүхий төв байгуулах	Ажилчдын эрүүл мэнд, амьдралын чанар дээшилнэ	Үйлчилгээ авсан иргэдийн тоо	2,000 хүн / жил	2026–2029
26		Нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийж, эмзэг бүлгийн оролцоог хангах бодлого хэрэгжүүлэх	Тэгш хамруулалт, олон нийтийн дэмжлэг нэмэгдэнэ	Бодлогоор хамрагдсан оролцогчийн тоо	500+	2025–2030



БҮЛЭГ II. МЕНЕЖМЕНТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТҮНШЛЭЛИЙН ЗАГВАР

2.1. “Налайхын ҮТП”-ийн ҮТП-ийн бүтэц, засаглалын хувилбар

Паркийн хөгжлийн бодлого, стратегийн зорилтуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах нь тус хамт олны үүрэг болно.

Паркийн удирдлагын схем, мэргэжлийн чиглэл, удирдлага өгөх болон хамтран ажиллах байгууллагуудыг нарийвчлан гаргаж байгаа нь парк, түүний үйл ажиллагаатай хамаарах хүрээнд кластерийн удирдлагыг нэвтрүүлэх, логистик төв байгуулах боломжийг тодорхойлоход чиглэж байгаа болно.

ҮТП-ийн захиргаанд Хөгжлийн төлөвлөлтийн хэлтэс ажиллах бөгөөд тэд дараах ажил үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Шинэ төлөвлөгөө боловсруулахдаа одоо байгаа ажлын гүйцэтгэлээс ямар сургамж авах ёстойг тодорхойлох,
2. Олон улсын жишиг, туршлага дээр үндэслэн, илүү хүртээмжтэй өсөлт, тогтвортой хөгжил, дунд хугацааны төлөвлөгөөний зорилтот түвшин, хүрэх ёстой үр дүнг биелүүлэхэд шаардлагатай стратеги, бодлого, хөтөлбөрийг тодорхойлж, ач холбогдлоор эрэмбэлэх. Хөтөлбөр, стратегид давхардал, өөр хоорондын зөрчил гарахгүй байхын тулд баримтлах зарчмыг тодорхойлох.
3. Улс орны нөхцөл байдал, хөрөнгө нөөцийн бололцоо, хэрэгжилтэд гарч болзошгүй саад бэрхшээл зэрэгтэй холбоотой авах арга хэмжээ, мэдээллийг судлан үнэлэх, жил бүрийн төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх авах арга хэмжээг боловсруулах
4. Бодлого, стратеги, хөтөлбөрийн талаар зөвлөмж боловсруулж ҮТП-ийн хөгжлийн төлөвлөлтийн буюу Удирдах зөвлөлд танилцуулах.

Мэргэжлийн ажлын хэсгүүд байгуулагдвал дараах ажил үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Хөгжлийн төлөвлөлтийн хэсэг, дэд хэсгүүд тус тусын ажил үүргийн хүрээнд хамаарах одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг судлан шинжлэх, одоо мөрдөгдөж буй төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад тулгарсан асуудал, бэрхшээлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх;
2. Уг дүн шинжилгээндээ үндэслэн баримтлах стратеги буюу арга замыг заасан баримт бичгийн төсөл боловсруулж, холбогдох төлөвлөлтийн хэлтэст танилцуулж хэлэлцүүлэх,
3. Стратеги буюу арга замыг заасан баримт бичиг боловсруулахад зориулан холбогдох фокус бүлгүүдээс санал, мэдээлэл авах ажлыг зохион байгуулах.

Төлөвлөгөөт хугацааны туршид хэрэгжүүлэх төслийн ерөнхий саналыг хүлээж авах хэрэгтэй. Эдгээр төслийн саналд дараах зүйлийг хамруулсан байх шаардлагатай. Үүнд:

- Одоо хэрэгжиж буй төлөвлөгөөнд орсон, цаашид үргэлжлэх төслүүд,
- Шинэ төслүүд
- Төлөвлөгөөт хугацааны орлого, зардал, үр ашгийн тооцоо
- Хөгжлийн төлөвлөлтөд болон төслийг газар дээр нь хэрэгжүүлэхэд тулгарч болзошгүй асуудал, бэрхшээл,

Уг төлөвлөгөө нь эдгээр төслүүд, тэдгээрийн орлого, зардлын тооцоог нэгтгэнэ. Энэ хүрээнд ирсэн мэдээллийг нэгтгэснээр ҮТП-ийн хэмжээний эдийн засгийн үзүүлэлтийн нэгтгэл, хүрэх үр дүн, төлөвлөгөөт зардлын дээд хязгаарт зохих нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл болно.

Ингээд зөвшилцсөний дараа Хөгжлийн төлөвлөлтийн зөвлөлд дараах асуудлыг танилцуулж хэлэлцүүлнэ. Үүнд:



- Хөгжлийн тулгуур зорилтууд, стратегиуд, хүрэх ёстой үр дүн
- Төлөвлөгөөнд тусгах макро-эдийн засгийн үзүүлэлтүүдийн хүрэх ёстой түвшин
- Санал болгож буй хөтөлбөр, төслүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам

Хөгжлийн төлөвлөлтийн зөвлөл (ХТЗ) бол тус ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг төрийн бодлого, үндэсний хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулах үүрэг бүхий мэргэжлийн удирдлага юм. ХТЗ нь хөрөнгө нөөц хуваарилах асуудлаар зөвлөмж гаргах үүрэгтэй ба хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина. ХТЗ төлөвлөгөөний төслийг зөвшөөрсний дараа уг төлөвлөгөөг ҮТП-ийн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батална.

Хөгжлийн төлөвлөлтийн энэхүү нягт чамбай, шат дараатай шалган хянах үйл явц нь уг бодлого, стратегид хэрэгцээ шаардлагыг оновчтой, бодитой тусгасан байх, бүс нутагт тогтвортой хөгжлийн үзэл санаан дор тэнцвэртэй хөгжих баталгаа болдог юм.

Хөгжлийн төлөвлөлтөд хөгжлийн зорилтуудыг нэгтгэн тусгах тусгай жор гэж мэдээж байхгүй. Улс орнууд төдийгүй байгууллагууд эдийн засаг, санхүүгийн бүтэц, хөгжлийн түвшнээрээ ялгаатай. Тиймээс тэд өөрийн онцлог нөхцөл байдалд тохирсон бодлогын хариу арга хэмжээ авах ёстой.

- Хөгжлийн төлөвлөлтөд нэгтгэхэд цогц бөгөөд нягт чамбай төлөвлөлтийн хүрээ шаардагдана. Уг хүрээ буюу тогтолцооны дээд үзүүрт ҮТП-ийн Алсын хараа, Эрхэм зорилго, стратегийн тулгуур зорилтууд байна. Энэ алсын хараа, стратегийн тулгуур зорилтуудыг хэлтэс, үйлдвэрлэлийн нэгж руу хуваарилан буулгахдаа гээгдүүлж болохгүй. Үе шат доошлох тусам стратегийн тулгуур зорилт нь нарийвчлагдан, гарах үр дүн нь тодорхой болж байх ёстой. Ялангуяа доод түвшиндээ хэрэгжүүлэх арга зам, үр дүнг хэрхэн хэмжихээ заасан байх ёстой.
- Хөгжлийн төлөвлөлтөд байгаль орчныг хамгаалах тэргүүлэх чиглэл тодорхой тусч, тогтвортой хөгжлийг үндсэн зорилго болгон заадаг ч орон нутагт хэрэгжилт эхлэх үед тогтвортой хөгжлийн ойлголт саармагжиж, сулрах хандлага гардаг. Тиймээс яг газар дээрээ хэрэгжилт үр дүнтэй байхын тулд компани, орон нутгийн хооронд ажлын уялдаа, нийцэл сайн байх шаардлагатай. Хөгжлийн төлөвлөгөөний зорилтуудын хэрэгжилтийг төлөвлөсний дагуу хангах нэг арга бол орон нутагт ямар төсөл хэрэгжүүлэхийг сонгохдоо тэрхүү уялдаа, нийцэлд хатуу захируулах явдал юм.
- Төлөвлөлтийн энэ тогтолцоог хүчтэй байгууллагууд л хөдөлгөнө. Ерөнхий захиралд тайлагнадаг төлөвлөлтийн нэгж буюу ХТХ энэ тогтолцоог нэгдмэл ажиллуулах гол нөхцөл юм. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадвартай хэлтэс нэгж байх ёстой.
- Хөгжлийн төлөвлөлт үр дүнтэй байхын тулд тогтвортой хөгжлийг хангах хууль, бодлого нь залгамж чанартай байх ёстой. Ойлголт, нэр томъёо өөрчлөгдөж болох ч бодлогын зорилт өөрчлөгдөх нь ховор. Нэг бодлого хэрэгжиж дуусахад дараагийн бодлого нь өмнөх зорилгоо үгүйсгэдэг байж болохгүй. Өмнөх бодлогын зорилт нь шинэ бодлогод уламжлагдан хадгалагдаж, улам бүр бэхжиж байх ёстой.
- Бодлогын ямар нэг алдаа гаргахгүйн тулд хүчин чармайлт гаргаж, оношоо зөв тогтоох нь нэн чухал. ҮТП-ийг хөгжүүлэх асуудлаар авах бодлогын арга хэмжээ нь зохистой бөгөөд цогц байх хэрэгтэй. Нэг салбарт хөрөнгө оруулбал холбогдох бусад салбарт ч хөрөнгө оруулалт хийх ёстой бөгөөд ингэж байж төслүүд сайн ажиллах, хөрөнгө оруулалт ач холбогдолтой болно.
- Хөгжлийн бодлого нь байгууллага тэтгэхэд чиглэж байх ёстой. Төсвийн алдагдлыг бууруулах бодлогын арга хэмжээ нь эдийн засгаа хэт агшаахгүй байх үүднээс тохируулгын арга хэмжээ авах ёстой. Хөгжлийн асуудлыг зөв оношилж чадвал байгууллагатаа хүнд хохирол учруулахгүйгээр бүтцийн зохицуулалт хийж болно.



- Хөрөнгө оруулалтын төслүүдийг сонгоход улс төрийн оролцоо хэт их бол стратегийн зорилтуудыг төлөвлөгөөнд нэгтгэн тусгах ажил үгүйсгэгдэж, төсвийн зарцуулалт үр дүнгүй болно.

Энд ямар нэг гаднын онол, арга, үзэл номлолыг шууд хуулбарлах бус, тэр тусмаа неолиберал бодлогыг сохроор дагах бус, харин өөрийн улс орны өвөрмөц онцлог, нөхцөл байдлыг харгалзан, авах гээхийн ухаанаар прагматик хандсанаар амжилтад хүрч болохыг бусад орны туршлага бидэнд анхааруулж байна. Гарсан алдааг засаж залруулахад дараах арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Хөгжлийн төлөвлөлтийн агуулгыг сурталчлан, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Хөгжлийн бодлогын онол, арга зүйн үзэл баримтлалыг шинээр томъёолох, зарим байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээрийг шинэчлэх, тэгш эрхтэй оролцоог хангах;
- Нэн тэргүүнд захиргааны болон захиргааны бус дэмжлэг, туслалцаа үзүүлэх, татаас олгох, татварын болон зээлийн хөнгөлөлт үзүүлэх талаар Төр, Засгийн шийдвэр гармагц түүнийг хэрэгжүүлэх замаар экспортыг урамшуулах, импортыг оновчтой, уян хатан, үе шаттай хязгаарлах (тарифын болон тарифын бус хязгаарлалт, олон зорилго чиглэлтэй стандартууд, лиценз, квотууд тогтоох) шаардлагатай болдог.

Санхүүгийн эх үүсвэр

ҮТП - ийн хөгжлийн төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэхэд төрөл бүрийн нөөц, санхүүгийн олон янз эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Монгол Улсын Хөгжлийн банк
- Орон нутгийг хөгжүүлэх сан
- Засгийн Газрын тусгай сангууд
- Гадаадын хөрөнгө оруулалт
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- Төр хувийн хэвшлийн түншлэл, концесс
- Орон нутгийн бонд
- Парк хөгжүүлэх сан
- Бусад эх үүсвэр

Налайхын ҮТП нь Засгийн газрын эрх бүхий байгууллага буюу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (ХББОСЯ), АҮЭБЯ бодлогын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, ЭЗХЯ-наас арга зүйн дэмжлэг, хөрөнгө оруулалтын төслийн зөвлөмж авч ажиллана. Эдгээр яамнууд нь:

1. Парк үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох,
2. Парк ба үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагыг тогтоох,
3. Паркийн удирдлагатай үйл ажиллагааны гэрээ байгуулах,
4. Паркийн хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжиж, Засгийн Газрын хөрөнгийн баталгаа гаргах ажлыг гүйцэтгэх,
5. Паркийн дэд бүтцийг байгуулах зураг төслийг гаргуулах, байгуулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх,
6. Паркийн хөгжлийн хөтөлбөрийг баталж мэргэжлийн удирдлагаар хангах,
7. Паркийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чиг үүрэгтэй оролцож байгаа



Парк нь дэд бүтцийн барилга байгууламжийг барих асуудлаар ХББОСЯ, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын асуудлаар БЯ, хүнд үйлдвэрийн асуудлаар АҮЭБЯ, хөрөнгө оруулалтын асуудлаар ЭЗХЯам зэрэг төрийн байгууллагуудтай харилцаж өдөр тутмын үйл ажиллагаагаа уялдуулж байх болно.

Налайхын Засаг дарга нь:

- Паркийн хөгжил, үйлдвэржилтийн чиг хандлагыг нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоох,
- ХХААХҮЯ, АҮЭБ-тай хамтран Паркийн удирдлагатай гурвалсан гэрээ байгуулах,
- Орон тоо, төсөв батлах, санхүүжүүлэх, төсвийн зарцуулалтад хяналт тавих,
- Паркт эзэмшлийн газар олгох, хяналт тавих,
- Паркийн дэд бүтцийг байгуулах зураг төслийг гаргуулах, барих санхүүжилтийн шийдвэрлүүлэх асуудлыг бусад Яамнуудтай хамтран шийдвэрлэх,
- Мэргэжлийн удирдлагаар хангах,
- Паркийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй оролцдог.

Нийслэлийн Засаг дарга:

- Паркийн хөгжил, үйлдвэржилтийн чиг хандлагыг дүүргийн хөгжлийн бодлоготой уялдуулах,
- ҮТП хөгжүүлэх сан байгуулах,
- Орон нутгийн дэмжлэг үзүүлэх,
- Хөрөнгө оруулагчидтай холбох,
- Паркт эзэмшлийн газар олгох, хяналт тавих зэргээр хамтран ажилладаг.

Хамтран ажиллах байгууллага:

- Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиуд, МСҮТ
- Гааль,
- Татвар,
- Банк санхүү,
- Мэргэжлийн хяналт,
- Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим,
- Сургалт, сурталчилгааны байгууллага,
- Дотоод гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид юм

Паркийн удирдлага/дарга нь паркийн үйл ажиллагааны гэрээ байгуулж, хөгжлийн хөтөлбөрийг Улаанбаатар хот, Налайх дүүргийн Засаг даргаар батлуулж, мөрдөн ажиллах болно.

Орон нутгийн удирдлага:

- Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн парк байгуулах газрын байршил, хэмжээг тогтооно.
- Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон газарт паркийн үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан хуулийн этгээдийн хүсэлтийг судалж, шийдвэрлэх журмыг холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.



Налайхын ҮТП-ийн Хөгжлийн төлөвлөгөө нь 2025-2030, 2031-2035, 2036-2040 он хүртэлх төлөвлөгөө байна. Энэхүү төлөвлөгөөнд суурилан дунд хугацааны болон жил бүрийн төлөвлөгөө боловсруулагдаж, гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гаргаж явах болно.

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт мониторинг хийх үүднээс Налайхын ҮТП - ийн захиргаа, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч байх, бүтэц, чиг үүргийн хуваарилалтыг хийж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон байх ёстой. Тухайлбал, хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нэгж, хэлтсүүдийг бодлогын удирдлагаар хангаж, дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд үндэслэн дунд болон богино хугацааны бизнес төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, салбар нэгжийн хооронд үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хэрэгжүүлнэ. Эдгээр нь:

- Удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр,
- Үйлдвэрлэл, технологийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр,
- Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр,
- Санхүүгийн менежментийг боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр,
- Нийгмийн хариуцлагын хөгжлийн хөтөлбөр.

Хөгжлийн төлөвлөгөө, түүнтэй холбогдох хөтөлбөр, төслүүдийг боловсруулах ажлыг шуурхай удирдлагаар хангаж, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүрэг, хариуцах нэгжийг доор үзүүлсэн захиргааны бүтцийн дагуу байгуулахаар төлөвлөсөн.

ҮТП-ийн бодлогын зөвлөл нь паркийн удирдлагын этгээд, паркийн нэгжүүд болон бүсийн сонирхлын бүлгийн төлөөлөлтэй Менежментийн багт туслан зөвлөх шуурхай удирдлагын бүтэц байна.

ҮТП-ийн захирагч/дарга болон менежментийн баг нь:

- Паркийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;
- Олгогдсон эрх, үүргийн хүрээнд паркийг төлөөлөн харилцах;
- Дотоод, гадаадын байгууллага, төслүүдтэй холбоо тогтоож ажиллах;
- Ажлын төлөвлөгөө гаргах, төсөл, тооцоо хийх, хэрэгжүүлэх;
- Паркийн үйл ажиллагааны талаар тайлан гаргах, мэдээлэл хийх;
- Паркийн нэгжийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах;
- “Үйлдвэрлэл, технологийн парк” нэрийг ашиглах;
- Хуульд заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх;
- Паркийн нэгжүүдэд үйлчлэх үйлчилгээг удирдан зохион байгуулах;

Паркт орохыг сонирхогч хуулийн этгээдэд паркийн үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлаар дүгнэлт гаргах эрх бүхий зөвлөлд (*цаашид зөвлөл гэх*) хүсэлт гаргана. Зөвлөлийн дүгнэлт нь тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх үндэслэл болно.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, олон нийтийн оролцоо

Хяналт, шинжилгээ үнэлгээ:

Төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай зардлыг ҮТП-ийн төсөвт тусган санхүүжүүлэх бөгөөд холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагууд, ажиллагчдын оролцоог зайлшгүй хангана.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд олон нийтийн хяналт оролцоог хангах дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд боловсруулж буй бодлого хөтөлбөр, төсвийн төсөлд удирдлагын баг, ажиллагчдын төлөөлөл үзэл бодол байр суурь, тэдний эрх ашгийг хөндсөн асуудалд саналыг тусгадаг механизмыг бий болгоно.



- Төлөвлөгөөний хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллага, иргэд, бизнесийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- Төрийн хяналт шинжилгээ, үнэлгээний зарим чиг үүргийг мэргэжлийн чадавх бүхий ТББ-д шилжүүлэх, тэднээр гүйцэтгүүлэх, хөндлөнгийн дүгнэлт гаргуулдаг болно.
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн, үйл ажиллагааны тайланг үйлдвэр, байгууллагын хамт олон, ард иргэдэд нээлттэй таниулж сурталчилна.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих нь дараах 3 чиглэлтэй байна. Үүнд:

- Төлөвлөгөөт зорилтуудын заалт бүрийн биелэлтийн байдал
- Төлөвлөгөөт хугацаа дахь гүйцэтгэлийн байдал
- Төлөвлөгөөний орон зай, хамрах хүрээний биелэлтийн байдал

Хэрэгжилтийг хангах Дотоод аудит, мониторингийн хороо нь жилийн болон дөрөв, дөрвөн жилийн ажлын төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд гүйцэтгэлийг УТП-ийн Удирдах зөвлөлд тайлагнана.


Үүнээс гадна, дүүргийн зүгээс хөндлөнгийн хяналт, мониторинг явуулж, хотын түвшинд хэрэгжүүлж буй төслийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгч ажиллаж болно.

Үйлдвэрлэл, Технологийн Паркийг компани засаглалын хэлбэрт оруулснаар паркийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц дараах бүтэцтэй байх боломжтой.

УТП-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

УТП-ийн өргөжин тэлэхийн хэрээр компани бүтцэд ч өөрчлөлт орж, зохион байгуулалтын үйл ажиллагаа улам нарийсах болно. УТП-ийн компанийн засаглалын удирдлага, зохион байгуулалтын жишиг бүтцийг зураг 2.1-т, чиг үүргийн загварыг хүснэгт 2.1-т харуулав.

Зураг 2. 1. УТП-ийн компанийн засаглалын удирдлага, зохион байгуулалтын жишиг бүтэц





Хүснэгт 2. 1. ҮТП-ийн захиргааны нэгжийн чиг үүрэг

№	Захиргааны нэгжүүд	Чиг үүрэг
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал	Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах болон эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлээд зогсохгүй, бүх хувьцаа эзэмшигчид ялангуяа цөөнх хувьцаа эзэмшигчдийг ялгаварлахгүй адил хандах нөхцөлийг бүрдүүлсэн байхаас гадна хувьцаа эзэмшигчид зөрчигдсөн эрхээ үр дүнтэйгээр нөхөн сэргээж авах боломжоор хангах
2	Төлөөлөн удирдах зөвлөл	ҮТП-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.
3	ТУЗ-ын нарийн бичгийн дарга	ХЭХ болон ТУЗ бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх, хурлын ажлыг зохион байгуулах, ХЭХ, ТУЗ шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах, ТУЗ дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах.
4	Аудитын хороо	Дотоод аудитын тогтолцоо нь ҮТП-ийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмол хянах, үр дүнг нь сайжруулах замаар урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжилд чухал хувь нэмэр оруулна; Дотоод аудитын нэгжийн удирдлага нь зохих мэдлэг, чадвар, туршлагатай байх ба ТУЗ эсвэл түүний дэргэдэх холбогдох нэгжүүдтэй шууд харилцаж, тайлагнана.
5	Цалин урамшуулалтын хороо	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлахдаа хэмжээг тодорхой илэрхийлж, үндэслэлийг ойлгомжтой тайлбарлана. Цалин, урамшууллыг төлөөлөн удирдах зөвлөлийн нийт цалингийн сан бус, гишүүн тус бүрээр, мөн хэрэв төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аливаа хорооны гишүүний хувиар хийсэн ажилд тусад нь цалин урамшуулал олгох бол түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд тодорхой тусгана.
6	Нэр дэвшүүлэх хороо	ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.
7	Захиргаа, санхүүгийн хэлтэс	ҮТП-ийн захиргаа, удирдлага
8		Хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээ үзүүлсний хураамж
9		ХК-ийн санхүү
10	Үйлдвэрлэл төлөвлөлт, судалгаа хөгжлийн хэлтэс	Паркт үйлдвэрүүдийг оруулах, үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай нөхцөлд гаргах
11		Паркийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих
12		Газар зохион байгуулалт, менежмент
13		Хэтийн төлөвлөлт
14		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт
15		Барилгажилтын үйл ажиллагаа
16	Паркийн ашиглалтын удирдах хэлтэс	Дэд бүтцийн удирдлага
17		Аюулгүй байдлын үйлчилгээ
18		Хангамж ашиглалтын объектуудын удирдлага
19		Нэгж хэсгүүдэд үйлчлэх үйлчилгээний удирдлага
20	Судалгаа хөгжлийн хэлтэс	Судалгаа, хөгжлийн бодлого
21		Хүний нөөцийн хөгжил
22		Туршилт шинжилгээний лабораториудын үйл ажиллагаа
23		Шинэ технологи-шинэ бүтээгдэхүүний маркетинг
24		Дизайны товчоо



№	Захиргааны нэгжүүд	Чиг үүрэг
25	Гадаад харилцаа, логистикийн хэлтэс	Гадаад харилцаа
26		Маркетинг
27		Тээвэр логистикийн үйл ажиллагаа

2.2. Налайхын ҮТП-ийн кластерийн зохион байгуулалт, менежментээр хангах бодлого

Харвардын бизнесийн сургуулийн профессор Майкл Портерын “Кластер бол хоорондоо холбоотой компаниуд болон тэдгээртэй тухайн нэг салбарт хамтран ажиллах институциуд нийтлэг ба дам байдлаар холбогдон газарзүйн байршлаар ойртсон бүлэглэл юм” гэсэн тодорхойлолт нь Налайхын ҮТП-ийн хөгжүүлэхээр судалж буй кластерыг бүрэн илэрхийлж болохоор байна.

1996 онд судлаач Маркусены боловсруулсан кластерт оролцогчид тэдгээрийн хоорондын харилцаанд оролцох үүргийн ялгаатай байдлаас хамааруулсан кластерын дөрвөн төрлийн загвараас “Кластерын төвийн загвар”-ыг “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн өргөтгөлийн 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” 2023 он болон 2025 оны байдлаар “Налайхын Үйлдвэрлэл Технологийн Парк” ХК-тай гэрээ байгуулсан нэгжүүдийг удирдлага болгон Налайхын ҮТП-ийн хөгжүүлэх боломжтой төслүүдэд тулгуурлаж, “Барилгын материал, бусад үйлдвэрийн кластер”-ийн төвийн загварыг боловсруулсан байна. Үүнд:

Кластерын төв: Барилгын материалын үйлдвэр

Кластерын нэгж:

- ✓ Бетон хийцийн үйлдвэрүүд
- ✓ Хавтангийн үйлдвэрүүд
- ✓ Металл хийцийн үйлдвэрүүд


Кластерын дагаж хөгжих боломжит төслүүд:

- ✓ Хаягдал боловсруулах үйлдвэрүүд
- ✓ Жижиг, дунд үйлдвэрийн бүс
- ✓ Барилгын материалын худалдаа

Эдгээрийг кластерын төвийн загвараар загварчилсныг дараах зурагт харууллаа.



Зураг 2. 2. Налайхын ҮТП-ийн кластерын загвар



НҮТП-ийн хөгжүүлэх үйлдвэрлэлийн процесс нь ҮТП-д нэгдэх үйлдвэрлэлийн сүлжээ, үндсэн оролцогч талууд, тэдний хооронд үүсэх **үйлдвэрлэл, нийлүүлэлтийн логик уялдаа, гарц ба зах зээлд нийлүүлэх бүтцийг** дараах хүснэгтээр харууллаа.

- ✓ Нийлүүлэгчид: Дотоодын болон импортоор хангагч байгууллагууд, тухайлбал хаягдал металл, түүхий эд, байгалийн чулуу, цемент, шохой, химийн нунтгийн ханган нийлүүлэгчид.
- ✓ Үйлдвэрлэлийн төрөл: Хаягдал дахин боловсруулах, барилгын материал үйлдвэрлэл, металл хийцийн үйлдвэр, чулуун бүтээгдэхүүний болон хүнд үйлдвэрийн чиглэлээр төрөлжсөн.
- ✓ Гарц: Гипсэн хавтан, хар тугалга, эмульс, хөнгөн блок, тавцан, шат, хайрга, төмөр бетон, ган хийц, дахин боловсруулсан материал, бүтээгдэхүүн.
- ✓ Зах зээл / Хүлээн авагч: Барилгын компаниуд, худалдааны төвүүд, экспортын компаниуд, гадаад зах зээл, зам тээврийн компаниуд, уул уурхай болон төрийн байгууллагууд.

Орцын хувьд олон компани цемент, элс, шохой, хаягдал металл, дугуй, пластик зэргийг ашигладаг нь нийтлэг нийлүүлэлтийн дэд бүтэц шаардлагатайг харуулж байна. Үйлдвэрлэлийн хувьд дахин боловсруулалт, барилгын материал, металл хийц гэсэн 3 гол чиглэл давамгайлж байгаа нь кластер хөгжлийн тодорхой зураглалыг бүрдүүлж байна. Гарцын хувьд олон төрлийн бүтээгдэхүүн (хар тугалга, шат, тавцан, хавтан, бетон, ган хийц) үйлдвэрлэж буй нь нэг зах зээлд өрсөлдөх биш, харин нийлүүлэлтийн сүлжээг бүрдүүлэх давуу талыг илэрхийлж байна.

Хүснэгт 2. 2. НҮТН-ийн нэгжүүдийн үйлдвэрлэлийн процесс

№	Компанийн нэр	Нийлүүлэгчид	Орц	Үйлдвэрлэл	Гарц	Хүлээн авагч нэгжүүд
1	"Пийс стийл групп" ХХК	Хаягдал металл худалдан авах төвүүд, Гэр ахуйн хаягдал болон автомашины сэлбэг хэрэгсэл нийлүүлэгчид. Жнь: Улаанбаатар хотод байгаа хаягдал металл цуглуулагч компаниуд):	Хаягдал төмөр	Ширэм болон ган боловсруулах үйлдвэрлэл	Усан онгоцны тэнцвэржүүлэгч	Усан онгоцны үйлдвэрүүд, Гадаадын компаниуд
2	"Эко минерал трейд" ХХК	Монгол дахь хаягдал батарей худалдан авах төвүүд, Иргэд ААН-д. Жнь: Гэр ахуйн болон аж ахуйн хэрэглээний батарей хүлээн авдаг компаниуд, Хуучин машины батарей хүлээн авч дахин боловсруулах компаниуд.	Хаягдал цэнэг хураагуур	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл	Гипсэн хавтан, хар тугалга	Дотоодын болон гадаадын барилгын компаниуд
3	"Электрокем Монгол" ххк	Монгол дахь хаягдал батарей худалдан авах төвүүд, Иргэд ААН-д. Жнь: Гэр ахуйн болон аж ахуйн хэрэглээний батарей хүлээн авдаг компаниуд, Хуучин машины батарей хүлээн авч дахин боловсруулах компаниуд.	Хаягдал батарей	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл	Хар тугалга	Дотоодын болон гадаадын барилгын компаниуд
4	"Хөгжил комплекс" ХХК /Хажирын гол/	Дотоодын болон Импортын компаниуд. Жнь: Элсны карерүүд, Монгол Улсад Портланд цемент, полимер нунтаг зэрэг барилгын материалын түүхий эдийг нийлүүлдэг компаниуд. Жнь: МАК, Монцемент, Монгол элс, Алтангол элс гэх мэт	Элс, Портланд цемент, Полимер нунтаг гэх мэт	Барилгын материалын үйлдвэрлэл	Эмульс, хуурай хольц	Барилгын материалын дэлгүүр, худалдааны төвүүд болон Барилгын компаниуд
5	"Координат чойсе" ХХК	Барилгын бүх төрлийн төмөр бэлдэц үйлдвэрлэдэг дотоодын компаниуд болон барилгын материал импортлон дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээг ханган буй ААН. Жнь: Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Улаанбаатар менежмент, Xingfa Aluminium, Believe Chemical гэх мэт	Ган, хар төмөр, хайлш, хөнгөн цагаан, цайр	Барилгын металл хийцийн үйлдвэрлэл	Металл шат, тавцан	Барилгын материалын худалдааны төвүүд болон Барилгын компаниуд
6	"Төгсбилэг инженеринг" ХХК	Улаанбаатар хотод хаягдал тос цуглуулах, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд болон Хувийн цуглуулагчид. Жнь: Грийн ойл, Хай би ойл ХК гэх мэт	Хаягдал тос	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл	Дизель түлш, дээврийн хар цаас, ус чийг тусгаарлагч материал	Уул уурхай болон Барилга, Тээврийн компаниуд

№	Компанийн нэр	Нийлүүлэгчид	Орц	Үйлдвэрлэл	Гарц	Хүлээн авагч нэгжүүд
7	"Айвуун Аргалант" ХХК	Улаанбаатар хот болон Монгол Улсад Портланд цемент, элс, шохойн чулуу, кварцын нунтаг, полимер нунтаг зэрэг барилгын түүхий эдийг нийлүүлдэг байгууллагууд.	Портланд цемент, Элс, Шохойн чулуу, Кварцын болон полимер нунтаг	Барилгын материалын үйлдвэрлэл	Хөнгөн блок, хуурай хольц, замаска	Барилгын материалын худалдааны төвүүд болон Барилгын компаниуд
8	"Ногоон цагираг" ХХК	Монгол Улсад болон ойролцоох бүс нутагт байгалийн чулуу болон хиймэл чулуу олборлох, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд болон уурхайнууд.	Байгалийн чулуу, Хиймэл чулуу	Чулуун хийцийн үйлдвэрлэл	Чулуун шал, хавтан, тавцан	Барилгын материалын худалдааны төвүүд болон Барилгын компаниуд
9	"Грейт Монголиа групп" ХХК	Улаанбаатар хот болон Монгол Улсад Портланд цемент, элс, хайрга, төмөр арматур зэрэг барилгын түүхий эдийг нийлүүлдэг компаниуд.	Элс, Портланд цемент, Хайрга, Төмөр арматур	Барилгын материалын үйлдвэрлэл	Угсармал бетон	Дотоодын барилгын компаниуд
10	"Сайхан улаан оргил" ХХК	Хаягдал дугуй худалдан авах төвүүд, Гэр ахуйн хаягдал болон автомашины дугуй нийлүүлэгчид. Жнь: Улаанбаатар хотод байгаа хаягдал дугуй, резин цуглуулагчид	Хаягдал хуучин дугуй, резинэн эдлэлүүд	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл	Нунтаг хаймар	Зам барилга болон гадна талбайн тохижилт үйлчилгээний компаниуд
11	"Ивээлт Алтан Гадас Од" ХХК	Бүх төрлийн барилгын компаниуд	Хог хаягдал	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл	Барилгын материал	Дотоодын барилгын компаниуд
12	"Нью метод" ХХК	Монгол дахь хаягдал батарей худалдан авах төвүүд, Иргэд ААН-д. Жнь: Гэр ахуйн болон аж ахуйн хэрэглээний батарей хүлээн авдаг компаниуд, Хуучин машины батарей хүлээн авч дахин боловсруулах компаниуд.	Хаягдал батарей	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл	Хар тугалга	Дотоодын болон гадаадын барилгын компаниуд
13	"Төгсбридж" ХХК	Монгол Улсад ган саваа, цахиурын исэл нийлүүлдэг компаниуд болон цагаан шавар, шохойн чулуу, зэрэг түүхий эдийг нийлүүлдэг уурхайнууд	Ган саваа, Шохойн чулуу, Цахиурын исэл, Цагаан шавар	Барилгын материалын үйлдвэрлэл	Гагнуурын электрод, Хадаас, Шруп	Барилгын материалын дэлгүүр, худалдааны төвүүд болон

№	Компанийн нэр	Нийлүүлэгчид	Орц	Үйлдвэрлэл	Гарц	Хүлээн авагч нэгжүүд
						Барилгын компаниуд
14	"Бетон шийдэл" ХХК	Улаанбаатар хот болон Монгол Улсад Ган, төмөр, Гагнуурын электрод, Элс, хайрга, Амратур төмөр зэрэг барилгын түүхий эдийг нийлүүлдэг байгууллагууд.	Ган, төмөр, Гагнуурын электрод, Элс, хайрга, Амратур төмөр,	Барилгын материалын үйлдвэрлэл	Металл карказ, Төмөр бетон	Дотоодын барилгын компаниуд
15	"Си энд Эй Преспорти" ХХК	Хаягдал өнгөт металл худалдан авах төвүүд, Гэр ахуйн хаягдал болон автомашины сэлбэг хэрэгсэл нийлүүлэгчид Жнь: Улаанбаатар хотод байгаа 2догч түүхий цуглуулагчид	Хаягдал зэс, хаягдал хөнгөн цагаан, Хаягдал батарей, Гууль, цагаан тугалга, цайр	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл	Өнгөт металл	Барилгын материалын худалдааны төвүүд болон Барилгын компаниуд



Кластерын хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх боломжит үе шат

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Урт хугацааны хөгжлийн бодлого (Алсын хараа-2050), Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжийн ерөнхий төлөвлөгөө бодлого, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, Налайхын засаг, захиргааны байгууллагуудаас улсын, бүсийн, орон нутгийн хөгжилтэй холбогдон гаргасан тогтоол шийдвэр, төсөл, бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа нь Налайхын УТП-ийг байгуулах КЛАСТЕР-ийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгалаа олсон бөгөөд уг төлөвлөгөөг боловсруулах үндэслэл болно.

Налайхын УТП-ийн КЛАСТЕР нь барилгын материалын үйлдвэрлэл болон бусад салбарыг дэлхийн түвшинд хөгжүүлэх, аж үйлдвэрийн хөгжлийг хангах, шинэ чиглэлийн үйлдвэрлэлийг бий болгох, улмаар экспортыг өсгөх, импортыг орлоход бодитой хувь нэмэр болох зэрэг ерөнхий зорилгыг агуулахын зэрэгцээ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, Налайх дүүргийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг сайжруулах, хүрээлэн буй байгаль орчны тогтвортой байдлыг хангах, боловсруулах аж үйлдвэрийн салбарт түшиглэсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн болно.

Кластерын хөгжлийг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчин, хот байгуулалтын асуудлын уялдаа, эдийн засгийн шүтэлцээнд авч үзлээ. Төр, хувийн хэвшлийн түншлэл, сайн засаглал, орон нутгийн бие даасан байдал зэргийг хангах нь бүс нутгийн хөгжлийн тулгуур зарчим гэж тодорхойлж, дунд хугацаанд Налайх дүүргийн хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, тогтвортой хөгжлийн урьдач нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Хүснэгт 2. 3. Хэрэгжилтийн үе шат ба хугацаа

Үе шат	Хугацаа	Үндсэн зорилт
1-р үе шат	2025–2027	Суурь дэд бүтэц, анхны үйлдвэрүүдийг идэвхжүүлэх
2-р үе шат	2027–2030	Үйлдвэрлэл өргөжүүлэх, ухаалаг технологи нэвтрүүлэх
3-р үе шат	2030–2040	Экспортын үйлдвэрлэл өргөжүүлж, инновацын экосистемийг бүрдүүлэх

Кластер байгуулах хөгжлийн үе шатанд дараах чиглэлийг голлон анхаарах шаардлагатай.

- Дэд бүтэц, ухаалаг үйлдвэрлэл зэрэгт төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх стратегийг эхлүүлнэ.
- Ногоон санхүүжилтийн боломжууд (EX, UNIDO, GCF төслүүд) ашиглан эко кластерийн хөгжлийг түргэтгэх хэрэгтэй.
- Шинэ технологийн нутагшилт, R&D төв байгуулах, чадавхжуулах төв хөгжүүлэх замаар инновацын экосистем бий болгох ёстой.

Хүснэгт 2. 4. Налайхын УТП-ийн кластерын хөгжлийн үе шатын төлөвлөгөө

Үе шат	Хугацаа	Гол үйл ажиллагаа	Тайлбар
1-р үе шат	2025-2026	Суурь дэд бүтцийн өргөтгөл, анхны үйлдвэрлэлийн эхлэл	Цахилгаан, дулаан, ус, зам, холбооны өргөтгөл
2-р үе шат	2026-2027	Үйлдвэрүүдийн хүчин чадал нэмэгдүүлэх, автоматжуулалт эхлүүлэх	Хагас автомат шугамууд суурилуулах, чанар стандартад нийцүүлэх
3-р үе шат	2027-2028	Ногоон үйлдвэрлэл, дахин боловсруулалт хөгжүүлэх	Эко бүтээгдэхүүн, дахин боловсруулсан түүхий эд ашиглах



4-р үе шат	2028-2029	Инновац ба ухаалаг үйлдвэрлэл нэвтрүүлэх	IoT, BIM, AI суурилсан үйлдвэрлэлийн шийдэл хэрэгжүүлэх
5-р үе шат	2029-2030	Экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, кластерын өргөтгөл	ЕАЭЗХН болон Ази Номхон далайн зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх

Үйлдвэрлэл технологийн паркийн кластерын зохион байгуулалт, менежментээр хангах бодлого нь тухайн парк дахь аж ахуйн нэгжүүдийн уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг дэмжих замаар үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, инновацыг хурдасгах, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэсэн байна. Энэ бодлого дараах үндсэн чиглэлүүдтэй байж болно. Үүнд:

1. Кластерын бүтцийн зохион байгуулалт

- **Салбарын төвлөрөл:** Тодорхой чиглэл (жишээ нь, барилгын материал, хог хаягдал боловсруулах, металл боловсруулах ЖДҮ-ийг хөгжүүлэх, хүнс гэх мэт)-д суурилсан үйлдвэрүүдийн багц бий болгох.
- **Дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хамтын ашиглалт:** Бүх компаниудын хэрэгцээнд нийцсэн орчин үеийн лаборатори, агуулах, логистикийн төв зэрэг нөөцүүдийг төвлөрүүлэх.
- **Судалгаа, хөгжүүлэлтийн төв:** Шинэ технологи, инновацыг нэвтрүүлэхэд зориулсан судалгааны лабораториудыг парк дотор байгуулах.

2. Хамтын ажиллагааг дэмжих менежмент

- **Сүлжээ ба түншлэл:** Паркийн компаниуд хооронд мэдээлэл солилцох, хамтарсан төслүүд хэрэгжүүлэхийг урамшуулах.
- **Инкубатор болон акселераторын (хурдасгуур) хөтөлбөр:** Стартап, жижиг дунд бизнесүүдэд санхүүгийн болон технологийн дэмжлэг үзүүлэх систем бий болгох.
- **Ажлын байр ба мэргэшсэн ажиллах хүч:** Хүний нөөцийн сургалт, чадавхжуулалтын төвүүдийг ажиллуулж, паркийн дотор ажиллах мэргэжилтнүүдийг тасралтгүй сургах.

3. Тогтвортой хөгжлийн бодлого

- **Ногоон үйлдвэрлэл:** Байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих.
- **Экологийн стандартын хэрэгжилт:** Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор хаягдал, бохирдлыг хянах системийг тогтоох.

4. Зах зээлд өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх бодлого

- **Гадаад зах зээлд гаргах дэмжлэг:** Экспортын чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын стандартад нийцэх бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.
- **Брэнд болон маркетингийн стратеги:** Паркаас гарсан бүтээгдэхүүнийг нийтэд таниулах хамтын брэнд хөгжүүлэх.
- **Санхүүгийн дэмжлэг ба хөрөнгө оруулалт:** Кластер доторх бизнесүүдэд хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт татах бодлого хэрэгжүүлэх.



5. Удирдлага, хяналт

- **Кластерын зохицуулалтын төв байгууллага:** Паркийн үйл ажиллагааг хариуцан зохицуулах, зохион байгуулалтын төв байгуулах.
- **Хяналт, үнэлгээний тогтолцоо:** Компаниудын үйл ажиллагааг тасралтгүй үнэлж, амжилттай хэрэгжиж буй арга хэмжээг түгээх.
- **Орон нутгийн оролцоог хангах:** Орон нутгийн удирдлага, иргэдтэй нягт хамтран ажиллаж, хариуцлагатай хөгжлийг дэмжих.

Энэхүү агуулгын хүрээнд Паркийн кластерын бодлогыг хэрэгжүүлэхэд улсын болон орон нутгийн дэмжлэгийг татан оролцуулах шаардлагатай ба Паркийн дотоод зохион байгуулалтыг тасралтгүй сайжруулж, инновацын экосистемийг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь кластерын хүрээнд ажиллаж буй компаниудын үр ашгийг нэмэгдүүлэх төдийгүй бүс нутгийн эдийн засагт чухал хувь нэмэр оруулах боломжтой болох юм.


Налайхын УТП-ийн кластерын тэргүүн ээлжид хэрэгжүүлэх арга хэмжээ, тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон болно. Үүнд:

- ✓ Монгол Улсын болон Улаанбаатар хотын барилгын материал үйлдвэрлэлийг төвлөрүүлэх, барилгыг материалын үйлдвэрлэлд (бетон хийцийн үйлдвэр, хавтангийн үйлдвэр, металл хийцийн үйлдвэр, хог хаягдал дахин боловсруулах ба бусад үйлдвэрлэл, үйлчилгээ) төвлөрөн хөгжүүлэх
- ✓ Шинэ дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаа эрхлэх, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнг түшиглэсэн барилгыг болон боловсруулах үйлдвэрийн технологийн судалгаа, хөгжлийн төв байгуулах,
- ✓ Тээвэр логистик, гаалийн баталгаат агуулахын бүс байгуулах,
- ✓ Барилгын үйлдвэрлэлийг дагаж хөгжих жижиг дунд үйлдвэрийн бүс байгуулах,
- ✓ Кластерын инженерийн суурь дэд бүтцийн санхүүжилтийг шийдвэрлэх
- ✓ Кластер нь кластерын захиргаа байрлах бизнес төвтэй, ногоон бүс, авто зам, нөөц газартай байх.
- ✓ Цаашид Налайх УТП-г дараах нэгжүүдийг төрөлжүүлэх боломжтой байна. Үүнд:
 - Барилгын түүхий, эд материалын үйлдвэрүүд
 - Бетон зуурмагийн үйлдвэр, түүний түүхий эд, материалын үйлдвэр
 - Төрөл бүрийн барилгын жижиг, дунд үйлдвэрүүд
 - Барилга засварын цех
 - Металлын материал боловсруулах үйлдвэр, жижиг деталь үйлдвэрүүд
 - Барилгыг материалын худалдаа

Үйлдвэрлэл, технологийн кластерын үйл ажиллагаа нь Төр-Их дээд сургууль, Эрдэм шинжилгээний байгууллага - кластерын нэгжүүдийн зохистой шүтэлцээ, нягт хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжих юм.



Зураг 2. 3. Кластерын уялдаа холбоо



Кластерын оролцогч талуудын харилцааг дараах байдлаар томъёолж болно.


Хүснэгт 2. 5. Оролцогч талуудын оролцооны бүтэц

Оролцогч тал	Үүрэг, оролцоо
Налайхын Үйлдвэрлэл Технологийн Парк ХК	Төсөл хэрэгжүүлэгч үндсэн байгууллага; Ерөнхий менежмент, мониторинг
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Бодлогын дэмжлэг, зохицуулалт, хөрөнгө оруулалтын дэмжлэг
ХББОСЯ (Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам)	Барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, стандартын уялдаа
Гадаадын хөрөнгө оруулагчид	Хамтарсан үйлдвэр байгуулах, хөрөнгө оруулах
Орон нутгийн ААН-үүд, үйлдвэр эрхлэгчид	Үйлдвэрлэл эрхлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх
Санхүүжилтийн байгууллагууд (банкнууд, хөрөнгө оруулалтын сан)	Төсөлд санхүүжилт гаргах, хөнгөлөлттэй зээл, баталгаа олгох
Боловсрол, судалгааны байгууллагууд	Хүний нөөц бэлтгэх, технологийн инновац, судалгаа, сургалт
Байгаль орчны байгууллагууд	Ногоон үйлдвэрлэл, тогтвортой хөгжлийн хяналт, дэмжлэг

Тус судалгааны баг кластерын менежментийн системийг дараах зурагт үзүүлсэн схемийн дагуу баримталж хэрэгжүүлэх нь бодитой гэж үзэж байна.



Зураг 2. 4. Үйлдвэрлэлийн менежментийн систем



Аливаа кластерын хөгжил нь тухайн улс орны нийгэм, эдийн засагт шууд болон шууд бусаар томоохон нөлөө үзүүлдгийн хувьд улс орон, бүс нутаг, хамаарах салбарын хөгжлийн үзэл баримтлал, бодлогуудтай нийцтэй байх нь чухал юм. Улс орнуудын эдийн засгийн нийтлэг зорилго нь жигд тогтвортой, хүртээмжтэй өсөлтөд хүрэх байдаг. Иймд, кластерын урт хугацааны стратегийн гол зорилго нь эдийн засгийн бодлогын чухал хэсэг байх учиртай. Кластер нь аж үйлдвэрийн бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл юм. Монгол Улсын аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын тулгамдаад буй асуудлуудыг бид дараах байдлаар харж байна.

- Манай орны барилгын материалын үйлдвэрлэлийн хөгжил эрчимжиж, эдийн засгийн өсөлттэй боловч аж үйлдвэрийн бусад салбарын хөгжлийн хурдац хангалттай бус, тэдгээр нь бодит нөөц боломжоо ашиглах хэмжээнд хүрч чадахгүй олон жил болж байгаа төдийгүй цаашдаа ч энэ хэвээр байвал эдийн засагт сөрөг нөлөөлөх нөхцөл нэгэнт бүрдсэн байна.
- Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан бүсийн тулгуур төвүүд болон хот суурин газар, тухайлбал, Улаанбаатар хот болон Налайх, Багахангай дүүргийг хөгжүүлэх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгамдсан эрэлт хэрэгцээ болоод байна.

Кластер нь дээрх тулгамдсан асуудлуудыг даван туулахад түлхэц болох гол арга хэрэгсэл болно. Цаашилбал, кластерын бүтээн байгуулалт, хөгжил нь зөвхөн аж үйлдвэр төдийгүй, хөрөнгө оруулалт, худалдаа, төсөв, санхүүгийн бодлого, дэд бүтэц, эрчим хүч, байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх болон зөвлөх үйлчилгээ, ажиллах хүчний хөгжил, инновацыг дэмжих, институцыг бэхжүүлэх зэрэгт томоохон түлхэц өгөх чухал ач холбогдолтой.

Энэхүү кластерын урт хугацааны хөгжлийн стратегийн гол зорилго нь барилгын материалын үйлдвэрийг бие даан хөгжүүлэх, баялгийг дотооддоо боловсруулах, нэмүү өртөг шингэсэн, импортыг орлох, экспортын төрөлжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, кластерын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтаар дамжуулан Улаанбаатар хот төдийгүй, кластерын ойр орчмын бүс нутаг, цаашлаад улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм. Тухайлбал, кластерын үйл ажиллагаа нь манай улсын гол тулгамдсан асуудлын нэг болох эдийн засгийн уул уурхайн салбараас хараат байдлыг бууруулах, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна. Түүнчлэн, кластер нь татвар, хураамж улсын болон орон нутгийн төсөвт төлснөөр төсвийн орлогыг нэмэгдүүлэх, өнөөгийн гадаад өрийн дарамтыг бууруулахад түлхэц болно. Кластер нь дотоодод шинээр



ажлын байр үүсгэх, ажиллах хүчний ур чадварын нэмэгдүүлэх мөн үйлдвэрлэлийн завсрын хэрэглээгээр дамжуулан кластерын бүс нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, өрхийн амьжиргааг дээшлүүлэх чухал ач холбогдолтой юм.

Улмаар Налайхын УТП-д кластер байгуулан хөгжүүлэх талаар дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Монгол улсын нийслэл нь дэд бүтэц сайн хөгжсөн, мэргэшсэн ажиллах хүчний нөөц бүрдсэн, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн материаллаг бааз суурь бүрдсэнээр харьцангуй давуу талтай байна. Энэхүү бий болсон эдийн засгийн чадавх, мэдлэг оюунд суурилсан хөгжлийн хандлагад нийцүүлэн Налайхын УТП-д кластер хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.
2. Налайхын болон төвийн бүсийн ирээдүйн хөгжлийн хандлага барилгын материалын үйлдвэрлэлд тулгуурласан, орчин үеийн дэвшилтэд технологид суурилсан үйлдвэрлэл, технологийн цогцолбор амжилттай хөгжих боломжтой юм.
3. Кластерын бүсэд хөгжүүлэх үйлдвэрүүдийн зураглал, төлөвлөгөө боловсруулснаар импортыг орлох, экспортод гаргах өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбаруудыг уялдуулан хөгжүүлэх бүрэн боломжтой нь кластерын бүсэд байгуулагдах төслүүдээс шууд шалтгаалах нь харагдаж байна.
4. Кластерын үйл ажиллагаа нь барилгын материалын үйлдвэрлэлийн үндсэн чиглэлтэй байх бөгөөд бусад үйлдвэрлэлийн чиглэлийг дэмжинэ.
5. Налайхын УТП-ийн кластерын зохион байгуулалтыг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх арга хэмжээ, тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:
 - Одоогийн гэрээ байгуулсан үйлдвэрүүдийг түүний түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний чиглэлээр Үйлдвэрлэл, технологийн кластерыг хөгжүүлэх,
 - Шинэ дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаа эрхлэх, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнг түшиглэсэн барилгын материалын боловсруулах үйлдвэрийн технологийн судалгаа, хөгжлийн төв байгуулах,
 - Тээвэр логистик, гаалийн баталгаат агуулахын бүс байгуулах,
 - Кластерын үйлдвэрлэлийг дагаж хөгжих жижиг дунд үйлдвэрийн бүс байгуулах, барилгын материалын худалдаа, арилжааны бүс байгуулах
6. Үйлдвэрлэл, технологийн кластерын үйл ажиллагаа нь Төр-Их дээд сургууль, Эрдэм шинжилгээний байгууллага-кластерын нэгжүүдийн зохистой шүтэлцээ, нягт хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ.
 - a. Төрийн оролцоо: Хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэн, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
 - b. Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага: Инновацын төслүүд, нанотехнологийг боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх
 - c. Бизнесийн байгууллагын оролцоо: Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын боловсруулсан инновацын төсөл, нанотехнологийг нэвтрүүлж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн олон улсын зах зээлд өрсөлдөнө.

Дээрх нийгэм, эдийн засгийн ач холбогдол тухайн кластерт хэрэгжих боломжтой шинэ шинэ төслүүдийн ашигт ажиллагаанаас шалтгаалж, тасралтгүй өсөн нэмэгдэх бүрэн боломжтойн дээр ажлын байр нэмэгдүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллаж, амьдрах хэв шинжийг бүрдүүлэх, гадаад дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг татах, урт хугацаанд үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн бодит хэрэгжилтийг хангах суурь нөхцөл болохоор байна.



2.3. Санхүүжилтийн бүтэц, загварчлал

2.3.1 Налайхын ҮТП-д шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ

Паркийн үйлчилгээний орлого, зардлын шаардлагатай санхүүжилт

“Налайхын Үйлдвэрлэл Технологийн Парк” ХК-ийн үндсэн зорилго нь Монгол Улсын барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт нэмүү өртөг шингэсэн, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх паркийн харьяа үйлдвэрийн төслийн хэрэгжилтийг хангах, төслийг амжилттай хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, төслийг хэрэгжүүлэх явцад төрийн байгууллага, Улаанбаатар хотын захиргаа, Налайх дүүрэг болон төслийн үйлдвэрүүдийн ажлын уялдаа холбоог хангах, зохион байгуулалт хийж, хяналт тавихад оршино. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2024 оны 03-р сарын 25-ны өдөр 38-р тогтоолоороо “Налайх Барилгын Материалын ҮТП”ОНӨҮГ-ыг өөрчлөн зохион байгуулж, шинээр хувьцаат компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталсан. Одоогоор нийт 18 инженер, техникийн ажилтны орон тоотой, 2025 оны эхнээс жилийн 800 сая төгрөгийн зардлын төсөвтэй, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх үүрэгтэй ажиллаж байна. Тус компани бүтцийн өөрчлөлтийн дараа 73,9 тэрбум төгрөгийн дүрмийн сантай болж, компанийн нийт хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн.

“Налайхын Үйлдвэр Технологийн Парк” ХК нь Менежментийн компани хэлбэрээр зохион байгуулагдсанаар одоо гэрээ байгуулсан 15 компани, шинээр орох 22 компанийн үйлдвэртэй Менежментийн гэрээ байгуулж, төлбөрт үйлчилгээг үзүүлж болно. Парк нь Менежментийн компани хэлбэрээр зохион байгуулагдсанаар дараах үйлчилгээг паркийн хэмжээнд үзүүлэх боломжтой юм.

Хүснэгт 2. 6. Менежментийн компаниас ҮТП-ийн нэгжүүдэд үзүүлж болох төлбөрт үйлчилгээний төрөл

№	Үйлчилгээний чиглэл	Үйлчилгээний төрөл
1	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА (Бизнесийн зөвлөх үйлчилгээ)	Хөрөнгө оруулалтын боломжийн судалгаа
2		ТЭЗҮ, бизнес төлөвлөгөө боловсруулах
3		Зах зээлийн судалгаа
4		Технологи, тоног төхөөрөмжийн судалгаа, сонголт
5		Төлбөр цуглуулах, нэхэмжлэх
6		Паркийн нэгжийн бүтээгдэхүүнийг сурталчлах, таниулах
7	БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ, ИННОВАЦ (Судалгаа хөгжүүлэлт)	Бүтээгдэхүүний загвар, дизайн боловсруулах
8		Шинэ бүтээгдэхүүний судалгаа, туршилт
9		Шинэ санаа дэмжих, урамшуулах
10		Үзэсгэлэн худалдаа, эвент зохион байгуулах, оролцох
11		Технологи дамжуулалт, шинэ технологи нэвтрүүлэлт
12	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА (Техникийн зөвлөх үйлчилгээ)	Дэд бүтцийн хэрэгцээ, төлөвлөлт
13		Үйлдвэрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх
14		Үйлдвэрлэлийн туршилт хийх, дүгнэлт гаргах
15		ХАБЭА-н сургалт зохион байгуулах
16		Сургалт зохион байгуулах
17		Стандарт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх үйлчилгээ



№	Үйлчилгээний чиглэл	Үйлчилгээний төрөл
18	ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИ,	Диспетчер /Шуурхай удирдлагын үйлчилгээ
19	ХӨГЖҮҮЛЭЛТ БА ПАРКИЙН	Харуул хамгаалалтын үйлчилгээ, гал команд
20	АШИГЛАЛТ	Ногоон байгууламжийн үйлчилгээ
21	(Паркийн ашиглалтын	Паркийн хотхоны цэвэрлэгээ, хог хаягдлын менежмент
22	үйлчилгээ	Дэд бүтцийн арчлалт, үйлчилгээ
23	Тээвэр, логистикийн	Агуулахын үйлчилгээ
24	үйлчилгээ)	Тээвэр зохион байгуулах үйлчилгээ
25		Ачих буулгах үйлчилгээ

2.3.2. НҮТП-ийн нэгжүүдээс паркийн хураамжаар орлого бүрдүүлэх, санхүүжилт авах загвар

Үйлдвэрлэл, технологийн паркийн менежментийн компани нь паркийн хураамжийг шударга, ил тод, эдийн засгийн үндэслэлтэй байдлаар тогтоох нь чухал юм. Паркийн хураамжийг тогтоохдоо дараах зарчмуудыг баримтлах шаардлагатай. Үүнд:

- ✓ Паркийн хураамжийг тогтоохдоо ил тод байдал, сонирхогч талуудын оролцоо, зөвшилцлийн зарчмыг баримтлах.
- ✓ Паркийн нэгжүүдтэй хамтран паркийн хураамжийн системийн талаар хэлэлцэж, харилцан тохиролцох
- ✓ Монгол Улсын хууль, дүрэм, журамд нийцүүлэх
- ✓ Паркийн нэгжүүдийн саналыг сонсож, оролцоог хангаснаар паркийн хураамжийн системийн үр дүнг сайжруулах боломжтой байх.
- ✓ Паркийн хураамжийг тогтоохдоо зардал, үйлчилгээ, үйлдвэрүүдийн онцлогийг харгалзан шударга, тогтвортой, үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг хангах.

Паркийн хураамжийг дараах аргачлалуудаас **сонгон ашиглах боломжтой**.

1.Зардалд үндэслэн гаргах аргачлал: Төлбөрийг дараах зардлуудыг тооцож тогтоох

- ✓ Дэд бүтцийн зардал: Зам, цахилгаан, усан хангамж, ариутгах татуурга, харуул хамгаалалт зэрэг паркийн нийт үйл ажиллагаанд шаардлагатай зардлууд.
- ✓ Удирдлагын зардал: Менежмент, ажилчдын цалин, оффисын зардал, судалгаа, маркетингийн зардал гэх мэт удирдлагын үйл ажиллагаатай холбоотой зардлууд.
- ✓ Сэргээн засварлах болон хөрөнгө оруулалтын зардал: Дэд бүтцийн засвар үйлчилгээ, шинэчлэл, паркийн хөгжүүлэлтэд шаардагдах хөрөнгө оруулалтын зардал.

2.Үйлдвэрүүдийн онцлогт нийцүүлэх аргачлал: Паркийн нутаг дэвсгэрт багтсан үйлдвэрүүдийн:

- ✓ Талбайн хэмжээ
- ✓ Үйл ажиллагааны цар хүрээ
- ✓ Ашиглаж буй дэд бүтцийн ачаалал
- ✓ Үйлдвэрлэлийн төрөл гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан ялгаатай хураамжийн түвшнийг тогтоож болно.



3. Зах зээлийн харьцуулалтын аргачлал:

- ✓ Бусад ижил төстэй паркийн жишиг: Үйлдвэрлэл, технологийн паркийн хураамжийн жишгийг судалж, зах зээлд өрсөлдөхүйц түвшинд байлгах.
- ✓ Тус бүс нутгийн онцлог: Байршил, зах зээлд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэх.

Үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрт багтсан үйлдвэрүүдээс авах паркийн хураамжийг тогтоох математик загвар нь олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ дээр үндэслэгдэнэ. Тухайлбал, талбайн хэмжээ, дэд бүтцийн хэрэглээ, үйл ажиллагааны төрөл, зардлын бүтэц, болон зах зээлийн нөхцөл зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Эдгээрийг нэгтгэсэн шугаман программчлалын загвар болон төлөвлөлтийн функцийг ашиглаж болно.

Загварын үндсэн хувьсагчид

C – нийт хураамжийн хэмжээ (төгрөг)

x_i – i -р үйлдвэрийн эзэмшиж буй талбай (m^2)

u_i – i -р үйлдвэрийн дэд бүтцийн хэрэглээ (ус, цахилгаан, дулаан гэх мэт)

t_i – i -р үйлдвэрийн үйл ажиллагааны цар хүрээ

f_i – паркийн удирдлагын нэмэлт үйлчилгээний хураамж (i -р үйлдвэрт ногдох)

Z – паркийн нийт зардал (удирдлага, дэд бүтэц, хөгжүүлэлт)

n – паркийн нэгжид багтах үйлдвэрүүдийн тоо

Загварын зорилтот функц

ҮТП-ийн менежментийн компаниас паркийн нэгжүүдэд ногдуулах паркийн хураамжийн хэмжээг шударга, зардлыг нөхөхүйц, бодитой түвшинд тогтоох зорилгоор дараах функцийг ашиглахаар төлөвлөсөн.

$$C = \sum_{i=1}^n (\alpha \cdot x_i + \beta \cdot u_i + \gamma \cdot t_i + f_i)$$

α – талбайд ногдох хураамжийн коэффициент (төгрөг/ m^2)

β – дэд бүтцийн хэрэглээний коэффициент (төгрөг/нэгж хэрэглээ)

γ – үйл ажиллагааны төрөлд суурилсан коэффициент (жин, 0-1 хооронд)

f_i – үйлчилгээний хураамж тогтмол эсвэл хувьсах хэлбэрээр тогтоох боломжтой

Загварыг ашиглах хязгаарлалтын нөхцөлүүд

1. Нийт хураамжийн хэмжээ нь ҮТП-ийн нийт зардлыг нөхөх ёстой. Өөрөөр хэлбэл

$$C \geq Z$$

2. Үйлдвэрүүдийн хувьсагчид бодит утга байх ёстой

$$x_i > 0, \quad u_i \geq 0, \quad t_i \in [0,1]$$



3. Талбайд ногдох хураамж бодит хязгаарт байх (зах зээлийн жишиг)

$$\alpha_{min} \leq \alpha \leq \alpha_{max}$$

4. Дэд бүтцийн хэрэглээний хязгаарлалтууд

$$\sum_{i=1}^n u_i \leq U_{total}$$

U_{total} – паркийн дэд бүтцийн хүчин чадлын дээд хязгаар

Паркийн хураамж нь Гишүүнчлэлийн хураамж(ПХ-1), Менежментийн хураамж (ПХ -2), Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын хураамж (ПХ -3), Ашиглалтын хураамж(ПХ -4), Бусад хураамж(ПХ-5)-уудын нийлбэрээр тооцогдоно.

Хүснэгт 2. 7. Паркийн хураамжийн бүрэлдэхүүн хэсгүүд

Паркийн хураамжийн бүрэлдэхүүн хэсэг	Паркийн хураамжийн бүрэлдэхүүн хэсэг	Зардлын бүрэлдэхүүн хэсэг
ПХ-1	Гишүүнчлэлийн хураамж	Паркийн нэгжид элсүүлэх шийдвэр гарч, гэрээ байгуулснаар нэг удаа төлнө.
ПХ-2	Менежментийн хураамж	Паркийн дэд бүтцийн ашиглалт болон удирдлагын зардлыг нөхөх зорилгоор улирал бүр тогтсон хэмжээний төлбөр авах
ПХ-3	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын хураамж	Паркийн хог хаягдлын менежмент, харуул хамгаалалт, цэцэрлэгжүүлэлт, байгаль орчны нөхөн сэргээлт зэрэг нэмэлт үйлчилгээнд зориулан улирал бүр авах
ПХ-4	Эрчим хүч, дэд бүтэц, авто зам ашигласны хураамж	Ус хангамж, дулаан, цахилгаан, уур, зам зэрэг дэд бүтцийн хэрэглээний төлбөрийг бодит хэрэглээнээс хамааруулан тооцож, улирал бүр авах
ПХ-5	Бусад үйлчилгээний хураамж	Паркийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тохижуулах, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилготой ба тухай бүр гэрээгээр зохицуулна.

2.3.3. НҮТП-ийн Хураамжийн Орлогын Тооцоолол

Судлаачид нь “Налайхын Үйлдвэр Технологийн Парк” ХК-ийн санал болгосон Зардалд үндэслэсэн “Паркийн нэгжээс паркийн удирдлагад хураамж төлөх” журмын аргачлалаар **жишиг тооцоолол** хийсэн. “Налайхын Үйлдвэр Технологийн Парк” ХК-ийн төвлөрүүлэх орлого нь үйл ажиллагаагаа эхэлсэн 15 үйлдвэрийн хувьд тооцоход жилд 3195.29 сая төгрөг буюу 934.3 мянган ам.доллар болохоор байна.

$$ПХ = ПХ1 + ПХ2 + ПХ3 + ПХ4 + ПХ5$$



Хүснэгт 2. 8. УТП-ийн менежментийн компанийн жилд төвлөрүүлэх орлогын төсөөлөл 2028-2030 онд, сая төг.өөр, эхний 15 үйлдвэрээр

№	Паркийн нэгжийн нэр	Гишүүнчлэлийн хураамж (ПХ-1)	Менежмент-ийн хураамж (ПХ-2)	Байгаль орчин, нөхөн сэргээх ажлын хураамж (ПХ-3)	Эрчим хүч, дэд бүтэц, авто зам ашиглалтын хураамж (ПХ-4)	Бусад хураамж (ПХ-5)	Паркийн хураамжийн нийт дүн (ПХ)
1	Пийс стийл групп	10.00	11.56	12.59	146.00	0	180.15
2	Хөгжил комплекс	10.00	7.50	8.17	58.40	0	84.07
3	Эко минерал трейд	10.00	4.63	5.04	94.70	0	114.36
4	Электрокем монгол	10.00	25.56	27.83	322.78	0	386.18
5	Координат чойсе	10.00	20.00	21.78	252.54	0	304.32
6	Сайхан улаан оргил	10.00	18.75	20.42	236.76	0	285.93
7	Грейт Монголиа групп	10.00	19.69	21.44	248.60	0	299.72
8	Ногоон цагираг	10.00	9.13	9.94	115.22	0	144.28
9	Айвуун аргалант	10.00	18.75	20.42	236.76	0	285.93
10	Нью метод	10.00	7.50	8.17	94.70	0	120.37
11	Ивээлт алтан гадас од	10.00	25.00	27.22	315.68	0	377.90
12	Төгс билэг инженеринг	10.00	6.25	6.81	78.92	0	101.98
13	Төгс бридж	10.00	12.50	13.61	157.84	0	193.95
14	Си энд Эй Проспорти	10.00	7.38	8.03	93.13	0	118.54
15	Бетон шийдэл	10.00	12.75	13.88	161.00	0	197.63
16	Нийт дүн	150.00	206.94	225.32	2,613.04	0	3,195.29

Гишүүнчлэлийн хураамж (ПХ -1)-ийг тооцох

Паркийн ТУЗ-өөс тухайн компанийн үйлдвэрийг паркийн нэгжээр элсүүлэх шийдвэр гарч, гэрээ байгуулснаар гишүүнчлэлийн хураамжийг нэг удаа төлнө. Мөн паркийн нэгж болох үйлдвэр нь үйл ажиллагааны явцад хуулийн этгээдийн нэр солих, өөрчлөн зохион байгуулагдах, охин компани нэмж оруулах үед уг хураамжийг дахин авна. Паркийн нэгжээс хураамж төлөх журамд заасны дагуу гишүүнчлэлийн хураамж 10 сая төгрөг ба тухайн жилд гишүүнчлэлийн хураамжийн орлого 150 сая төгрөг болохоор байна.

Менежментийн хураамж (ПХ -2)-ийг тооцох

Менежментийн хураамж нь Паркийн дэд бүтцийн ашиглалтын засвар үйлчилгээ, удирдлагын зардлыг нөхөх, төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор улирал бүр эсвэл жил бүр төлөх төлбөр юм. “Налайх УТП” ХК-ийн 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар эзэмшиж буй 120 га-д байгуулсан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын нийт өртөг 29.99 тэрбум төгрөг буюу 11.12 сая ам.доллар болсон байна.



Хүснэгт 2. 9. Налайх УТП-ийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт 2014-2024 онд, 2026 оноос ашиглалтад жилд гарах урсгал зардал

№	Үзүүлэлт	Дэд бүтцийн нийт хөрөнгө оруулалт	Цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалт	Ус хангамжийн хөрөнгө оруулалт	Авто замын хөрөнгө оруулалт	Төмөр замын хөрөнгө оруулалт	Бусад ажил / Паркийн гадна ажил /
1	Хөрөнгө оруулалт (тэрбум төг)	29,995.20	16,869.30	1,469.76	8,947.57	0	2,708.57
2	Хөрөнгө оруулалт (мянган ам.доллар)	11,121.70	6,254.84	544.96	3,317.60	0	1,004.29
3	Урсгал зардал тооцох хувь (%)	2.50	2.50	2.50	2.50		2.50
4	Дэд бүтцийн урсгал зардал (сая төг)	749.88	421.73	36.74	223.69	-	67.71

Тайлбар: Монгол банкны 2024.12.31-ний албан ханш 1 US\$=3420 төгрөг

Паркийн дэд бүтцийн ашиглалтад жилд гарах урсгал засварын зардлыг хөрөнгийн үнийн дүнгийн 2,5%-аар тооцвол 749.88 сая төгрөг гарч, “Налайхын УТП” ХК-ийн удирдлагын үйл ажиллагааны төсөв 596.0 сая төгрөгийг нэмж тооцвол, паркийн эзэмшиж буй нийт газрын 1 га тутамд 6,250-11,220 мянган төгрөгийн зардал ноогдохоор байна. Паркийн хөгжлийн эхний үед энэ зардал нь эхний 15 үйлдвэрийн хувьд жилд 206.94 сая төгрөг байхаар тооцов.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын хураамж (ПХ -3)-ийг тооцох

Үйлчилгээний хураамж нь Паркийн хог хаягдлын менежмент, харуул хамгаалалт, цэцэрлэгжүүлэлт зэрэг нэмэлт үйлчилгээнд гарах зардлыг нөхөн зорилготой. УТП-ийн менежментийн компанийн хувьд энэ хураамж нь орлого биш бөгөөд гэрээт компаниудад цуглуулан шилжүүлэх шилжих төлбөр юм.

Хүснэгт 2. 10. Паркийн хог хаягдлын менежмент, харуул хамгаалалт, цэцэрлэгжүүлэлтийн жилийн зардал

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (мян төг)	Тайлбар
1	Хог хаягдлын менежмент	ачилт	52	320,000	16,640	Ахуйн хог хаягдал ачих үйлчилгээ нь 1 удаагийн ачилт нь 320,000 төг байна.
2	Харуул хамгаалалт	объект	15		300,000	Улаанбаатар хотын харуул хамгаалалтын үйлчилгээний жилийн зардлыг жишиг болгов.
3	Цэцэрлэгжүүлэлт	м2	50,000	1,000	500,000	
	Нийт дүн				816,640	

Жишээ нь: Улаанбаатар хотын үл хөдлөх хөрөнгийн менежментийн компаниуд нь түрээслэгчдээс түрээсийн зардлаас гадна 1 кв.метр тутмаас 6,000-7,000 төгрөг авч байна. Хог хаягдлын менежмент, харуул хамгаалалт, цэцэрлэгжүүлэлтийн гэрээт компаниудад төлөх



жилийн зардал 816.64 сая төгрөг гарч, паркийн үйлдвэрүүдийн ашиглах газрын 1 га тутамд 6,805 мянган төгрөг ноогдож байна. Энэ зардал нь эхний 15 үйлдвэрийн хувьд жилд 225.32 сая төгрөг болж байна.

Эрчим хүч, дэд бүтэц, авто зам ашигласны хураамж (ПХ -4)-ийг тооцох

Ашигласны хураамж нь ус хангамж, дулаан, цахилгаан, уур, зам зэрэг дэд бүтцийн хэрэглээний төлбөрийг бодит хэрэглээнээс хамааруулан тооцож, сар эсвэл улирал бүр авах хураамж юм. Паркийн нэгжүүд нь дэд бүтцийн үйлчилгээнд төлөх төлбөр буюу нийт зардлын бүтцийг дэд бүтцийн төрлөөс хамааран тус бүрээр авч үзвэл 2-40% байна.

Хүснэгт 2. 11. Паркийн эрчим хүч, дэд бүтэц, авто зам ашигласны хураамж

№	Үзүүлэлт	Цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалт	Ус хангамжийн хөрөнгө оруулалт	Авто замын хөрөнгө оруулалт	Төмөр замын хөрөнгө оруулалт	Бусад ажил /Паркийн гадна хашааны ажил/
1	Хөрөнгө оруулалт (сая төг)	16,869.30	1,469.76	8,947.57	0	2,708.57
2	Хөрөнгө оруулалт (мян ам. доллар)	6,254.84	544.96	3,317.60	0	1,004.29
3	Ашиглалтын зардлын эзлэх хувь	40	34	2	12	12
4	Дэд бүтцийн ашиглалтын зардал (сая төг)	1,045.22	888.43	52.26	313.56	313.56

Паркийн үйлдвэрүүдийн жилд гарах ашиглалтын зардлыг тооцвол нийтдээ 2613.04 сая төгрөг гарч, паркийн нэгжүүдэд 58.40-322.78 сая төгрөг ноогдож байна.

Бусад хураамж (ПХ -5)-ийг тооцох

Бусад хураамжийн олон улсад хэрэглэдэг нэг хэлбэр нь Орлогын дүнгээс бодох хураамж юм. Монгол Улсын ЗГ нь “Рио Тинто” ХК-тай хамтран Оюу Толгой төсөл хэрэгжүүлэхэд, “Оюу Толгой” ХХК нь үйл ажиллагааны зардлаас 2009-2014 онд 6%, 2015 оноос 3%-аар тооцон менежментийн төлбөр төлж байна.

Монгол Улсын ЗГ-ын 2023 оны 108-р тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК нь охин, хараат компани, хуулийн этгээд, төслийн нэгжээс борлуулалтын орлогын 1-2%-аар тооцон менежментийн төлбөр авахаар 2023 оноос хуульчлан баталсан байна. Энэхүү тогтоолоор батлагдсан эрх зүйн актын зүйл, заалтыг авч үзвэл, Компанийн удирдлага гэсэн бүлэг 3-т:

3.5.2.Компани нь охин, хараат компани, харьяа хуулийн этгээд, төслийн нэгжтэй менежментийн гэрээ байгуулж, дүгнэнэ.

3.5.3.Энэ дүрмийн 3.5.2-т заасан гэрээний дагуу охин, хараат компани, харьяа хуулийн этгээд компанид менежментийн төлбөр төлнө. Менежментийн төлбөрийн хувь хэмжээ нь борлуулалтын орлогын 2 (хоёр) хүртэл хувь байна.



3.5.4.Компани нь өөрийн хувь эзэмшлийг харгалзан охин, хараат компани, харьяа хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөлөгчийг томилох, төлөөлөгчийн баримтлах удирдамжийг мөрдүүлэх эрхтэй гэж заасан байна.

Гэвч бусад хураамжийг журамд зааснаар тухай бүр гэрээгээр зохицуулна гэсэн тул судлаачдын зүгээс тооцоолол хийгээгүй болно. Ирээдүйд бий болох нэг орлогын эх үүсвэр бол Худалдааны төвийн түрээсийн орлого юм.

“Налайхын Үйлдвэр Технологийн Парк” ХК-ийн төвлөрүүлэх орлого (гишүүнчлэл ба менежментийн хураамж) нь 2031-2035 онд шинээр орох 40 үйлдвэрийн хувьд тооцоход жилд 400,0-839,5 сая төгрөг болохоор байна.

Хүснэгт 2. 12. “Налайхын УТП” ХК-ийн жилд төвлөрүүлэх орлогын төсөөлөл 2031-2035 онд, сая төгрөгөөр, дараагийн 40 үйлдвэрээр

№	Паркийн нэгжийн нэр	Гишүүнчлэлийн хураамж (ПХ-1)	Менежмент-ийн хураамж (ПХ-2)	Байгаль орчин, нөхөн сэргээх ажлын хураамж (ПХ-3)	Эрчим хүч, дэд бүтэц, авто зам ашиглалтын хураамж (ПХ-4)	Бусад хураамж (ПХ-5)	Паркийн хураамжийн нийт дүн (ПХ)
1	Керамик эдлэлийн үйлдвэр	10.00	13.80	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	23.80
2	Угсармал барилгын бетон хийц эдлэлийн үйлдвэр	10.00	14.40	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	24.40
3	Байгалийн чулуун хавтангийн үйлдвэр	10.00	12.30	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	22.30
4	Сэндвич хавтан, төмөр хийц, эдлэлийн үйлдвэр	10.00	12.90	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	22.90
5	Инженерийн байгууламжийн төмөр бетон эдлэлийн үйлдвэр	10.00	11.70	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	21.70
6	Магнийн хавтангийн үйлдвэр	10.00	12.30	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	22.30
7	Хонины ноосон дулаалгын материалын үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
8	Дээврийн материалын үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
9	Полистрол, XPS дулаалгын материалын үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
10	Хөнгөн төмөр каркасны үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
11	Хэв хашмалын үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95



№	Паркийн нэгжийн нэр	Гишүүнчлэл ийн хураамж (ПХ-1)	Менежмент -ийн хураамж (ПХ-2)	Байгаль орчин, нөхөн сэргээх ажлын хураамж (ПХ-3)	Эрчим хүч, дэд бүтэц, авто зам ашиглалтын хураамж (ПХ-4)	Бусад хураамж (ПХ-5)	Паркийн хураамжийн нийт дүн (ПХ)
12	Экопанель SIP хавтангийн үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
13	Нийлэг туйвангийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
14	Өнгөлгөөний тоосгоны үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
15	Полистрол бетон гулдмай, хийц эдлэлийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
16	Усан суурьт будгийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
17	Хавтгай шилний үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
18	Ханын 3 үет EPS төрлийн хавтангийн үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
19	Цэвэр бохир усны полимер хоолойн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
20	Фасадны төрөл бүрийн цавуу, түрхлэг, эмульсийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
21	Хөнгөн дүүргэгчтэй бетон эдлэлийн хөдөлгөөнт үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
22	Ландшафт, архитектурын бетон эдлэлийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
23	Хиймэл чулуун хавтангийн үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
24	Хадаас шурупны үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
25	Барилгын ханын цасны үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
26	Электродны үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
27	Гипсэн хавтангийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
28	Ган туйвангийн бэлдцийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
29	WPC хавтангийн үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
30	Барилгын ган туйвангийн үйлдвэр	10.00	11.55	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	21.55
31	Хуванцар хаалга цонхны үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35



№	Паркийн нэгжийн нэр	Гишүүнчлэл ийн хураамж (ПХ-1)	Менежмент -ийн хураамж (ПХ-2)	Байгаль орчин, нөхөн сэргээх ажлын хураамж (ПХ-3)	Эрчим хүч, дэд бүтэц, авто зам ашиглалтын хураамж (ПХ-4)	Бусад хураамж (ПХ-5)	Паркийн хураамжийн нийт дүн (ПХ)
32	Бетон зуурмагийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
33	Шалны материалын үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
34	Цахилгаан утас, кабелийн үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
35	Зам талбайн тохижилтын бетон эдлэл	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
36	Полиуретон дулаалгын материалын үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
37	Гидратын шохойн үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
38	Хөөсөн шилэн дулаалгын материалын үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
39	Металл хийц, эдлэлийн үйлдвэр	10.00	10.95	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.95
40	Бетоны нэмэлтийн үйлдвэр	10.00	10.35	мэдээлэлгүй	мэдээлэлгүй	0	20.35
	Нийт дүн	400.00	439.50			0	839.50

Тайлбар: Байгаль орчин сэргээх ажлын хураамж, дэд бүтцийн ашиглалтын хураамж нь Паркийн орлого биш бөгөөд дамжих төлбөр юм.

Хүснэгт 2. 13. Налайх УТП-ийн Худалдааны төвөөс жилд төвлөрүүлэх орлогын төсөөлөл 2031-2035 онд

№	Барилгын нэр, зориулалт	Хүчин чадал	Түрээсийн нэгж үнэ сард / төг /	Сарын орлого /мян төг/	Жилийн орлого /мян төг/
1	Бөөний худалдааны төв	800 лангуу	200,000	160,000	900,000
2	Жижиглэн худалдааны төв	150 лангуу	1,000,000	150,000	750,000
3	Үйлчилгээний төв	800 ААН	100,000	800,000	4,000,000
4	Агуулах	4400 м2	10,000	44,000	968,000
5	Авто зогсоол	1700 машины зогсоол	3,000	66,000	330,000
6	Төмөр замын ачиж буулгах талбай	8 га	50,000,000	50,000	600,000
7	Нийт орлогын дүн				7,548,000

Хүснэгт 2. 14. Налайх УТП-ийн Худалдааны төвийн хүчин чадал

№	Барилгын нэр, зориулалт	Газрын хэмжээ	Хүчин чадал	Тайлбар
1	Бөөний худалдааны төв	4.00	800 лангуу	40м2 бүхий 800 лангуу байрлуулах
2	Жижиглэн худалдааны төв	2.00	150 лангуу	Жижиг, дунд үйлдвэрээс гаргасан бүтээгдэхүүн борлуулах 100м2 бүхий 150 лангуу байх
3	Үйлчилгээний төв	2.00	800 ААН	2га талбайд 2 давхар үйлчилгээний төв барьж 800 ААН



4	Ногоон байгууламж	4.60		4.6га талбайг хамарсан ногоон байгууламжийг барих
5	Агуулах	11.00		Агуулахын барилга ба гадна тохижилт 11 га талбайг хамрах
6	Авто зогсоол	9.40	1700 машины зогсоол	Худалдааны үйлчилгээний 1600 зогсоол нь 7.4 га Тээвэр логиستيкийн 100 зогсоол 2га газрыг хамрах
7	Төмөр замын ачиж буулгах талбай	8.00		8га талбайг хамарсан төмөр замын ачиж буулгах талбай барих
8	Авто зам	14.00		Авто зам нь 14 га талбайг хамрах

Эх үүсвэр: Налайх УТП ХК-ийн дотоод мэдээлэл

2.3.4. Паркийн үйл ажиллагааны зардлын төсөв, ирээдүйн төсөөлөл

“Налайхын УТП” ХК нь одоо нийт 18 ажилтантай, жилийн 800.0 сая төгрөгийн зардлын төсөвтэй ажиллаж байна. Судлаачид нь 2025-2030 оны хооронд одоогийн байгаа 18 хүн үүнээс 16 хүн хянах үнэлгээ хийхээр, 2035 оноос 28 хүний орон тоотой ажиллах боломжтой гэж үзсэн.

Хүснэгт 2. 15. “Налайхын УТП” ХК зардлын төсөв 2026-2030 онд (мян төг)

№	Зардлын төрөл	Нийт Зардлын төсөв	Паркийн 120 га талбайн менежмент	Паркийн 130 га талбайн менежмент	Паркийн 60 га талбай, Худалдааны төвийн менежмент	Багахангайн 50 га газрын менежмент
1	Цалин, НДШ-ийн зардал		10 ажилтан	6 ажилтан		
2	Цалин	480,000	300,000	180,000	0	0
3	Нэмэгдэл	140000	80000	60000	0	0
4	НДШ	57,600	36,000	21,600	0	0
5	Хэсгийн дүн	677,600	416,000	261,600	0	0
6	Сургалт, лабораторийн зардал	30,000	16,250	13750	-	-
7	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал					
8	Гэрэл, цахилгааны зардал	2,093	1,628	465	0	0
9	Түлш, халаалтын зардал	2,934	2,282	652	0	0
10	Цэвэр, бохир усны зардал	203	158	45	0	0
11	Хэсгийн дүн	5,229	4,067	1,162	0	0
12	Шууд бус зардал					
13	Захиргааны бичиг хэргийн зардал	864	672	192	0	0
14	Тээвэр, шатахууны зардал	9,500	5,500	4,000	0	0
15	Шуудан, холбооны зардал	270	210	60	0	0
16	Хог хаягдал зайлуулах	16,640	0	0	0	0
17	Цэцэрлэгжүүлэлт	5500,00	0	0	0	0
18	Гадаад албан томилолтын зардал	72,000	36,000	36,000	0	0
19	Харуул хамгаалалтын зардал	300,000	0	0	0	0
20	Аудит, баталгаажуулалт,	3,000	3,000	0	0	0



№	Зардлын төрөл	Нийт Зардлын төсөв	Паркийн 120 га талбайн менежмент	Паркийн 130 га талбайн менежмент	Паркийн 60 га талбай, Худалдааны төвийн менежмент	Багахангайн 50 га газрын менежмент
	зэрэглэл тогтоох үйлчилгээний хураамж					
21	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500	400	100	0	0
22	Тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношилгооны зардал	1,800	1,500	300	0	0
23	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	0	0	0	0	0
24	Бусад төлбөр, хураамж	0	0	0	0	0
25	Хэсгийн дүн	945,330	71,667	56,726	0	0
26	Нийт зардлын дүн	1,622,633	487,667	318,326	0	0

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол, "Налайх УТП" ХК-ийн тайлан баланс 2019-2024 он

2031-2035 онд паркийн удирдлагын компанийн цалин, НДШ-ийн зардал 2,685.4 сая төгрөг, сургалт лабораторийн зардал 45 сая төгрөг, байрны ашиглалтын зардал 18.6 сая төгрөг, бусад зардал 1,886.49 сая төгрөг төсөвлөж нийт зардлын дүн 4,635.48 сая төгрөг байхаар тооцов.

Хүснэгт 2. 16. "Налайхын УТП" ХК зардлын төсөв 2031-2035 онд (мян төг)

№	Зардлын төрөл	Нийт Зардлын төсөв	Паркийн 120 га талбайн менежмент	Паркийн 130 га талбайн менежмент	Паркийн 60 га талбай, Худалдааны төвийн менежмент	Багахангайн 50 га газрын менежмент
1	Цалин, НДШ-ийн зардал		10 ажилтан	6 ажилтан	5 ажилтан	5 ажилтан
2	Цалин	2,184,000	840,000	504,000	420,000	420,000
3	Нэмэгдэл	182,000	70,000	42,000	35,000	35,000
4	НДШ	319,410	122,850	73,710	61,425	61,425
5	Хэсгийн дүн	2,685,410	1,032,850	619,710	516,425	516,425
6	Сургалт, лабораторийн зардал	45,000	19,688	5,625	5,625	8,438
7	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал					
8	Гэрэл, цахилгааны зардал	7,440	3,255	930	930	1,395
9	Түлш, халаалтын зардал	10,432	4,564	1,304	1,304	1,956
10	Цэвэр, бохир усны зардал	720	315	90	90	135
11	Хэсгийн дүн	63,592	27,822	7,949	7,949	11,924
12	Шууд бус зардал					
13	Захиргааны бичиг хэргийн зардал	30,720	13,440	3,840	3,840	5,760
14	Тээвэр, шатахууны зардал	720,000	315,000	90,000	90,000	135,000
15	Шуудан, холбооны зардал	960	420	120	120	180
16	Хог хаягдал зайлуулах	16,400	39,000	13,000	13,000	26,000
17	Цэцэрлэгжүүлэлт	500,000	312,500	187,500	156,250	156,250
18	Гадаад албан томилолтын зардал	172,000	50,000	36,000	36,000	50,000
19	Харуул хамгаалалтын зардал	35,910	15,711	4,489	4,489	6,733



№	Зардлын төрөл	Нийт Зардлын төсөв	Паркийн 120 га талбайн менежмент	Паркийн 130 га талбайн менежмент	Паркийн 60 га талбай, Худалдааны төвийн менежмент	Багахангайн 50 га газрын менежмент
20	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох үйлчилгээний хураамж	71,820	31,421	8,978	8,978	13,466
21	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	56,000	20,000	8,000	8,000	16,000
22	Тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношилгооны зардал	1,800	800	200	200	400
23	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	6,000	3,000	600	600	1,200
24	Бусад төлбөр, хураамж	0	-	-	-	-
25	Хэсгийн дүн	1,886,485	801,292	352,727	321,477	410,989
26	Нийт зардлын дүн	4,635,487	1,861,964	980,386	845,851	939,338

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

2.3.5. Хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ

Менежментийн компанийн ашигт ажиллагаа

“Налайх Үйлдвэрлэл Технологийн Парк” ХК нь 2025 оноос менежментийн төлбөрийн орлого олж эхлэх ба паркийн нийт орлого нь 2026-2030 онд 14.73-20.17 тэрбум төгрөгт хүрч, үйл ажиллагааны зардал нь 10.88-15.36 тэрбум төгрөг болж, татварын дараах ашиг нь 3.46-4.33 тэрбум төгрөг буюу 1.01-1.27 сая ам.долларт хүрэхээр урьдчилсан төсөөлөл гарсан.

Хүснэгт 2. 17. Паркийн орлого зардлын төсөөлөл 2026-2030 онд(сая төгрөг)

№	Үзүүлэлт	2026	2027	2028	2029	2030
1	Борлуулалтын орлого	14,725.30	15,390.30	16,523.30	18,745.30	20,169.10
2	Гишүүнчлэлийн хураамж	150.00	-	-	-	-
3	Менежментийн хураамж	206.94	206.94	206.94	206.94	206.94
4	Байгаль орчин нөхөн сэргээх хураамж	225.32	225.32	225.32	225.32	225.32
5	Ашиглалтын хураамж	2,613.04	2,613.04	2,613.04	2,613.04	2,613.04
6	Бусад хураамж	-	-	-	-	-
7	Түрээсийн орлого	-	-	-	-	-
8	Үйлдвэрүүдийн орлого	11,530.00	12,345.00	13,478.00	15,700.00	17,123.80
9	Үйл ажиллагааны зардал	10,882.22	11,534.22	12,440.62	14,218.22	15,357.22
10	Цалин, НДШ	677.60	677.60	677.60	677.60	677.60
11	Сургалт, лабораторийн зардал	30.00	30.00	30.00	30.00	30.00
12	Ашиглалтын зардал	5.29	5.29	5.29	5.29	5.29
13	Бусад зардал	945.33	945.33	945.33	945.33	945.33
14	Үйлдвэрүүдийн зардал	9,224.00	9,876.00	10,782.40	12,560.00	13,699.00
15	Татварын өмнөх ашиг	3,843.08	3,856.08	4,082.68	4,527.08	4,811.88
16	Татварын зардал	384.31	385.61	408.27	452.71	481.19
17	Татварын дараах ашиг	3,458.77	3,470.47	3,674.41	4,074.37	4,330.69



Харин Паркийн нийт орлого нь 2031-2035 онд 71.1-78.61 тэрбум төгрөгт хүрч, үйл ажиллагааны зардал нь 48,23-54,55 тэрбум төгрөг болж, татварын дараах ашиг нь 17.16-18.04 тэрбум төгрөг буюу 5.02-5.28 сая ам.доллар болохоор урьдчилсан төсөөлөл гарсан.

Хүснэгт 2. 18. Паркийн орлого зардлын төсөөлөл 2031-2035 онд(сая төгрөг)


№	Үзүүлэлт	2031	2032	2033	2034	2035
1	Борлуулалтын орлого	71,107.34	72,707.34	73,807.34	75,907.34	78,607.34
2	Гишүүнчлэлийн хураамж	400.00	-	-	-	-
3	Менежментийн хураамж	439.5	439.5	439.5	439.5	439.5
4	Байгаль орчин нөхөн сэргээх хураамж	551.84	551.84	551.84	551.84	551.84
5	Ашиглалтын хураамж	6,968.00	6,968.00	6,968.00	6,968.00	6,968.00
6	Бусад хураамж	-	-	-	-	-
7	Түрээсийн орлого	7,548.00	7,548.00	7,548.00	7,548.00	7,548.00
8	Үйлдвэрүүдийн орлого	55,200.00	57,200.00	58,300.00	60,400.00	63,100.00
9	Үйл ажиллагааны зардал	48,228.48	49,828.48	50,708.48	52,388.48	54,548.48
10	Цалин, НДШ	2,685.40	2,685.40	2,685.40	2,685.40	2,685.40
11	Сургалт, лабораторийн зардал	45.00	45.00	45.00	45.00	45.00
12	Ашиглалтын зардал	18.59	18.59	18.59	18.59	18.59
13	Бусад зардал	1319.49	1319.49	1319.49	1319.49	1319.49
14	Үйлдвэрүүдийн зардал	44,160.00	45,760.00	46,640.00	48,320.00	50,480.00
15	Татварын өмнөх ашиг	22,878.86	22,878.86	23,098.86	23,518.86	24,058.86
16	Татварын зардал	5,719.72	5,719.72	5,774.72	5,879.72	6,014.72
17	Татварын дараах ашиг	17,159.15	17,159.15	17,324.15	17,639.15	18,044.15

Паркийн ашигт ажиллагаа, мөнгөн урсгалын шинжилгээ

Налайхын УТП-ийн дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2030 онд нийт 161.5 тэрбум төгрөг буюу 46.7 сая ам.доллар болохоор байна. Үүнээс Нийслэл болон улсын төсвөөр 2014-2024 онуудад 29.99 тэрбум төгрөг буюу 11.12 сая ам.доллар хөрөнгө оруулалт хийгдсэн.

Паркийн гарах мөнгөн урсгал нь 2014 оноос эхэлсэн, орох мөнгөн урсгал нь 2026 оноос эхлэхээр байна. Дискаунтын хүүг 18%-аар тооцоход 2032 оноос паркийн мөнгөний гүйлгээний тайлан нь нэмэх үлдэгдэлтэй гарч, паркийн цэвэр ашиг нь 17.16 тэрбум төгрөг буюу 5,02 сая ам.доллар болж, анхны хөрөнгө оруулалтаа 6,1 жилд нөхнө.

Зураг 2. 5. Паркийн хөрөнгө оруулалт, мөнгөн урсгалын төсөөлөл (чөлөөт мөнгөн урсгал, сая ам.дол)



Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол



2.4. Хөрөнгө оруулалтын боломжууд, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн санхүүжилтийн бүтэц сонгох

Шинжлэх Ухаан, Технологийн Сургуулийн судлаачдын хийсэн судалгаагаар барилгын материалын Налайх Үйлдвэрлэл Технологийн Парк төслийн дэд бүтцийг барьж байгуулахад хоёр дахь үе шат 3 жилийн хугацаанд 161,5 тэрбум төгрөг буюу 46,8 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Ийм их хэмжээний хөрөнгийг бүрдүүлэхэд нэг төрлийн хөрөнгийн эх үүсвэрт түшиглэх нь хүндрэлтэй. Иймээс, төслийг санхүүжүүлэхэд шаардлагатай байгаа хөрөнгийг олон тооны эх үүсвэрүүдээс багцлан бүрдүүлэх шаардлагатай болно.

Төслийн санхүүжилтийн хэлбэрийг хөрөнгийн эх үүсвэрүүдээр нь дараах байдлаар ангилан авч үзэх боломжтой. Үүнд:

1. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
2. Зээлийн эх үүсвэртэй санхүүжилт
3. Өөрийн хөрөнгийн эх үүсвэртэй санхүүжилт
4. Холимог буюу өөрийн болон зээлийн эх үүсвэртэй гэж ангилдаг.

1. Зээлийн эх үүсвэртэй санхүүжилтээр

- 1.1. Банкны зээлийн санхүүжилт: арилжааны банкны богино, урт хугацаат зээл, синдикатын зээл,
- 1.2. Бондын санхүүжилт: Засгийн Газрын баталгаатай бонд, Засгийн Газрын баталгаагүй бонд, Орон нутгийн бонд, Корпорацын бонд

2. Өөрийн эх үүсвэртэй санхүүжилтээр

- 2.1. Энгийн хувьцааны санхүүжилт
- 2.2. Давуу эрхтэй хувьцааны санхүүжилт

3. Холимог санхүүжилтээр

- 3.1. Толгой компанийн зээл
- 3.2. Төсөлд шинэ хөрөнгө оруулагч зээл олгох
- 3.3. Төслийн санхүүжилт
- 3.4. Толгой компани өөрийн нэрээр бонд гаргах
- 3.5. Төслийн компани өөрийн нэрээр бонд гаргах гэсэн байдаг.

Ингээд Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн санхүүжилтийн бүтцийг бий болгохдоо санхүүжилтийн өртөг зардлыг тооцох, төслийн бизнесийн амьдралын мөчлөг зэргээс хамааран, Төслийн санхүүжилтийн төрлүүд дараах хүснэгтээс сонгодог.



Хүснэгт 2. 19. Төслийн санхүүжилтийн төрлүүд

№	Санхүүжилтийн			Давуу тал	Сул тал
	Эх үүсвэр	Хэлбэр	Төрөл		
1	Зээлийн эх үүсвэр	Банкны зээлийн санхүүжилт	Арилжааны банкны богино хугацаат зээл	-Зээл олгох шийдвэр хурдан гарах -Эргэлтийн хөрөнгөд тохиромжтой -Барьцааны хөрөнгө бага шаардах эсвэл шаардахгүй	-Зээлийн хэмжээ нь бага -Хугацаа богино -Хүү өндөр
2			Арилжааны банкны урт хугацаат зээл	-Зээл олгох шийдвэр хурдан гарах -Бага дүнтэй тоног төхөөрөмж авах, барилга байгууламж барих санхүүжилт хийх боломжтой -Дахин санхүүжилт хийх боломжтой	-Зээлийн хэмжээ нь дунд -Хугацаа урт -Хүү нь харьцангуй бага -Барьцааны хөрөнгө ихээр шаардах -Зээл олгох шалгуур олон
3			Синдикатын зээл (хэд хэдэн банк хамтарсан)	-Зээлийн хэмжээ нь их -Зээлийн хугацаа урт -Хүү харьцангуй бага -Экспортлогчдод тохиромжтой -Дахин санхүүжилт хийх боломжтой	-Зээлдэгчид тавих шалгуур өндөр -Зээл олгох шийдвэр удаан гарах -Гадаад валютын ханшны эрсдэл их -Санхүүжилтийн өртөг өндөр -Төсөлд тавих шалгуур өндөр
4		Бондын санхүүжилт	Засгийн Газрын баталгаатай бонд	-Санхүүжилт олоход хялбар -Хүү харьцангуй бага -Төсөлд тавих шалгуур бага	-Гадаад валютын ханшны эрсдэл их -Санхүүжилтийн өртөг бага -Тухайн улс олон улсын үнэлгээний агентлагаар бондын зэрэглэл тогтоолгох
5			Засгийн Газрын баталгаагүй бонд	-Санхүүжилт олоход хялбар -Хүү харьцангуй бага -Төсөлд тавих шалгуур бага	-Гадаад валютын ханшны эрсдэл их -Санхүүжилтийн өртөг харьцангуй бага -Тухайн улс олон улсын үнэлгээний агентлагаар бондын зэрэглэл тогтоолгох
6			Орон нутгийн бонд	-Санхүүжилт олоход хялбар -Хүү харьцангуй бага -Төсөлд тавих шалгуур бага -Ханшны эрсдэлгүй	-Тухайн орон нутаг нь төсвийн ашигтай байхыг шаардах -Санхүүжилтийн өртөг харьцангуй бага
7			Корпорацын бонд	-Санхүүжилт олоход хялбар -Хүү харьцангуй бага -Төсөлд тавих шалгуур бага	-Тухайн орон нутаг нь төсвийн ашигтай байхыг шаардах -Санхүүжилтийн өртөг харьцангуй бага -Тухайн улсын бондын зэрэглэлээс илүү зэрэглэл компани авч чадахгүй



№	Санхүүжилтийн			Давуу тал	Сул тал
	Эх үүсвэр	Хэлбэр	Төрөл		
8	Өөрийн хөрөнгийн эх үүсвэр	Хувьцааны санхүүжилт	Энгийн хувьцааны санхүүжилт	-Санхүүжилт босгох хэмжээ нь их -Хугацаа урт -Санхүүжилт олоход харьцангуй хялбар -Хүүгийн зардал байхгүй -Төсөлд тавих шалгуур бага	-Шинэ ба төслийн компанид таарахгүй -Ашигтай ажилласан ба бодит орлоготой 2-3 жил байхыг шаарддаг. -Хөрөнгийн үнэлгээ хийх шаардлагатай. -Санхүүжилтийн өртөг өндөр -Олон нийтийн хараа хяналт их
9			Давуу эрхтэй хувьцааны санхүүжилт	-Санхүүжилт босгох хэмжээ нь дунд -Санхүүжилт олоход харьцангуй хялбар -Төсөлд тавих шалгуур бага	-Хүүгийн зардал үүснэ -Хүү төлөх хугацаа богино буюу дунд
10	Холимог эх үүсвэр	Зээл, өөрийн хөрөнгө хосолсон	Толгой компанийн санхүүжилт бүхий зээл	-Санхүүжилт олоход хялбар -Хүү харьцангуй бага -Төсөлд тавих шалгуур бага -Санхүүжилтийн өртөг хамгийн бага	-Төслөөс бий болсон мөнгөн урсгалыг толгой компани ашиггүй зарцуулах боломжтой -Жижиг хөрөнгө оруулагчид удирдлагад хяналт тавих боломж муу
11			Төсөлд шинэ хөрөнгө оруулагч зээл олгох	-Санхүүжилт олоход хялбар -Хүү харьцангуй бага -Хөрөнгө оруулагчид удирдлагад хяналт тавих боломж сайн -Дахин санхүүжилт хийх боломжтой -Шинэ төсөлд тохиромжтой	-Төсөлд тавих шалгуур өндөр -Хүүгийн зардал үүснэ -Засаглалтай холбоотой маргаан үүсдэг -Санхүүжилтийн өртөг өндөр
12			Төслийн санхүүжилт	-Дэд бүтэц, эрчим хүчний салбарт тохиромжтой -Санхүүжилт босгох хэмжээ нь их	-Гэрээний олон нарийн төвөгтэй хэлбэр ашигладаг -Төсөлд олон тал оролцдог -Санхүүжилтийн өртөг хамгийн өндөр
13	Холимог эх үүсвэр	Бонд, өөрийн хөрөнгө хосолсон	Толгой компани бонд гаргах	-Санхүүжилт олоход хялбар -Хугацаа урт -Хүү харьцангуй бага -Төслийн компанид тавих шалгуур бага -Санхүүжилтийн өртөг дунд	-Төслөөс бий болсон мөнгөн урсгалыг толгой компани ашиггүй зарцуулах боломжтой -Жижиг хөрөнгө оруулагчид удирдлагад хяналт тавих боломж муу
14			Төслийн компани бонд гаргах	-Санхүүжилт олоход хялбар -Хугацаа урт -Хүү харьцангуй бага -Санхүүжилтийн өртөг дунд	-Төслийн компани ашигтай ажиллах -Хүүгийн зардал үүснэ -Шинэ төсөлд тохиромжгүй -Толгой компани бондын зэрэглэл тогтоолгох



ЗГ-ын гадаад бонд, өрийн баталгааны санхүүжилт

Монгол улсын Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8,716.3 тэрбум төгрөг буюу 2,578.0 сая ам.доллартой тэнцэж байна.

2021 оны 07 дугаар сард "Сенчири-2027" төслийн хүрээнд 3.5%-ийн хүүтэй, 6 жилийн хугацаатай 500 сая ам.доллар, "Сенчири-2031" төслийн хүрээнд 10 жилийн хугацаатай 4.45%-ийн хүүтэй 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын гадаад бондыг амжилттай арилжаалсан байна.Түүнчлэн Сенчири-3 бондын хүүгийн түвшин дэх Монгол улсын Засгийн Газрын эрсдэлийн түвшин буюу "Spread" мөн түүхэндээ хамгийн бага буюу 2.3% болсон нь Засгийн Газрын өмнө гарган арилжаалж байсан гадаад бондуудын эрсдэлийн дундаж түвшин болох 5.5%-аас 2 дахин багассан үзүүлэлт юм.

Хүснэгт 2. 20. Монголын ЗГ, Хөгжлийн Банкнаас олон улсын зах зээлд гаргасан өрийн үнэт цааснууд

№	Үнэт цаасны нэр, төрөл, огноо	Үнэт цаасны гаргагч	Үнэт цаасны дүн, хугацаа	Санхүүжилтийн өртөг	Гадаадын санхүүгийн зөвлөх	Дотоодын санхүүгийн зөвлөх
1	ЧИНГИС-2022 бонд 2012.12.05	Монгол улсын Засгийн Газар	1,000 сая US\$, 10 жил	5.125% ЗГ-ын бонд		
2	ЧИНГИС-2018 бонд 2013.01.05	Монгол улсын Засгийн Газар	500 сая US\$, 5 жил	4.125% ЗГ-ын бонд		
3	САМУРАЙ бонд 2013.12	Хөгжлийн Банк	30 тэрбум JPY, 10 жил	1.52% Монгол Улсын Хөгжлийн Банкны бонд	Мизухо банк, Номура ба Дайва секьюритиз	Фронттиер Секьюритиз ХХК
4	МАЗААЛАЙ бонд 2016.03	Монгол улсын Засгийн Газар	500 сая US\$, 5 жил	10.875% ЗГ-ын бонд		
5	ХУРАЛДАЙ бонд 2017.03.	Монгол улсын Засгийн Газар	600 сая US\$, 3 жил	8.75% ЗГ-ын бонд		
6	СЕНЧИРИ-2027 бонд 2021.07.	Монгол улсын Засгийн Газар	500 сая US\$, 6 жил	3.5% ЗГ-ын бонд		
7	СЕНЧИРИ-2031 бонд 2021.07.	Монгол улсын Засгийн Газар	500 сая US\$, 10 жил	4.45% ЗГ-ын бонд		

Эх үүсвэр: Монгол улсын ЗГ-ын өрийн удирдлагын 2023-2025 оны стратеги, 2022 он, www.cbonds.com

Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 265 дугаар тогтоолын дагуу "Сэлбэ" дэд төвийн бүтээн байгуулалтыг Нийслэлийн гадаад үнэт цаас гарган санхүүжүүлэхэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Энэхүү үнэт 500 сая ам.долларын хэмжээтэй, 2.75 жилийн хугацаатай, 7.75%-ийн хүүтэй бөгөөд 2027 оны 08 дугаар сард төлөгдөх хуваарьтай байна.



Хүснэгт 2. 21. Монголын ЗГ-ын олон улсад гаргасан баталгаа

№	Үнэт цаасны нэр, төрөл, огноо	Үнэт цаасны баталгаа гаргагч	Үнэт цаасны дүн, хугацаа	Санхүүжилтийн өртөг	Зээлдүүлэгч	Санхүүгийн зөвлөх
1	МИАТ ТӨХК 2013.	Монгол улсын Засгийн Газар	39 сая US\$, 7 жил	9.38%	АНУ-ын PEFCO	
2	Монгол Улсын Хөгжлийн Банк 2013.12	Монгол улсын Засгийн Газар	30 тэрбум JPY, 10 жил	1.52% Монгол Улсын Хөгжлийн Банкны бонд	Япон улсын хөрөнгө оруулагчид	Мизухо банк, Номура ба Дайва секьюритиз
3	Монгол Улсын Хөгжлийн Банк 2014	Монгол улсын Засгийн Газар	162 сая US\$, 8 жил	6%	БНХАУ-ын Хөгжлийн Банк	
4	Эрдэнэс Монгол ХК 2016.	Монгол улсын Засгийн Газар	42 сая US\$, 15 жил	7% Техникийн туслалцааны зээл	Азийн Хөгжлийн Банк	
5	УЛААНБААТАР СИТИ бонд 2024.08.15	Монгол улсын Засгийн Газар	500 сая US\$, 3 жил	7,75% Муж хотын бонд		Дойче банк, Фронтинер стратегиз ХХК

Эх үүсвэр: Монгол улсын ЗГ-ын өрийн удирдлагын 2023-2025 оны стратеги, 2022 он, www.cbonds.com

Монгол улсын ЗГ-ын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегид заасны дагуу Засгийн Газар нь дунд хугацаанд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж заасан:

- ✓ Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;
- ✓ Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах;
- ✓ Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авахгүй байх.

Корпорацийн буюу компанийн бондын санхүүжилт

Монгол улсын уул уурхайн болон үл хөдлөх хөрөнгийн компаниуд нь Хонгконг, Сингапурын болон Монголын Хөрөнгийн Бирж дээр 100-300 сая US\$-ийн бондыг ихэвчлэн 3 жилийн хугацаатай 5,8-12,5%-ийн купоны хүүтэй амжилттай арилжаалсан байна. Хүснэгт -аас харвал Эрдэнэс Тавантолгой ТӨХК нь 100 сая US\$-ийн бондыг 3 жилийн хугацаатайгаар Хонгконг, Сингапурын Биржүүдээс бага купонтой дотоодын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлснийг харж болно.



Хүснэгт 2. 22. Монголын компаниудаас олон улсын зах зээлд гаргасан өрийн үнэт цааснууд

№	Үнэт цаасны нэр, төрөл, огноо	Үнэт цаасны гаргагч	Үнэт цаасны дүн, хугацаа	Санхүүжилтийн өртөг, байршуулсан бирж	Гадаадын санхүүгийн зөвлөх	Дотоодын санхүүгийн зөвлөх
1	ӨҮЛЭН бонд, 2019.02.14	Монголын Ипотекийн Корпорац Холдинг ХК	300 сая US\$, 3 жил	9,75% Корпорацын бонд, Сингапурын Хөрөнгийн Бирж	n/a	Ти Ди Би Секьюритиз ХХК
2	БӨРТЭ бонд, 2021.02.15	Монголын Ипотекийн Корпорац Холдинг ХК	250 сая US\$, жил	8,85% Корпорацын бонд, Сингапурын Хөрөнгийн Бирж	n/a	Ти Ди Би Секьюритиз ХХК
3	ЭТТ бонд 2021.08.25	Эрдэнэс Тавантолгой ТӨХК	100 сая US\$, 2-3 жил	5.8-6.8% Корпорацын бонд, Монголын Хөрөнгийн Бирж	Би Ди Сек ХХК	Эм Ай Си Си ХХК
4	ММС бонд 2023.08.28	Mongolian Mining Corp буюу Энержи Ресурс ХХК	180 сая US\$, 3 жил	12,5% Корпорацын бонд, Хонконгын Хөрөнгийн Бирж	Дойче банк, Морган Стэнлэй банк	n/a
5	ХУЛАН бонд 2024.01.18	Монголын Ипотекийн Корпорац Холдинг ХК	225 сая US\$, 3 жил	11,5% Корпорацын бонд, Сингапурын Хөрөнгийн Бирж	Дойче банк, Кореа Инвестмент энд Секьюритиз	Ти Ди Би Секьюритиз ХХК

Эх үүсвэр: www.cbonds.com, www.mse.mn, www.fitchratings.com

Харин “Налайхын ҮТП” ХК нь гадаад болон дотоодын зах зээлд 7.75%-ийн хүүтэй америк долларын бонд гаргах бүрэн боломжтой юм.

Сүүлийн жилүүдэд биржийн бус (OTC market) зах зээл нь Монгол улсад хурдацтай хөгжиж байна. 2024 оны эхний хагасын байдлаар биржийн бус зах зээлд 714.7 тэрбум төгрөгийн дүнтэй 62 бонд бүртгүүлсэн нь Монголын хөрөнгийн бирж дээрх бондын татан төвлөрүүлсэн дүнгээс 1.3 дахин их үзүүлэлт юм.

Корпорацын буюу компани хувьцааны санхүүжилт

Монголд алт болон зэсийн төсөл хэрэгжүүлэгч гадаадын компаниуд нь төсөл санхүүжүүлэх нэмэлт хувьцаагаа Канад болон Австрали улсын хөрөнгийн зах зээлд гаргасан. Нэмэлт хувьцаагаа гаргахдаа Backdoor listing буюу одоо зах зээл дээр бүртгэлтэй байгаа уул уурхайн корпорацууд нь нэмэлт хувьцаа гаргах замаар Монгол дахь төслийг санхүүжүүлэх арга хэрэглэсэн. Гаргасан хувьцаануудын зах зээлийн үнэ дансны үнээс 2,1-3,4 дахин өссөн ба компаниудын үнэлгээ 9,09-194,01 сая СА\$-т Хүснэгт.хүрсэн байна.

Харин барилгын материалын Налайх ҮТП-ийн төслийн хүрээнд байгуулах компаниудын одоогийн байдлаар үүсгэн байгуулагдаагүй, өмч хөрөнгө нь бүрдээгүй, ашигтай ажилласан бизнесийн түүх үүсээгүй, төслийн судалгааны шатанд яваа тул хувьцааны санхүүжилт хийх боломжгүй юм.



Хүснэгт 2. 23. Олон улсын зах зээлд гаргасан Монголд зэсийн төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьцаанууд

№	Үнэт цаасны нэр, бүртгэл -тэй бирж	Үнэт цаасны гаргагч, төслийн нэр	Хувьцааны дансны үнэ	IPO хийх үеийн үнэ	Хувьцааны зах зээлийн үнэ	Компанийн нийт үнэлгээ 2024.12.20 /сая CA\$/	Нийт гаргасан энгийн хувьцааны тоо /ш/
1	ERD :TSX	Эрдэнэ Ресурс Девелопмент, Баян хөндий алт зэсийн төсөл	CA\$ 0.16 2018.06.14	CA\$ 0.26 2018.06.14	CA\$ 0.55 2024.12.20	194,01	352,740,000
2	KCC:ASX	Кинкорра Куппер, Хүрэл үнэг зэсийн төсөл	AU\$ 0.07 2018.03.13	AU\$ 0.035 2018.03.13	AU\$ 0.035 2024.12.20	9,09	259,750,000
3	XAM:TSX	Занаду Майнз, Хармагтай зэс алтны төсөл	CA\$ 0.03 2020.05.20		CA\$ 0,045 2024.12.20	74,2	1,730,000,000
4	AZ9:ASX	Азиа Батерей Металлс, Ямбат зэс никелийн төсөл	AU\$ 0.026 2023.12.25	AU\$ 0.026 2023.12.25	AU\$ 0.056 2024.12.25	39,9	588,000,000

Эх үүсвэр: www.tsx.com, www.investing.com

Монголын Хөрөнгийн Биржид хувьцаа гаргах шалгуур, зардлууд

Хүснэгт 2. 24. Компанид тавих ерөнхий шаардлага

№	Үзүүлэлтүүд	Компанид тавих шалгуур
1	Үйл ажиллагаа явуулсан	3-аас доошгүй жил
2	Санхүүгийн тайлан	3-аас доошгүй жил СТОУС
3	Санхүүгийн шалгуур	Борлуулалтын орлого, цэвэр ашиг, зах зээлийн үнэлгээ
4	Засаглалын шалгуур	- Удирдлагын баг нь тогтвортой ажилласан байх; - Гол хувьцаа эзэмшигчид нь өөрчлөгдөөгүй байх;
5	Компанийн засаглалын кодекс	Засаглалын кодексыг дагаж мөрддөг байх
6	Олон нийтэд эзэмшүүлэх хувь	10%-25%

Эх үүсвэр: www.mse.mn, www.ubx.mn

Хүснэгт 2. 25. МХБ-ийн бүртгэлийн шалгуур

№	Үзүүлэлтүүд	Компаниуд тавих шалгуур, биржийн самбарын ангилал		
		I Ангилал	II Ангилал	III Ангилал
1	Үйл ажиллагаа явуулсан жил	3-аас доошгүй	2-оос доошгүй	-
2	Санхүүгийн тайлан (СТОУС)	3 жил	2 жил	-
3	Сүүлийн жилийн борлуулалтын орлого	5 тэрбум төгрөгөөс дээш	-	-
4	Сүүлийн жилийн ашгийн хэмжээ	1 тэрбум төгрөгөөс дээш	100 сая төгрөгөөс доошгүй	-
5	Ажлын капитал	-	Бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд хангалттай байх	-
6	Компанийн засаглалын зарчмыг дагаж мөрдөх	Мөрдөх	Мөрддөггүй бол тайлбарлах	Мөрддөггүй бол тайлбарлах



7	Удирдлагын багийн туршлага, түүний болон хяналтын багц эзэмшигчид	Сүүлийн 2 жилийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3-т, сүүлийн 1 жилд хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх	-	-
8	Зах зээлийн үнэлгээ	10 тэрбум төгрөгөөс дээш	1 тэрбум төгрөгөөс дээш	Биржээс тухай бүр
9	Олон нийтэд эзэмшүүлэх хувь	25%-иас доошгүй	25%-иас доошгүй	-
10	Хувьцаа эзэмшигчдийн тоо	100-аас доошгүй	50-аас доошгүй	-
11	Үнэт цаас нь арилжих боломжтой байх	Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх		

Эх үүсвэр: www.mse.mn, www.ubx.mn


Хүснэгт 2. 26. Компаниас дотоодын биржид гарахад бусад зардлууд

№	Үйлчилгээний төрөл	Монголын Хөрөнгийн Бирж	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж
1	Биржийн үйлчилгээ		
2	Өргөдөл хүлээн авах	2,000,000	1,500,000
3	Бүртгэлийн хураамж	5,000,000-500,000,000	5,000,000-250,000,000
4	Жилийн хураамж	500,000-50,000,000	500,000-30,000,000
5	Санхүүгийн зохицуулах хороо		
6	Зохицуулалтын үйлчилгээ	500,000	500,000
7	Тэмдэгтийн хураамж	100,000	100,000
8	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв		
9	ISIN дугаар авах	1,500,000	1,500,000
10	Үнэт цаас хадгалах жилийн хөлс	100,000-400,000	100,000-400,000
11	Бусад оролцогч талуудын үйлчилгээ		
12	Андеррайтер	Тийм	Тийм
13	Аудит	Тийм	Тийм
14	Хууль	Тийм	Шаардлагатай тохиолдолд
15	Үнэлгээ	Тийм	Шаардлагатай тохиолдолд

Эх үүсвэр: www.mse.mn, www.ubx.mn



Хүснэгт 2. 27. IPO үйл ажиллагааны төлөвлөгөө



Эх үүсвэр: www.mse.mn , www.ubx.mn

Компани нь МХБ болон Улаанбаатар Үнэт Цаасны Биржид хувьцаагаа арилжаалж, хөрөнгө татан төвлөрүүлэхэд багадаа 17-18 долоо хоногийн хугацаа зарцуулахаар байна.

Компанийн амьдралын мөчлөгт тохируулан санхүүжилтийн төрөл сонгох

Аливаа компани нь бизнесийн амьдралын мөчлөгийн хувьд эхлэл, өсөлт, тэсрэлт, тогтворжих, уналт гэсэн 5 үе шатыг дамжих ба мөчлөг бүрд тохирсон санхүүжилтийн төрлийг сонгох ёстой болно.

Зураг 2. 6. Бизнесийн амьдралын мөчлөг



Эх үүсвэр: АНУ-ын Корпорацийн Санхүүгийн Институт байгууллага, www.cfi.org



Налайх ҮТП-ийн төслийн хүрээнд байгуулах компаниудын одоогийн байдлаар үүсгэн байгуулагдаагүй, өмч хөрөнгө нь бүрдээгүй, ашигтай ажилласан бизнесийн түүх үүсээгүй, төслийн судалгааны шатанд яваа тул бизнесийн мөчлөгийн эхлэлийн үе шатанд хамаарах буюу төрийн дэмжлэг оролцоо их, хөнгөлөлттэй зээл, татаас олгох шаардлагатай төслүүд юм.

Зураг 2. 7. Экспортын орлогыг нэмэгдүүлэх санхүүжилтийн схем



Эх үүсвэр: АНУ-ын Корпорацийн Санхүүгийн Институт байгууллага, www.cfi.org

Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Парк (НҮТП)-ийн хөгжлийн төлөвлөгөө нь хөрөнгө оруулалт татах тодорхой боломж, механизмыг агуулсан баримт бичиг юм. Тус төлөвлөгөөнд тулгуурлан дараах хөрөнгө оруулалт татах стратеги болон дунд хугацааны үйл ажиллагаа, төслүүдийн төлөвлөлтийг боловсрууллаа.

I. Хөрөнгө оруулалтын боломжит хувилбарууд

1. Дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрүүд

- ✓ Хамтарсан үйлдвэр байгуулалт: Үндэсний томоохон ААН-үүдтэй кластер хэлбэрээр хамтарч хөрөнгө оруулах.
- ✓ Концесс болон түрээсийн хэлбэрээр дэд бүтцэд хөрөнгө оруулах.
- ✓ Үндэсний хөрөнгө оруулалтын форумууд зохион байгуулж олон нийтийн санхүүжилт татах.
- ✓ “Smart Nalaikh” дэд төсөл, венчур сан, кластерын сангуудыг дотоод зах зээлд нэвтрүүлэх.

2. Гадаадын хөрөнгө оруулалтын хувилбарууд

- ✓ Технологи, инновацын чиглэлээр R&D хамтын төслүүд хэрэгжүүлэх.
- ✓ Гадаадын технологийн парк, лаборатори, венчур сангуудтай хамтран кластер загварын үйлдвэр хөгжүүлэх.



- ✓ Гадаад хөрөнгө оруулалтын чуулга уулзалт, форум зохион байгуулж, шууд хөрөнгө оруулалт татах.
- ✓ Гадаадын бирж, финтек платформуудад хөрөнгө оруулалтын кейсүүд танилцуулах.

II. Хөрөнгө оруулалтыг татахын тулд 2025–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төслүүд

№	Үйл ажиллагаа / Төсөл	Тайлбар	Зорилтот хөрөнгө оруулагч
1	НҮТП Investor Week олон улсын хөрөнгө оруулалтын форум	Гадаадын хөрөнгө оруулагчидтай шууд холбогдох форум зохион байгуулах	Гадаад хөрөнгө оруулагчид (Япон, БНСУ, ХБНГУ, Сингапур)
2	“Үндэсний хөрөнгө оруулалтын түншлэл” хөтөлбөр	Тэргүүлэх үндэсний үйлдвэрүүдийг хөрөнгө оруулагчаар оролцуулах механизм	Үндэсний томоохон ААН-үүд
3	Паркийн хоёр дахь үе шатны дэд бүтцийн хөрөнгө оруулалт	Цахилгаан, ус, зам, холбооны шугамд дэд хөрөнгө оруулалт татах	Хөрөнгө оруулагч барилгын компаниуд, дэд бүтцийн инженерүүд
4	Smart Industrial Zone – дижитал үйлдвэрлэл, IoT төв байгуулах	Үйлдвэрлэл 4.0 суурьтай үйлдвэрүүдийг татах зорилготой кластер	Технологийн компаниуд, AI, IoT систем хөгжүүлэгчид
5	Инновацын R&D төв байгуулах хамтын төслүүд	Гадаад лаборатори, судалгааны байгууллагатай хамтран R&D төсөл хэрэгжүүлэх	Гадаадын их дээд сургууль, шинжлэх ухааны төвүүд
6	НҮТП-ийн хөрөнгө оруулалтын кейсийг олон улсын биржид танилцуулах	Fintech, startup биржүүдэд танилцуулан хөрөнгө татах	Онлайн хөрөнгө оруулагчид, венчур сангууд
7	“Үндэсний үйлдвэрлэл – Налайхад” хөрөнгө оруулалтын чуулга уулзалт	Хувийн хэвшлийн анхаарлыг нэмэгдүүлэх дотоодын арга хэмжээ	Дотоодын хөрөнгө оруулагчид, барилгын салбар
8	Үйлдвэрийн дэд бүтцийн концессын загвар төсөл хэрэгжүүлэх	Усны шугам, цахилгаан хангамжийг концессын дагуу шийдэх	Төр-хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын түншлэл (PPP)
9	“Олон улсын түншлэл – Үйлдвэрлэлийн кластер” төсөл	Гадаадын технологитой хамтарсан үйлдвэрийг байгуулах	Үйлдвэрлэлийн чиглэлийн гадаад компаниуд
10	“НҮТП Investor Guide” англи хэл дээр гаргах	Хөрөнгө оруулалтын сурталчилгааны нэгдсэн баримт бичиг	Бүх төрлийн хөрөнгө оруулагчдад

III. Үр нөлөө, хүлээгдэж буй ашиг

- ✓ Хөрөнгө оруулалтын хэмжээ 5–10 жилийн дотор 10 дахин өсөх
- ✓ Гадаадын технологи, инновацын шилжилтийг хурдасгах
- ✓ Үйлдвэрлэл болон үйлчилгээний экосистем эрчимтэй төлөвших
- ✓ Дотоодын зах зээл болон экспортын гаралт өсөх
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдэх, хүний нөөц чадавхжих



2.5. НҮТП-ийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Налайхын ҮТП, паркт нэгдэх үйлдвэрүүдийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд учирч болзошгүй дараах эрсдэл байна гэж үзлээ. Эрсдэлийн нөлөөллийг ... дэд бүлгийн эрсдэлийн шинжилгээ, үнэлгээний судалгааны үр дүнд үндэслэн боловсруулав.

Налайхын ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эрсдэлийн шинжилгээний 3 болон түүнээс дээш үзүүлэлтэй эрсдэлийг анхаарч ажиллах дараах чиглэл байна. 1-2 онооны эрсдэл нь байгууллагад тийм ч өндөр аюул занал учруулахгүй бөгөөд үйл ажиллагааны явцад шийдвэрлэж болно. Налайхын ҮТП болон түүний нэгж үйлдвэрүүдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц дараах эрсдэлүүд байна. Үүнд:

Санхүүгийн эрсдэл: ҮТП, түүнд нэгдэх үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт, үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт, санхүүгийн хэвийн бус нөхцөлөөс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох дараах эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй.

- Хөрөнгө оруулалтын дутагдал, санхүүжилт тасралтаас үүсэх эрсдэл
- Санхүү, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх эрсдэл
- Зээлийн хүүгийн өсөлтийн эрсдэл
- Дэд бүтэц болон ус, дулаан цахилгаан гэх мэт нийлүүлэгчдийн үнийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл: ҮТП, түүнд нэгдэх үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт, үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хэвийн бус нөхцөл үүсгэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох дараах эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй.

- Тоног төхөөрөмж, технологийн эвдрэл, түүний эд ангийн олдцын дутагдлаас үүсэх эрсдэл
- Тоног төхөөрөмжийн эвдрэл, эд ангийн чанар муу байгаагаас үүсэх эрсдэл
- Үйлдвэрлэлийн процессын төлөвлөлт үйл ажиллагааны явцад зөрчигдөх эрсдэл
- Үйлдвэрийн шат дамжлага, тоног төхөөрөмжүүдийн зөрүүтэй байдлаас үүсэх эрсдэл
- Ижил төстэй үйлдвэрүүдийн нөөцийн төлөөх өрсөлдөөнөөс үүсэх эрсдэл

Зах зээлийн эрсдэл: ҮТП, түүнд нэгдэх үйлдвэрүүдэд гадаад, дотоод зах зээл, өрсөлдөөн, улс төр, геополитик зэрэг нөхцөлүүдээс ҮТП-ийн бүтээн байгуулалт, үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хэвийн бус нөхцөл үүсгэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох дараах эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй.

- Эцсийн бүтээгдэхүүний эрэлт, үнийн бууралтаас үүсэх эрсдэл
- Эцсийн бүтээгдэхүүний эрэлтийн тодорхойгүй байдлаас үүсэх эрсдэл
- Хэрэглэгчид бүтээгдэхүүний чанараас шалтгаалж, худалдан авагч буурах эрсдэл

Байгаль орчны эрсдэл: ҮТП, түүнд нэгдэх үйлдвэрүүдэд байгаль орчны нөхцөл, түүний гэнэтийн үзэгдэл зэргээс ҮТП-ийн бүтээн байгуулалт, үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд



хэвийн бус нөхцөл үүсгэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох дараах эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй.

- Шугам хоолойн осол гэмтлээс үүсэх бохир ус алдагдах эрсдэл
- Үйлдвэрээс аюултай, хортой хатуу болон шингэн материал алдагдах эрсдэл

Хууль эрх зүйн эрсдэл: ҮТП, түүнд нэгдэх үйлдвэрүүдэд хууль эрх зүй, улс төр түүний бодлого шийдвэр зэргээс хамаарч ҮТП-ийн бүтээн байгуулалт, үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд хэвийн бус нөхцөл үүсгэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох дараах эрсдэлүүдийг үүсгэж болзошгүй.

- Татвар, хөнгөлөлтийн өөрчлөлттэй холбоотой үүсэх эрсдэл

Нийгмийн эрсдэл: Бүс нутгийн ажиллах хүчний тооны хязгаарлагдмал байдал, мэргэжилтэй ажиллах хүчний хомсдолоос үүсэх эрсдэл

- Бүс нутгийн ажиллах хүчний хүртээмж, мэргэжилтний дутагдлын эрсдэл



Хүснэгт 2. 28. Налайхын ҮТП, паркт нэгдэх үйлдвэрүүдийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний чиглэл, сөрөг хариу арга хэмжээ

№	Үүсэж болзошгүй эрсдэл	Хамаарагдах нэгж	Сөрөг хариу арга хэмжээ	Хамаарах хугацаа	Хугацаа
Санхүүгийн эрсдэл					
1	Хөрөнгө оруулалтын дутагдал, санхүүжилт тасралтаас үүсэх эрсдэл	ҮТП, Металл хийцийн үйлдвэрүүд	Олон талт хөрөнгө оруулагчдыг татах	Дунд	2025-2028
			Олон улсын санхүүгийн байгууллагууд болон хөнгөлөлттэй зээлийн сангуудаас хөрөнгө босгох.	Дунд	2025-2030
			Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хослуулах	Урт	2025-2040
2	Санхүү, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх эрсдэл	Хог, хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд	Эрсдэлийн үнэлгээ хийх, үйл ажиллагааны санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж байх, түүнд түшиглэсэн оновчлол бий болгох	Урт	2025-2040
			Тасралтгүй хяналт, санхүүгийн дутагдлыг урьдчилан тооцох	Урт	2025-2040
			Төсвийн сахилга бат ба зардлын хяналт	Урт	2025-2040
3	Зээлийн хүүгийн өсөлтийн эрсдэл	Хог, хаягдал дахин боловсруулах болон хавтангийн үйлдвэрүүд	Хөрөнгө оруулагчидтай хийх гэрээ хэлцлийг маш нарийн чанд боловсруулах	Дунд	2025-2030
			Урт хугацааны санхүүжилтийн гэрээ ашиглах	Урт	2025-2040
			Зээлийн гэрээ нарийн чанд мөрдөх, зээлийн хүү болон үндсэн төлбөрийг цаг тухайд нь хийж байх	Урт	2025-2040
			Олон талын санхүүгийн эх үүсвэртэй байх	Урт	2025-2040
4	Дэд бүтэц болон ус, дулаан цахилгаан гэх мэт нийлүүлэгчдийн үнийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэл	Хавтан, Металл хийц, Жижиг, дунд үйлдвэрийн бүс, Хог, хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд	Шинэ эх үүсвэрийг шийдлийг боловсруулах	Дунд	2025-2030
			Үнийн болон нийлүүлэлтийн хэмжээний урт хугацааны гэрээ байгуулах	Дунд	2025-2030
			Эрчим хүч, усны хэрэглээг бууруулах технологи нэвтрүүлэх, үйл ажиллагаанд хэрэгжүүлж байх	Урт	2025-2040
Үйл ажиллагааны эрсдэл					
1	Тоног төхөөрөмж, технологийн эвдрэл, түүний эд ангийн олдцын дутагдлаас үүсэх эрсдэл	Бетон хийцийн болон металл хийцийн үйлдвэрүүд	Эд ангийн орлуулах шийдэл судлах, дотоодын хангамжийг судлах	Дунд	2025-2030
			Тогтмол үзлэг шалгалт хийх, урьдчилан сэргийлэх засвар, тоног төхөөрөмжийн ашиглалтын зааврыг дагаж мөрдөх	Урт	2025-2040
			Найдвартай ханган нийлүүлэгчтэй хамтран ажиллах	Урт	2025-2040
2	Тоног төхөөрөмжийн эвдрэл, эд ангийн чанар муу байгаагаас үүсэх эрсдэл	Бетон хийцийн үйлдвэрүүд	Чанарын баталгаатай тоног төхөөрөмж худалдан авах	Дунд	2025-2028
			Засвар үйлчилгээний тоног төхөөрөмж, системийг шинэчлэх, ухаалаг систем нэвтрүүлэх	Дунд	2025-2030
			Чанарын аудит хийх, эд ангийн хангамжийг үнэлэх	Урт	2025-2040
3			Туршилт, сайжруулалт хийх, тохируулга хийх	Дунд	2025-2028



№	Үүсэж болзошгүй эрсдэл	Хамаарагдах нэгж	Сөрөг хариу арга хэмжээ	Хамаарах хугацаа	Хугацаа
	Үйлдвэрлэлийн процессын төлөвлөлт үйл ажиллагааны явцад зөрчигдөх эрсдэл	Хог, хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд	Үйлдвэрлэлийн хүчин чадал, нөөц, хүний нөөцөд тохирсон төлөвлөгөө гаргах, мөрдөх	Урт	2025-2040
4	Үйлдвэрийн шат дамжлага, тоног төхөөрөмжүүдийн зөрүүтэй байдлаас үүсэх эрсдэл		Нэг нийлүүлэгчтэй, цогц үйлдвэрийн систем авахад анхаарах	Дунд	2025-2030
			Олон нийлүүлэгчээс тоног төхөөрөмж авах бол тохируулгыг маш сайн хийж гүйцэтгэх	Дунд	2025-2028
5	Ижил төстэй үйлдвэрүүдийн нөөцийн төлөөх өрсөлдөөнөөс үүсэх эрсдэл		Туршилт, сайжруулалт хийх, тохируулга хийх	Дунд	2025-2028
Зах зээлийн эрсдэл					
1	Эцсийн бүтээгдэхүүний эрэлт, үнийн бууралтаас үүсэх эрсдэл	Металл хийц, Жижиг, дунд үйлдвэрийн бүс	Эрэлт, нийлүүлэлтийн хандлагыг судлах, шинэ боломжит зах зээлийг эрэлхийлэх	Дунд	2025-2028
			Үнийн уян хатан стратеги хэрэгжүүлэх	Урт	2025-2040
			Үйлдвэрлэлийн процессыг оновчтой болгож, өртгийг багасгах замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.	Урт	2025-2040
2	Эцсийн бүтээгдэхүүний эрэлтийн тодорхойгүй байдлаас үүсэх эрсдэл	Хавтангийн үйлдвэрүүд	Эрэлт, нийлүүлэлтийн трендийг хянах	Дунд	2025-2028
			Эцсийн хэрэглэгчдийн төсөөлөл, таамаглал, худалдан авалтын хэв маягийг судлах	Дунд	2025-2028
			Үйлдвэрлэлийн хүчин чадал зохицуулах, уян хатан үйлдвэрлэлийн систем боловсруулах	Дунд	2025-2030
			Нийлүүлэлтийн сүлжээ өргөжүүлэх	Урт	2025-2040
3	Хэрэглэгчид бүтээгдэхүүний чанараас шалтгаалж, худалдан авагч буурах эрсдэл		Үйлдвэрлэлд шинэ технологи ашиглах, нэвтрүүлэх	Дунд	2025-2028
			Бүтээгдэхүүнийг сертификатжуулах	Дунд	2025-2028
			Бүтээгдэхүүний чанарыг байнга сайжруулах	Урт	2025-2040
			Чанарын хяналт тогтмолжуулах	Урт	2025-2040
Байгаль орчны эрсдэл					
1	Шугам хоолойн осол гэмтлээс үүсэх бохир ус алдагдах эрсдэл	Металл хийц болон Хог, хаягдал дахин	Зохих стандарт, зөвлөмжийн дагуу суурилуулалт хийх	Дунд	2025-2027
			Шугам хоолойн чанар, аюулгүй байдлыг сайжруулах	Дунд	2025-2030
			Хоолойн системийг тогтмол хянах, засвар үйлчилгээ хийж байх	Урт	2025-2040



№	Үүсэж болзошгүй эрсдэл	Хамаарагдах нэгж	Сөрөг хариу арга хэмжээ	Хамаарах хугацаа	Хугацаа
		боловсруулах үйлдвэрүүд			
2	Үйлдвэрээс аюултай, хортой хатуу болон шингэн материал алдагдах эрсдэл	Хог, хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу болон шингэн хог хаягдалд тогтмол үзлэг хийх, сорьц авч шинжилж байх	Урт	2025-2040
			Үйлдвэрээс гадагшлах урсгалын тоног төхөөрөмжийн найдвартай байдалд анхаарах	Урт	2025-2040
			Хог хаягдлыг бууруулах арга хэмжээ авч байх	Урт	2025-2040
Хууль эрх зүйн эрсдэл					
1	Татвар, хөнгөлөлтийн өөрчлөлттэй холбоотой үүсэх эрсдэл	Металл хийцийн үйлдвэрүүд	ҮТП, банк санхүү, татварын байгууллагуудтай олон талт хэлэлцээ хийх	Урт	2025-2040
			Гэрээ хэлцлийг чанд биелүүлэх, холбогдох тодорхой заалтууд дээр хөнгөлөлт эсвэл боломжийг тусгах	Урт	2025-2040
Нийгмийн эрсдэл					
1	Бүс нутгийн ажиллах хүчний хүртээмж, мэргэжилтний дутагдлын эрсдэл	Хог, хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүд	Бүс орон нутгийн хөдөлмөрийн биржүүдтэй хамтын ажиллагаатай байх	Дунд	2025-2027
			Шаардлагатай мэргэжилтэн сургаж авахад анхаарч ажиллах	Дунд	2025-2030
			Сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилчин, мэргэжилтэн бэлтгэн авахад анхаарах	Дунд	2025-2030
			Ажиллах хүчний амьдрах орчин, үйлдвэрийн орчныг сайжруулахад анхаарч ажиллах	Урт	2025-2040



БҮЛЭГ III. ҮТП-ИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Налайхын Үйлдвэрлэл Технологийн Паркийн үйл ажиллагаа жигдэрснээр эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг 2035 он хүртэл ямар байхыг тооцоолсон болно.

Налайх ҮТП нь Улаанбаатар хот болон Налай дүүрэг, орон нутгийн хэмжээнд олон талт нийгэм, эдийн засгийн эерэг нөлөөлөл үзүүлэх чухал дэд бүтцийн нэг хэсэг юм. Эдгээрийн гол нөлөөллийг дараах байдлаар ангилан авч үзэж болно.

Эдийн засгийн нөлөөлөл:

- ✓ Шинэ ажлын байр бий болгох: Уг парк нь барилгын материалын үйлдвэрлэлийн салбаруудыг хөгжүүлэх, инновацын шинэ технологи нэвтрүүлэх болон барилга угсралт, боловсруулах үйлдвэрлэлийн бусад компаниудыг дэмжих замаар ажлын байрыг олноор бий болно.
- ✓ Бүтээмж нэмэгдүүлэх: Барилгын материалыг дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үр ашиг өндөртэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн бүтээмж нэмэгдэнэ.
- ✓ Бизнесийн экосистемийг хөгжүүлэх: Парк нь бизнесүүдийг хооронд нь холбож, нийлүүлэлтийн гинжин хэлхээг үр ашигтай болгохоос гадна парк нь жижиг, дунд бизнесүүдэд түншлэл үүсгэх боломж олгох замаар кластераар хөгжих, орон нутагт бизнесийн экосистем бүрдүүлэхэд тусална.
- ✓ Гадаадын хөрөнгө оруулалтыг татах: Паркийн үйлдвэрлэл нь экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, импортын бүтээгдэхүүнтэй чанараар өрсөлдөх дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалт татах чухал орчин болно.
- ✓ Улс болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын бүрдүүлэлтийг хангах

Нийгмийн нөлөөлөл

- ✓ Боловсролын түвшин нэмэгдэх: Үйлдвэрлэл Технологийн Паркууд нь мэргэжлийн сургалт, судалгаа хөгжүүлэлтийг дэмжих замаар хүний нөөцийн чадварыг сайжруулна.
- ✓ Орлогын түвшин нэмэгдүүлэх: Шинэ ажлын байр, өндөр цалинтай мэргэжилтнүүдийг бий болгосноор иргэдийн амьжиргааны түвшин сайжирна.
- ✓ Орон нутгийн хөгжлийг дэмжих: Налайх ҮТП байгуулагдсанаар уг паркт хамаарах 40 үйлдвэрийн төсөлд шинээр үүсэх 10,000 ажлын байр байгаа нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, шинээр шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх зэрэг чухал ач холбогдолтой.
- ✓ Орон нутгийн дэд бүтэц: Зам, эрчим хүч, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн хөгжил эрчимжиж, иргэдийн амьдралын чанар нэмэгдэнэ.

Байгаль орчны нөлөөлөл:

- ✓ Ногоон технологийн нэвтрүүлэлт: Экологид учруулах хор хөнөөл багасгасан үйлдвэрлэлийн ногоон технологийг нэвтрүүлснээр байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг буруулах, Монгол улсын байгаль орчны стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.



- ✓ Хог хаягдлын менежмент сайжруулах: Ахуйн болон үйлдвэрийн хаягдлыг дахин боловсруулах, шинэ нөөц болгон ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Улс орны хөгжилд үзүүлэх нөлөө:

- ✓ Инновацын хөгжлийг хурдасгах: Судалгаа, хөгжүүлэлт болон технологийн шинэчлэл нь улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- ✓ Экспортын чадавхыг нэмэгдүүлэх: Дотооддоо үйлдвэрлэсэн өндөр технологийн бүтээгдэхүүнээр экспортын орлогыг өсгөнө.
- ✓ Бүс нутгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх: Төвлөрлийг сааруулах замаар бүс нутаг бүрд эдийн засгийн идэвхжил бий болгоно.
- ✓ Судалгаа, хөгжүүлэлт (R&D): Судалгааны хүрээлэн, лабораториудыг паркттай хослуулснаар дотоодын инновацыг дэмжинэ.

Налайх УТП-ийн төслийн хэрэгжилт нь тухайн бүс нутагт шууд болон шууд бусаар хамгийн түрүүнд нөлөө үзүүлнэ. Налайх УТП нь бүсийн хэмжээнд төсвийн орлого, ажил эрхлэлт, худалдан авалт зэргээр шууд нөлөө үзүүлнэ. Харин паркийн хүрээнд бүтээн байгуулагдах дэд бүтэц, авто зам, болон цахилгаан станц зэрэг нь эерэг дам нөлөөгөөр дамжин бүс нутгийн хөгжилд шууд бус нөлөөг үзүүлнэ.

Эдийн засгийн нөлөөлөл

Эдийн засгийн нөлөөлөл нь Улаанбаатар, Налайх дүүрэг болон орон нутгийн түвшинд олон өөр хүчин зүйлээс хамаарч ялгаатай мэдрэгдэнэ. Эдийн засгийн нөлөөлөл нь ихэвчлэн Улсын болон орон нутгийн төсөвт төлөх татвар, НДШ, төлбөр ба хураамж, бараа үйлчилгээний худалдан авалтаар илрэх нөлөөллүүд юм. Улаанбаатар хот болон Налайх дүүргийн төсвийн орлого, зарлага ба алдагдлын 2019-2024 оны байдлыг харах боломжтой.

Хүснэгт 3.1. Улаанбаатар ба Налайх дүүргийн төсвийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024
1	УЛААНБААТАР ХОТ						
2	Төсвийн орлого	946.5	932.6	1,175.6	1,563.0	2,142.0	3,054.5
3	Татварын орлого	854.3	752.5	1,066.6	1,431.9	1,989.8	2,817.2
4	Татварын бус орлого	92.2	180.1	109.0	131.1	151.2	237.4
5	Төсвийн зарлага	1,447.5	1,442.3	1,742.4	1,742.4	2,777.8	4,532.9
6	Төсвийн алдагдал	(500.9)	(509.7)	(566.9)	(179.4)	(635.9)	(1,478.4)
7	НАЛАЙХ ДҮҮРЭГ						
8	Төсвийн орлого	2.7	10.6	4.0	10.9	15.4	23.5
9	Татварын орлого	1.9	8.5	3.0	10.0	13.6	21.4
10	Татварын бус орлого	0.7	2.1	0.9	1.0	1.8	2.1
11	Төсвийн зарлага	22.5	25.9	25.5	16.0	19.1	27.9
12	Төсвийн алдагдал	(19.8)	(15.3)	(21.5)	(5.1)	(3.7)	(4.5)
13	Төсвийн алдагдлын эзлэх хувь (%)	(1.37)	(1.06)	(1.23)	(0.29)	(0.13)	(0.10)

Эх үүсвэр: Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал танилцуулга 2019-2024 онд

www.ubstat.mn




Хүснэгт 3. 2. Улаанбаатар хот болон Налайх дүүргийн төсвийн орлогын нөлөөлөл, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлт	Онууд			
		2025 Төс	2028 Төс	2030 Төс	2035 Төс
1	Улаанбаатар хот	3,482.1	5,158.9	6,704.5	12,003.1
2	Татварын орлого	3,203.6	4,746.2	6,168.2	10,922.8
3	Татварын бус орлого	278.5	412.7	536.3	983.1
4	Налайх дүүрэг	24.9	29.6	33.3	44.6
5	Татварын орлого	22.6	27.0	30.3	40.5
6	Татварын бус орлого	2.0	2.4	2.7	3.6

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Зураг 3. 1. Налайхын ҮТП-ийн төсвийн орлогод үзүүлэх нөлөөлөл



Шууд ба шууд бус ажлын байрны өсөлт

Налайхын ҮТП байгуулах төслийн үе шат болгоноос хамаарч, шууд ба шууд бус ажлын байрны тоо 2028 онд 771 хүн, 2030 онд 3800 хүн, 2035 онд 10,000 хүн болох тооцоо гарсан. 2024 оны эцсийн байдлаар Налайх дүүргийн ажиллах хүчний тоо 24,8 мянган хүн байгаа нь 10,0 мянган хүн буюу 40,3%-аар өсөхөөр байна.

Хүснэгт 3. 3. Шууд ба шууд бус ажлын байрны өсөлт, хүнээр, өссөн дүнгээр

№	Паркийн бүрэлдэхүүн хэсгүүд	Шинээр бий болох ажлын байр (өссөн дүнгээр)			
		2025	2028 Төс	2030 Төс	2035 Төс
1	Паркийн үйлдвэрүүд 120 га талбайд	318	771	1000	2500
2	Паркийн үйлдвэрүүд 160 га талбайд	0	0	500	1000
3	Барилгын худалдааны төв 60 га талбайд	0	0	800	2000
4	Тээвэр логистикийн төв 50 га талбайд	0	0	500	1500
5	Эмнэлэг, сургууль, татвар, банк, төрийн нэг цэгийн үйлчилгээ,	0	0	1000	3000
6	Нийт ажлын байр (хүн)	318	771	3800	10000



Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр

Улаанбаатар хот болон Төв, Хангайн бүсийн гаралтай шинэ ажилчин, ажилтнуудад төлөх цалин, ажлын хөлсний гэрээт төлбөрөөс гадна Төсөл нь орон нутгийн ханган нийлүүлэгч, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын боломжуудаар дамжуулан орон нутгийн эдийн засагт эерэг нөлөөллийг үзүүлнэ.

Бараа, үйлчилгээ үзүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн боломжуудыг бүрдүүлэх Налайх ҮТП-ийн төсөлд орон нутгийн ханган нийлүүлэгчид үзүүлэх боломжтой 108 тооны бараа, үйлчилгээ байна. Эдгээрт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (мах, ногоо, гурил, сүүн бүтээгдэхүүн, талх, өндөг), түлш, ажлын хувцас (аюулгүй ажиллагааны тоноглол), дээжийн уут болон бүтээгдэхүүн тээвэрлэх хайрцаг;

Үйлчилгээнд нь харилцаа холбоо, харуул хамгаалалт, хоол хүнс, цэвэрлэгээ, ажиллагсдын тээвэрлэлт, хүдэр тээвэрлэлт, хүнд машин механизмын засвар үйлчилгээ, хаягдал материалын устгал (батарей, дахин боловсруулсан хуванцар, төмөр), бизнес эрхлэгчдэд бизнес эхлүүлэх тал дээр үзүүлэх зөвлөх үйлчилгээ багтаж байна.

Ханган нийлүүлэгчийн гэрээнд тавигдах шаардлага, стандартуудыг тодорхой заасан байна. “Орон нутгийн ханган нийлүүлэгч” болохын тулд аж ахуйн нэгжүүд орон нутагт тодорхой хугацаанд бизнес эрхэлж, үйлчилгээ үзүүлсэн байх, харин орон нутгийн ажиллагсад нь тухайн газар нутагт тодорхой хугацаанд оршин суусан байх шаардлагатай. Төслийн үйл ажиллагааны бүх үе шатанд өсөн нэмэгдэх худалдааны үйл ажиллагаа, ажлын байр бий болох, тогтвортой орлого нэмэгдэх зэргээс үүсэх төслийн зардлаас эерэг эдийн засгийн нөлөөлөл ерөнхийдөө гарна гэсэн хүлээлт байгаа. Газарзүйн хамрах хүрээ нь орон нутгийн ажиллах хүчинд давамгайл эрх олгож байгаа тул голчлон сум, аймгийн түвшинд байх хэдий ч улсын хэмжээнд мэдрэгдэнэ. Хүлээгдэж буй нөлөөлөл нь шууд болон шууд бус, өндөр, эерэг байх болно.

Нэгтгэн дүгнэвээс, Налайх ҮТП байгуулагдсанаар Монгол Улсын эдийн засагт болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр болох нь дээрх судалгаануудаас харагдаж байна. Тухайлбал,

- ✓ ҮТП байгуулагдсанаар уг паркт хамаарах 40 үйлдвэрийн хэмжээнд нийтдээ 10,000 ажлын байр шинээр бий болж, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, улмаар амьжиргааны баталгаажих түвшин хангах боломж бүрдэнэ.
- ✓ Эдгээр үйлдвэрүүдийн ажиллах хүчний бэлтгэл, сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн зэрэг ахиулах давтан сургалт зэрэг асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэж, хүний нөөцийн чадвар дээшилнэ.
- ✓ Ажилтай, орлоготой, чадвартай ажиллагчид, ард иргэдийн амьдралын чанар сайжирна.
- ✓ Орон нутгийн дэд бүтцийн хөгжил нь амьдралын орчныг сайжруулснаар бүс нутгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх бөгөөд энэ нь төвлөрлийг сааруулах замаар бүс нутагт эдийн засгийн идэвхжил бий болгоно.
- ✓ Орон нутагт ҮТП-ийн зөөлөн дэд бүтэц болох Судалгаа, хөгжүүлэлт (R&D)-ийн төв, хүрээлэн, лабораториуд байгуулагдсанаар шинэ технологи нэвтрүүлэх инновацийн үйл ажиллагаа өрнөж, улмаар иргэдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.



- ✓ УТП-ийг дагаж хөгжих бизнесийн боломжууд хангагдаж, жижиг, дунд бизнесүүдэд түншлэл үүсгэх замаар кластераар хөгжих, орон нутагт бизнесийн экосистем бүрдүүлнэ.
- ✓ Экологид учруулах хор хөнөөл багасгасан үйлдвэрлэлийн ногоон технологийг нэвтрүүлснээр байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг буруулахаас гадна үйлдвэрийн хаягдлыг дахин боловсруулах, шинэ нөөц болгон ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Хүснэгт 3.4. Налайхын УТП-ийн нийгмийн үр нөлөөний индикаторууд

№	Нийгмийн үр нөлөөний чиглэл	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрэх түвшин (өссөн дүнгээр)	
				2025–2030	2030–2040
1	Өрхийн бодит орлого өсөх	Налайх дүүргийн өрхийн дундаж бодит орлогын өсөлт	Хувь	15%	40%
2	Ажил эрхлэлтийн боломж нэмэгдэх	УТП болон дүүргийн хэмжээнд шинээр бий болсон ажлын байр	Тоо	3,500	10,000
3	Хүний нөөцийн ур чадвар дээшлэх	Мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдсан иргэд	Хүн	2,500	6,000
4	Орон нутгийн бизнесийн идэвхжил нэмэгдэх	Орон нутгийн ханган нийлүүлэгч, үйлчилгээний ААН-ийн өсөлт	Хувь	30%	50%
5	Ажилгүйдлийн түвшин буурах	Налайх дүүргийн ажилгүйдлийн түвшний бууралт	Хувь	3–4%	7–8%
6	Хөдөлмөрийн бүтээмж өсөх	Нэг ажилтанд ногдох хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт	Хувь	20%	35%
7	Ажилчдын амьдрах орчны чанар сайжрах	Парк орчим дахь орон сууц, дэд бүтцийн хүртээмж: хотхонд хамрагдсан ажилчдын хувь	Хувь	35%	60%



БҮЛЭГ IV. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, МОНИТОРИНГ

“Налайх” УТП - ийн хөгжлийн төлөвлөгөө нь 2025-2040 онд хэрэгжинэ. Энэхүү төлөвлөгөөнд суурилан дунд хугацааны болон жил бүрийн төлөвлөгөө боловсруулагдаж, гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гаргаж явах болно. Ингэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, 2021 оны 119 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам” болон Налайх УТП-ийн хүрээнд батлагдсан дүрэм, журмууд, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам зэргийг тус тус баримтлан гүйцэтгэнэ.

Хэрэв Налайх УТП-ийн хэмжээнд хяналт, шинжилгээ, үнэлгээний холбогдолтой зохион байгуулалт болон журам гараагүй бол гүйцэтгэх захирал нь дотоод хяналтын нэгжийн бүтэц зохион байгуулалт, тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох журам, зааврыг баталж, үр дүнг дүгнэх, санал санаачилгыг дэмжин хяналтын ерөнхий чиг үүргийг тодорхойлно.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих нь дараах 3 чиглэлтэй байдаг. Үүнд:

- ✓ Төлөвлөгөөт зорилтуудын заалт бүрийн биелэлтийн байдал
- ✓ Төлөвлөгөөт хугацаа дахь гүйцэтгэлийн байдал
- ✓ Төлөвлөгөөний орон зай, хамрах хүрээний биелэлтийн байдал

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт мониторинг хийх үүднээс УТП-ийн захиргаа, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч байх, бүтэц, чиг үүргийн хуваарилалтыг хийж, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон байх ёстой. Тухайлбал, хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нэгж, хэлтсүүдийг бодлогын удирдлагаар хангаж, дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд үндэслэн дунд болон богино хугацааны бизнес төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, салбар нэгжийн хооронд үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хэрэгжүүлнэ. Эдгээр нь:

- Удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр,
- Үйлдвэрлэл, технологийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр,
- Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр,
- Санхүүгийн менежментийг боловсронгуй болгох үйл ажиллагааны хөтөлбөр,
- Нийгмийн хариуцлагын хөгжлийн хөтөлбөр.

Хөгжлийн төлөвлөгөө, түүнтэй холбогдох хөтөлбөр, төслүүдийг боловсруулах ажлыг шуурхай удирдлагаар хангаж, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүрэг, хариуцах нэгжийг байгуулахаар төлөвлөх хэрэгтэй байна.

Хөгжлийн төлөвлөгөө, холбогдох хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

- ✓ Хөгжлийн төлөвлөгөөнд дотоод хяналтыг компанийн дотоод аудитын хэлтэс, алба хэрэгжүүлэх бөгөөд хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ТУЗ-д танилцуулна. Шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.



- ✓ Паркийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ҮТП-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.
- ✓ Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн төлөвлөгөө болон шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- ✓ шударга, хараат бус байх;
- ✓ хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;
- ✓ хяналт-шинжилгээ, үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- ✓ хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;
- ✓ хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх;

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, олон нийтийн оролцоо

ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг дараах үе шатуудаар үнэлэн дүгнэх боломжтой.

- ❖ **I үе шат:** Эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2031 оны I улирал).
- ❖ **II үе шат:** Дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2036 оны I улирал).
- ❖ **III үе шат:** Эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2041 оны I улирал)

Төлөвлөгөөний хяналт шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай зардлыг ҮТП-ийн төсөвт тусган санхүүжүүлэх бөгөөд холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагууд, ажиллагчдын оролцоог зайлшгүй хангана.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд олон нийтийн хяналт оролцоог хангах дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд боловсруулж буй бодлого хөтөлбөр, төсвийн төсөлд удирдлагын баг, ажиллагчдын төлөөлөл үзэл бодол байр суурь, тэдний эрх ашгийг хөндсөн асуудалд саналыг тусгадаг механизмыг бий болгоно.
- ✓ Төлөвлөгөөний хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллага, иргэд, бизнесийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- ✓ Төрийн хяналт шинжилгээ, үнэлгээний зарим чиг үүргийг мэргэжлийн чадавх бүхий ТББ-д шилжүүлэх, тэднээр гүйцэтгүүлэх, хөндлөнгийн дүгнэлт гаргуулдаг болно.
- ✓ Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн, үйл ажиллагааны тайланг үйлдвэр, байгууллагын хамт олон, ард иргэдэд нээлттэй таниулж сурталчилна.

Төлөвлөлтийн гүйцэтгэлийн байдал, дотоод хяналт, мониторингийн ач холбогдол, хэрэгжүүлэлт

Дотоод хяналт, мониторингийн тогтолцоог компанийн үйл ажиллагаанд хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна. Үүнд:

- ✓ Дунд хугацааны болон жил бүрийн бизнес төлөвлөгөө хэрэгжсэн байна.



- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг системтэйгээр үнэлж, тогтмол хяналт тавьж, байнга сайжруулах нөхцөл бүрдэнэ.
- ✓ Байгууллагын үйлдвэрлэлийн технологийн горим, бараа бүтээгдэхүүн, ажил
- ✓ үйлчилгээний чанар, аюулгүй байдал хангагдана.
- ✓ Хэрэглэгч, худалдан авагчийн итгэлцэл дээшилж, бизнесийн нэр хүнд нь өснө.
- ✓ Нийгмийн хариуцлагатай байгууллага байж, үнэ цэнэ өсөж, зах зээлд эзлэх байр суурь бэхжиж, ашиг орлого нэмэгдэнэ.
- ✓ Мэдээллийн ил тод байдал сайжирч, шилэн компани болсон байна.

Дотоод хяналт, мониторингийн тогтолцоог паркийн хэмжээнд бүхий л зохион байгуулалтын нэгж хэсэг, болон харилцагч компани, төсөл хөтөлбөрүүд мөн гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагааг хамруулан эрсдэлд суурилсан цогц хяналтыг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэлтийг дараах чиглэлээр гүйцэтгэх ба дотоод хяналт, мониторингийн ач холбогдол үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

- ✓ Урт болон дунд хугацааны төлөвлөгөөний тулгуур бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.
- ✓ Урт болон дунд хугацааны төлөвлөгөөнд суурилан боловсруулсан богино хугацааны төлөвлөлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх.
- ✓ Хяналт-шинжилгээ үнэлгээний үр дүнд хэрэгжилт хангалтгүй байгаа төлөвлөлт, арга хэмжээнд дотоод хяналт хийж, хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөлийг илрүүлэн зөвлөмж өгөх.
- ✓ Санхүүгийн тайлагнал болон хууль тогтоомжийн нийцлийн зорилгыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох.
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ил тод байдлын журмын хэрэгжилтэд хяналт тавих.
- ✓ ҮТП-ийн нэгж, компаниудын дотоод хяналтын үйл ажиллагаа, нээлттэй ил тод байдалд хяналт тавих зэрэг болно.

“Smart Nalaikh Data Hub” системийн төлөвлөгөө

Налайхын ҮТП нь өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтын тогтолцоо нэвтрүүлэх зорилгын хүрээнд паркийн гүйцэтгэл, зах зээлийн төлөв, кластерийн уялдаа холбоог өгөгдөлд суурилан хянах цогц платформыг үйл ажиллагаандаа ашиглана. Уг системийг мэргэжлийн байгууллагаар хөгжүүлэлт хийлгэж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилго нь:

- **Нэгдсэн өгөгдлийн сан:** Үйлдвэрлэлийн KPIs, эрчим хүч/ус/хаягдал, хүний нөөц, санхүүгийн үзүүлэлтүүд, зах зээлийн foresight, кластерийн зураглалын мэдээллийг нэгтгэж шуурхай шийдвэрт ашиглана.
- **Автомат тайлагнал:** KPI-д суурилсан тайланг автоматжуулж, өгөгдөл олж цуглуулах ачааллыг багасгана. Энэ нь үйлдвэрлэлийн KPI-г бодит цагт хянах дашбоардын туршлагад суурилна; ийм дашбоард нь оператор, инженер, менежментэд өгөгдлийг нэг дор харуулах, drill-down хийх боломж олгодог.
- **Хөрөнгө оруулагчийн портал:** Нээлттэй, орчин үеийн вэб портал хөгжүүлж, гүйцэтгэл, санхүүгийн мэдээлэл, кластерийн зураглал, урамшууллын бодлого зэргийг байрлуулна. Өөрөөр хэлбэл, ил тод өгөгдөл бүхий орчин бий болгоно.



- **ESG болон эдийн засгийн тайлан:** Олон улсын ESG тайлагналын (GRI, SASB, TCFD) аргачлалыг ашиглаж, жилийн тайлан гаргана. ESG тайлангийн гол зорилго нь байгууллагын байгаль орчин, нийгэм, засаглалыг ил тод мэдээлэх бөгөөд энэ нь өсөлт, хөрөнгө оруулагчийн итгэлийг дэмждэг.
- **Стратеги, бодлогын дэмжлэг:** Системээс гарах өгөгдөл, анализ нь менежментийн зөвлөл, засаг захиргааны бодлого боловсруулахад шууд оролцоно.

“Smart Nalaikh Data Hub” систем нь дараах гол бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. (урьдчилсан байдлаар) Үүнд:

1. Өгөгдөл интеграцийн давхарга

- ERP, IoT мэдрэгч, кластерийн зураглал, зах зээлийн чиг хандлага, санхүүгийн системүүдийн өгөгдлийг стандартчилж нэгдсэн сан үүсгэнэ.
- Өгөгдлийн засаглалын бодлого баталж, чанар, нууцлал, хувийн мэдээлэл хамгаалалтыг хангана.

2. KPI-д суурилсан тайлагналын модуль

- Үндсэн KPI-уудыг сонгоно (үйлдвэрлэлийн хүчин чадал, цикл хугацаа, OEE, эрчим хүч/ус/хаягдал нэгж бүтээгдэхүүнд, CO₂ ялгаруулалт, ажлын байр зэрэг). Manufacturing KPI-ийн дашбоард нь гүйцэтгэлийн төвлөрсөн хяналт, таамаглалын анализ хийхэд чухал байдгийг судалгаа харуулж байна.
- Тайлагналын автомат хуваарь, захиалгат тайлангийн генератор хөгжүүлнэ.
- Alert engine нэвтрүүлж, үзүүлэлтүүдийн хэт хэлбэлзэл дээр сэрэмжлүүлэг илгээнэ.

3. Нээлттэй мэдээллийн портал

- Хөрөнгө оруулагч, түнш байгууллагууд, олон нийтэд зориулсан мэдээллийн суваг.
 - Кластерийн зураглал, нийлүүлэлтийн холбооснууд: кластерийн зураглал нь газрын зураг дээр аж ахуйн нэгжүүдийг дүрслэн, нийлүүлэлтийн сул холбоос, зах зээлийн дутуу нөхөгдсөн орон зайг илрүүлж хөгжлийн боломж тодорхойлдог.
 - Бодит цагийн KPI дашбоард
 - Төслийн санхүүгийн тайлан, хөрөнгө оруулалтын боломжууд.
 - Холбогдох эрх зүйн мэдээлэл, урамшууллын бодлого.
- Порталд хоёр түвшинтэй нэвтрэх (ерөнхий ба бүртгэлтэй хөрөнгө оруулагч) зохион байгуулалт хэрэгжүүлнэ.

4. ESG болон эдийн засгийн тайлагналын модуль

- Нийлүүлэгчид, оролцогч талуудын ESG өгөгдлийг авч багц хэлбэрээр хэрэглэж, жил бүрийн тайлан гаргана.
- Эдийн засгийн нөлөөллийн анализын загвар боловсруулж, парк орон нутгийн эдийн засаг, татварын орлого, ажлын байр зэрэгт хэрхэн нөлөөлж буйг тооцно.

5. Стратегийн дэмжлэгийн модуль

- Зах зээлийн тренд шинжилгээ, эрэлт-нийлүүлэлтийн прогноз, сценарийн төлөвлөлт ашиглаж ирээдүйн зах зээлийн боломж, эрсдэлийг урьдчилан харна.
- Дашбоард, кластер зураглал, анализыг нэгтгэн стратегийн хуралдаан, бодлого боловсруулахад зориулсан талбартай байна.



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Парк (НҮТП) ХК-ийн хөгжлийн төлөвлөгөө нь Монгол Улсын аж үйлдвэрлэлийн бүтцийг төрөлжүүлэх, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, инновацад суурилсан өсөлтийн хөшүүрэг бий болгох стратегийн зорилгод нийцсэн урт хугацааны нэгдсэн хөгжлийн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөө нь 2025–2040 он хүртэлх хугацаанд хэрэгжих төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан, кластер төвтэй, экспортыг дэмжсэн хөгжлийн загварыг тодорхойлж байна.

Нэг. Стратегийн зорилго, зорилт тодорхой, хэрэгжих суурь нь бүрдсэн

Төлөвлөгөө нь үндэсний хөгжлийн бодлого (Алсын хараа–2050), Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг баримт бичгүүдтэй бүрэн уялдсан стратегийн баримт бичиг бөгөөд:

- ✓ Олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий парк;
- ✓ Инновац, технологийн шинэчлэлд тулгуурласан эдийн засаг;
- ✓ Дотоодын ба бүс нутгийн зах зээлд төвлөрсөн кластер;
- ✓ Импорт орлох, экспорт нэмэгдүүлэх үйлдвэрлэл;
- ✓ Институцийн тогтвортой, ухаалаг засаглал бүхий орчныг бий болгоход чиглэсэн таван гол зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хоёр. Кластер суурьт, эдийн засгийн хөшүүрэг бүхий бүтэцтэй төлөвлөгөө

Парк нь үйлдвэрлэлийн нэгдсэн дэд бүтцийн сүлжээ, хамтын логистик, R&D болон инновацын төв, хүний нөөцийн хөгжлийн экосистем, олон улсын гэрчилгээжүүлэлтийн хүчин чадал зэрэг кластер хэлбэрийн бүтэцтэй хөгжихөөр төлөвлөгдсөн. Ингэснээр:

- ✓ Үйлдвэрлэлийн өртөг буурч, синержи бий болно;
- ✓ Хаягдалгүй үйлдвэрлэлийн симбиоз хэлбэр бүрэлдэнэ;
- ✓ Бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс зах зээл хүртэлх бүх үе шат интеграцид орно.

Гурав. Инновац, технологи дамжуулалтын тогтолцоо бүрдэнэ

“Smart Factory”, “R&D төв”, “Үйлдвэрлэл + Дижитал” платформ, оюуны өмчийн дэмжлэгийн тогтолцоо, олон улсын лабораторитой хамтын ажиллагаа зэргээр инновацын экосистемийг бүрдүүлэх цогц бүтэц тусгасан. Ингэснээр:

- ✓ TRL 6-9 түвшний технологи хөгжүүлэлт;
- ✓ Импортын хамаарлыг бууруулах үндэсний бүтээгдэхүүн бий болно;
- ✓ Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч кластер болно.

Дөрөв. Хөрөнгө оруулалт татах ба эдийн засгийн үр өгөөж өндөртэй

Төлөвлөгөөнд олон улсын хөрөнгө оруулалт, үндэсний үйлдвэрлэгчдийн хамтын бүтээн байгуулалт, концесс, төр ба хувийн хэвшлийн түншлэл (PPP), санхүүжилтийн уян хатан загварууд тусгасан. Тооцооллоор:

- ✓ 15 жилийн хугацаанд 1 их наяд төгрөг хүртэлх нийт хөрөнгө оруулалт шаардлагатай;
- ✓ 10,000 хүртэл байнгын ажлын байр бий болж, Улаанбаатар хотын төвлөрөл буурна;
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортын өсөлт, валютын орох урсгал нэмэгдэнэ.



Тав. Тогтвортой хөгжлийн зарчим, нийгмийн хариуцлагыг төвд байршуулсан

Налайхын үйлдвэрлэл технологийн парк нь “ногоон хөгжил”, “байгальд ээлтэй үйлдвэрлэл”, “эрчим хүчний үр ашиг”, “нийгмийн хариуцлагатай хамт олон” зэрэг зарчмыг баримтална. Энэ нь зөвхөн эдийн засгийн төдийгүй нийгэм, байгаль орчны үр нөлөөтэй хөгжлийн загвар гэдгийг харуулж байна.

Налайхын ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөө нь Монгол Улсад анх удаа инновац, кластер, экспорт, дижитал үйлдвэрлэл, тогтвортой хөгжил зэргийг хослуулсан системтэй, урт хугацааны, бодит хэрэгжих боломжтой хөгжлийн загварыг дэвшүүлж байна. Энэхүү төлөвлөгөө амжилттай хэрэгжсэн тохиолдолд Налайхын ҮТП нь:

- ✓ Үндэсний үйлдвэрлэлийн шинэ үеийн хөдөлгүүр;
- ✓ Бүс нутгийн технологи-эдийн засгийн төв;
- ✓ Монгол Улсын барилгын материалын инновац, экспортлогч цогцолбор болон төлөвших бүрэн боломжтой юм.

Иймд энэхүү төлөвлөгөөг нэгдмэл бодлого, санхүүжилтийн дэмжлэг, олон талт оролцоонд тулгуурлан үе шаттай, хариуцлагатай хэрэгжүүлэх шаардлагатай байна.